

International Accounting Education Standards Board™

Нягтлан Бодох Бртгэлийн
Боловсролын Олон Улсын
Тунхаглалын Гарын Авлага

2017 оны Хэвлэл

IES™

ӨМНӨХ ҮГ

Та бүхэндээ Дэлхийн нягтлан бодогчдын холбоо (ДНБХ)-ны Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартын зөвлөл (НБББОУСЗ)-өөс батлан гаргасан Боловсролын олон улсын стандарт (БОУС)-ыг эх хэл дээрээ хүргэж байгаадаа баяртай байна. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (ММНБИ) нь анх 2009 оны гарын авлагыг 2010 онд эх хэлнээ хөрвүүлэн хүргэж байсан бол энэ удаа уг стандартын 2017 оны хэвлэлийг орчуулан гаргалаа.

НБББОУСЗ нь эрхэм зорилгоо “Боловсролыг хөгжүүлэн түгээх замаар дэлхий даяар нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагыг бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх явдал юм” гэж толдорхойлсон. Энэ зорилгынхоо хүрээнд мэргэжлийн зэрэг олгох, мэргэжлийн нягтлан бодогчдын сургалт, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагын гишүүдийн тасралтгүй боловсрол ба хөгжилд зориулан тус стандарт болон боловсролын олон улсын практик тайлбар зэрэг баримт бичгүүдийг гаргадаг.

Энэ стандарт нь нийтлэг хандлага, зарчмыг агуулсан байдаг тул манай улсын боловсролын асуудал эрхэлсэн яам, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагууд өөрийн бодлого, чиглэл, үйл ажиллагааны болон сургалтын хөтөлбөрөө харьцуулах боломжтой юм.

ММНБИ нь ДНБХ-ны гишүүний хувьд тус холбооноос гаргасан стандарт болон бусад баримт бичгүүдийг гишүүд, дэмжигчиддээ хүргэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил олгож байгаа их, дээд сургуулиуд, мөн мэргэшүүлж байгаа мэргэжлийн байгууллагууд ч өөрсдийн боловсролын хөтөлбөр, сургалтаа уг стандартад нийцүүлэхийг зөвлөдөг.

НБББОУС–тай холбоотой санал, хүсэлтээ ММНБИ-ийн и-мэйл хаяг (info@monicpa.mn) болон 70111870 дугаарын утсаар холбогдож ирүүлнэ үү.

Д.НАЦАГДОРЖ

ММНБИ-ийн гүйцэтгэх захирал

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТУНХАГЛАЛ АГУУЛГА

Хуудас

Гарын Авлагын 2015 оны Хэвлэлд Оруулсан Томоохон Өөрчлөлтүүд болон Сүүлийн Үед Хийсэн Сайжруулалтууд.....	1
НБББОУСЗ-ийн Танилцуулга.....	3
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны Үүрэг.....	4
БОЛОВСРОЛЫН ТУНХАГЛАЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ	
Мэргэжлийн Нягтлан Бодогчид болон Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал (2015).....	5
НББОУСЗ-өөс гаргасан Нэр Томъёоны Тайлбар (2015).....	19
БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД	
Оршил.....	24
БОУС 1, Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрт Тавигдах Элсэлтийн Шаардлага (2014).....	25
БОУС 2, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт – Техникийн Чадавх (2015).....	32
БОУС 3, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Ур Чадвар (2015).....	43
БОУС 4, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлага (2015).....	53
БОУС 5, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Практик Туршлага (2015).....	68
БОУС 6, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ (2015).....	78
БОУС 7, Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (2014).....	87
БОУС 8, Санхүүгийн Тайлангийн Аудит Хариуцсан Гэрээт Ажлын Партнерын Мэргэжлийн Чадавх (2016).....	98

ГАРЫН АВЛАГЫН 2015 ОНЫ ХЭВЛЭЛД ОРУУЛСАН ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТҮҮД БОЛОН СҮҮЛИЙН ҮЕД ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТУУД

Энэхүү гарын авлага нь *Боловсролын Олон Улсын Стандартын Тунхаглалын Гарын Авлага*-ын 2015 оны хэвлэлийг орлоно. Энэхүү гарын авлагад үндсэн агуулга болон тодорхойлолтыг толилуулах замаар Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС)-ыг дэмжинэ. Илүү тодруулбал, уг гарын авлагад *Мэргэжлийн Нягтлан Бодогчид ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал* (Үзэл Баримтлал 2015), *НББОУСЗ-өөс гаргасан Нэр Томьёоны Тайлбар* (Нэр Томьёоны Тайлбар 2015), мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэх болон мэргэжлийн нягтлан бодогчид зориулсан Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн талаарх БОУС 1-6, мөн мэргэжлийн нягтлан бодогчид болон гэрээт ажлын партнеруудад зориулсан МТХ-ийн талаарх БОУС 7: *Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил* (2014), БОУС 8: *Санхүүгийн Тайлангийн Аудит Хариуцсан Гэрээт Ажлын Партнерын Мэргэжлийн Чадавх* (2016)-ыг тус тус багтаасан.

НББОУСЗ-өөс Үзэл Баримтлал (2015), Нэр Томьёоны Тайлбар (2015) болон 8 багц БОУС-уудыг 2015 оны сүүлийн болон 2016 оны эхний улиралд хянан засварласан. Энэхүү хяналтыг зөвхөн засвар өөрчлөлтүүд гэж үзэх бөгөөд дараах байдлаар хязгаарлагдсан: (i) цэвэр нэр томьёоны өөрчлөлт, хэл зүйн асуудлууд, хэвлэлийн засвар, эсвэл бусад засвар оруулахтай холбоотой асуудлууд; мөн (ii) БОУС-ын зохион байгуулалтын хувьд болон Үзэл Баримтлал (2015), Нэр Томьёоны Тайлбар (2015) ба багц БОУС-уудын хоорондох зохицол, тодорхой, үнэн зөв байдлыг сайжруулахад шаардлагатай засвар өөрчлөлтүүд. Үүний эсрэгээр, стандартын агуулга болон бүтцийн аливаа томоохон өөрчлөлтүүд болон стандартыг хэрэглэгчдэд материаллаг нөлөө үзүүлэхүйц аливаа өөрчлөлтийг уг хянан засварлалтад хамруулаагүй бөгөөд хэрвээ шаардлагатай бол эдгээр өөрчлөлтийг НББОУСЗ-ийн тусдаа стандартын төслийн хүрээнд авч үзэж болно. Эдгээр өөрчлөлтийн төслийг 90 хоногийн турш олон нийтэд танилцуулж хэлэлцүүлсэн бөгөөд эдгээр баримт бичгийг эцэслэхдээ НББОУСЗ-өөс ирсэн хариу саналуудад дүн шинжилгээ хийж, нарийвчлан авч хэлэлцсэн. Үзэл Баримтлал (2015), Нэр Томьёоны Тайлбар (2015), 8 багц БОУС-уудад оруулж баталсан өөрчлөлтүүдийг энд багтаасан болно. Бүх засвар өөрчлөлтүүдийг гарын авлагын 2017 оны хэвлэлд тусгасан.

Энэхүү гарын авлагад гурван Боловсролын Олон Улсын Практик Тунхаглал (БОУПТ)-ыг оруулаагүй бөгөөд учир нь эдгээр тунхаглал нь одоогийн хүчин төгөлдөр БОУС-уудад ашигласан ойлголт, нэр томьёонуудтай сайтар уялдаагүйтэй холбоотой. НББОУСЗ нь БОУПТ-ыг одоогийн хүчин төгөлдөр БОУС-уудтай уялдуулах үүднээс хянан засварлах эсвэл БОУПТ-ыг үүрэгжүүлээгүй зөвлөмж материалаар орлуулах эсэхийг ажлын төлөвлөгөөнийхөө явцад шийдвэрлэнэ.

Хэрэгжилтийг Дэмжих нь

НББОУСЗ нь одоогийн хүчин төгөлдөр БОУС-уудын нэвтрүүлэлт, хэрэгжилтийг дэмжихээр ажиллаж байна. Зөвлөмж өгөх төслүүд нь сургалтын үр дүнд чиглэсэн хандлагын хэрэгжилтийг дэмжих материалуудыг боловсруулах болон БОУС 1 ба 8-ыг багтаана.

Сургалтын Үр Дүнд Чиглэсэн Хандлага

МАШХ-ийн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрүүд, МТХ-ийн хөтөлбөрүүд болон практик туршлагаар дамжуулан мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх ажлыг хариуцагчдын ашигладаг сургалтын үр дүнд чиглэсэн хандлагын хэрэгжилтийг дэмжих иж бүрэн зөвлөмж материалыг НББОУСЗ-өөс боловсруулсан.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрт Элсэх нь

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Байгууллагуудад мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд хувь хүний амжилт, уналтад нөлөөлөх олон янзын хүчин зүйлсийг ойлгоход нь туслах материалуудыг багтаасан БОУС 1: Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрт Тавигдах Элсэлтийн Шаардлага (2014)-ын

хэрэгжилтийг дэмжих иж бүрэн зөвлөмж материалыг НБББОУСЗ-өөс боловруулсан.

Гэрээт Ажлын Партнерын Мэргэжлийн Чадавх

Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн байгууллагууд, нийтэд үйлчилдэг аудитын компаниуд, гэрээт ажлын партнеруудын хувьд БОУС 8: *Санхүүгийн Тайлангийн Аудит Хариуцсан Гэрээт Ажлын Партнерын Мэргэжлийн Чадавх* (2016)-ыг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй асуултууд болон асуудлуудын талаар Асуулт, Хариулттай нийтлэл болон цахим цуврал нэвтрүүлгийг НБББОУСЗ-өөс бэлтгэж гаргасан.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

НБББОУСЗ нь ДНБХ-ны гишүүн байгууллагууд болон их дээд сургуулиуд, боловсролын байгууллагууд, ажил олгогчид, зохицуулагч байгууллагууд, засгийн газрын эрх бүхий байгууллагууд, нягтлан бодогчид болон нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид зэрэг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын чиглэлийн бусад сонирхогч талуудад зориулан боловсролын стандартууд, хэрэгжилтийг дэмжих материалууд болон хэрэглээний зөвлөмжийг боловсруулдаг бие даасан стандарт тогтоогч байгууллага юм. НБББОУСЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавидаг Олон Нийтийн Ашиг Сонирхлын Хяналтын Зөвлөл (ОНАСХЗ) болон олон нийтийн ашиг сонирхлын чиглэлээр зөвлөмж гаргадаг НБББОУСЗ-ийн Зөвлөх Бүлгийн хамтарсан стандарт тогтоох үйл явцын хүрээнд НБББОУСЗ нь өөрийн стандарт, зөвлөмжийг боловсруулдаг. ДНБХ нь НБББОУСЗ-ийг санхүү, үйл ажиллагаа болон зохион байгуулалтын хувьд дэмжиж ажилладаг. Энэхүү зохицуулалт нь НБББОУСЗ-д үйлчилдэг өндөр ур чадвартай сайн дурын ажилтнуудыг зөвхөн стандарт тогтоох үйл ажиллагаанд анхаарал хандуулах боломжийг олгодог.

НБББОУСЗ-ийн зорилго нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид болон мэргэжлийн нягтлан бодогчдын чадавхыг сайжруулах чиглэлээр өндөр чанартай боловсролын олон улсын стандартыг боловсруулан мөрдүүлж, улмаар дэлхий даяар нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг бэхжүүлэн, олон нийтийн итгэлийг улам бүр нэмэгдүүлэх замаар олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчлэхэд оршино.

НБББОУСЗ нь 18-аас илүүгүй гишүүнтэй байна. НБББОУСЗ-ийн гишүүдийн тоог тодорхойлохдоо төлөвлөж буй стандарт боловсруулах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт олон төрлийн авьяас чадварууд болон нөөц чадавхын талаар харгалзаж үздэг. НБББОУСЗ-ийн гишүүдийн тоог Нэр дэвшүүлэх хорооны зөвлөмжид үндэслэн ДНБХ-ны Зөвлөлийн дэмжлэгтэйгээр ОНАСХЗ-өөс баталдаг.

НБББОУСЗ-ийн гишүүд тэр дундаа Дарга, Дэд Даргын томилгоог Нэр дэвшүүлэх хорооны зөвлөмжид үндэслэн ДНБХ-ны Зөвлөлийн дэмжлэгтэйгээр Олон Нийтийн Ашиг Сонирхлын Хяналтын Зөвлөл (ОНАСХЗ)-өөс баталгаажуулдаг.

НБББОУСЗ нь мэргэжлийн болон мэргэжлийн бус гишүүдээс¹ бүрдэх бөгөөд үүнд хагас нь буюу 9-өөс ихгүй мэргэжлийн гишүүд болон 3-аас доошгүй олон нийтийг төлөөлсөн гишүүд байна. Олон нийтийг төлөөлсөн гишүүн гэж мэргэжлийн бус гишүүний шаардлагуудыг хангасан хувь хүнийг хэлэх бөгөөд тухайн хувь хүн нь олон нийтийн ашиг сонирхлын төлөө илүү өргөн хүрээнд ажиллах үүрэг хүлээнэ. Зөвлөлийн бүх гишүүдийг олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, НБББОУСЗ-ийн гишүүний хувьд өөрсдийн үүргийг шударгаар биелүүлэхээ илэрхийлсэн мэдэгдэлд жил бүр гарын үсэг зурахыг шаарддаг.

НБББОУСЗ нь стандартуудыг бие даан боловсруулахдаа өөрийн үйл ажиллагааг ил тод байлгаж, ОНАСХЗ-өөс баталсан зохих горимыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Зөвлөлийн хурал, тэр дундаа теле хуралдааныг олон нийтэд нээлттэй явуулдаг бөгөөд хэлэлцэх асуудлуудын талаар www.iaesb.org/meetings хаягаас үзэж болно.

НБББОУСЗ-ийн тунхаглал болон үйл ажиллагааны талаарх нэмэлт мэдээллийг www.iaesb.org цахим хуудаснаас үзнэ үү.

¹ Мэргэжлийн бус гишүүн гэж аудитын үйлчилгээ үзүүлдэг компанийн ажилтан эсвэл гишүүн биш хувь хүнийг хэлэх бөгөөд ийм компанийн ажилтан, гишүүн байсан хувь хүмүүсийн хувьд ерөнхийдөө 3 жилийн хугацаанд энэ чиглэлээр ажиллаагүй байхыг шаарддаг.

ДЭЛХИЙН НЯГТЛАН БОДОГЧДЫН ХОЛБООНЫ ҮҮРЭГ

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) нь хүчирхэг, тогтвортой байгууллага, зах зээл болон эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах замаар олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчилдэг. ДНБХ нь санхүүгийн тайлагналыг ил тод, хариуцлагатай, харьцуулагдахуйц байхыг дэмждэг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэхэд туслхаас гадна дэлхийн санхүүгийн дэд бүтэц дэх нягтлан бодогчдын ач холбогдол болон үнэ цэнийг илтгэж таниулдаг. ДНБХ нь 1977 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд одоогоор 130 гаруй улс орон, бүс нутгийн 175 гаруй гишүүд, хамтран ажиллагсадтайгаар олон нийтийн практик, боловсрол, засгийн газрын үйлчилгээ, аж үйлдвэр болон худалдааны чиглэлээр ажиллаж буй 3 сая орчим нягтлан бодогчдыг төлөөлж байна.

Олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчлэх бүрэн эрхийнхээ хүрээнд ДНБХ нь гол төлөв Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандарт Зөвлөл (НБББОУСЗ)-ийн дэмжлэгтэйгээр өндөр чанартай боловсролын олон улсын стандартыг боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. ДНБХ нь уг бие даасан стандарт тогтоогч зөвлөлийг хүний нөөцөөр ханган, материаллаг баазыг удирдаж, харилцаа холбооны дэмжлэг үзүүлж, санхүүжилт олгодог бөгөөд зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгох үйл явцыг хөнгөвчилдөг.

НБББОУСЗ нь зохих горимын дагуу ДНБХ-ны оролцоогүйгээр өөрсдөө хөтөлбөрөө боловсруулж, хэвлэл нийтлэлээ баталж гаргадаг. ДНБХ-ноос эдгээр хөтөлбөр болон хэвлэл нийтлэлд ямар ч нөлөөлөх эрх байдаггүй. ДНБХ нь гарын авлага, стандартууд болон бусад хэвлэл нийтлэлийг гаргадаг бөгөөд зохиогчийн эрхийг нь эзэмшдэг.

НБББОУСЗ-ийн бие даасан байдлыг олон төрлийн арга замаар хамгаална. Үүнд:

- ОНАСХЗ-ийн стандарт тогтоох үйл явцад албан ёсны хараат бус олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн хяналтыг тавих (дэлгэрэнгүй мэдээллийг www.iprob.org хуудаснаас үзнэ үү), үүнд олон нийтийн зөвлөгөөнийг хамарсан хатуу чанд зохих горимыг багтаана;
- Нэр дэвшүүлэх ажиллагааг олон нийтэд ил тодоор явуулж, ОНАСХЗ-өөс нэр дэвшүүлэх/сонгох үйл явцад албан ёсны хараат бус хяналт тавих;
- Стандарт тогтоох зохих горим болон хэлэлцэх материалууд, уулзалтууд болон эцэслэсэн стандарт тус бүрийн нийтлэгдсэн дүгнэлтийн үндэслэлийг олон нийтэд ил тод болгох зэргээр ил тод байдлыг бүрэн хэмжээгээр бий болгох;
- Стандарт тогтоох үйл явцад Зөвлөл Бүлэг болон ажиглагчдыг оролцуулах; болон
- НБББОУСЗ-ийн гишүүд болон нэр дэвшүүлэгч/ажил олгогч байгууллагуудыг зөвлөлийн бие даасан, бүрэн бүтэн байдал болон олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх эрхэм зорилгын төлөө ажиллахыг шаардах.

Нэмэлт мэдээллийг ДНБХ-ны цахим хуудас www.ifac.org хаягаас үзнэ үү.

**МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД БА МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН
БОДОГЧ БОЛОХЫГ ЭРМЭЛЗЭГЧДЭД ЗОРИУЛСАН БОЛОВСРОЛЫН
ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ (2015)**

АГУУЛГА

	Параграф
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ - ОРШИЛ, ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	
Оршил	1-7
Үзэл Баримтлалын Зорилго.....	8-10
Үзэл Баримтлалын Цар хүрээ.....	11-16
ХОЁРДУГААР БҮЛЭГ - БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТУУД	
Мэргэжлийн Чадавх.....	17-18
Сургалтын Үр Дүн, Чадавхын Цар Хүрээ ба Ур Чадварын Түвшин.....	19-23
Сургалт ба Хөгжүүлэлт.....	24-26
Ерөнхий Боловсрол.....	27-29
Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт.....	30-33
Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил.....	34-37
Үнэлгээ, Хэмжилт ба Мониторинг.....	38-42
ГУРАВДУГААР БҮЛЭГ – НБББОУСЗ-ӨӨС ГАРГАСАН ХЭВЛЭЛ НИЙТЛЭЛ	
Боловсролын Олон Улсын Стандарт.....	43-47
НБББОУСЗ-өөс Гаргасан Бусад Хэвлэл Нийтлэл.....	48
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ - ДНБХ-НЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	
БОУС-тай Холбоотой ДНБХ-ны Гишүүдийн Үүрэг Хариуцлага	49-50
ХАВСРАЛТ 1: УР ЧАДВАРЫН ТҮВШНИЙ ТОДОРХОЙЛОЛТ	
ХАВСРАЛТ 2: НБББОУСЗ-ИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ	

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ – ОРШИЛ, ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

Оршил

1. Энэхүү *Мэргэжлийн Нягтлан Бодогчид ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал* (“Үзэл Баримтлал”) нь Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-ийн хэвлэл нийтлэлдээ ашигладаг ойлголтуудыг тодорхойлно. Мөн уг Үзэл Баримтлалд НБББОУСЗ-өөс гаргасан хэвлэл нийтлэлүүд болон Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (“ДНБХ”)–ны гишүүн байгууллагуудын холбогдох үүрэг хариуцлагыг танилцуулсан болно.
2. НБББОУСЗ нь оролцогч талуудын мэргэжлийн нягтлан бодогчдын ажилд итгэх итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг.
3. НБББОУСЗ-ийн эрхэм зорилго нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролыг хөгжүүлж, сайжруулах замаар дэлхий даяар нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг бэхжүүлэн олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчлэх явдал юм. НБББОУСЗ нь Боловсролын Олон Улсын Стандарт (“БОУС”)–ыг боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх замаар өөрийн эрхэм зорилгодоо хүрэхийг эрмэлздэг. БОУС нь дараах чиглэлээр тодорхой шаардлагууд тогтоох замаар дэлхий даяар мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын чанарыг дээшлүүлдэг:
 - Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэж орох;
 - Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулсан Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (“МАШХ”);
 - Мэргэжлийн нягтлан бодогчдод зориулсан Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (“МТХ”).
4. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд дараах зүйлсийг хамруулах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:
 - Үнэн зөв илэрхийлсэн холбогдох санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бэлтгэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах;
 - Шийдвэр гаргах болон байгууллагын стратегийг боловсруулж хэрэгжүүлэхэд оролцох;
 - Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэлд аудит хийх, мөн бусад баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
 - Холбогдох татварын мэдээллийг бэлтгэж, дүн шинжилгээ хийх.
5. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил нь өргөн хүрээг хамарсан дараах шийдвэр гаргагчдын санхүүгийн болон зарим тохиолдолд санхүүгийн бус мэдээллийн хэрэгцээг хангах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй: (а) олон нийт, (б) одоогийн болон ирээдүйн боломжит хөрөнгө оруулагчид, (в) байгууллагын удирдлага болон ажилтнууд, (г) ханган нийлүүлэгчид болон зээлдүүлэгчид, (д) харилцагчид, болон (е) засгийн газрын эрх бүхий байгууллагууд. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн чадамжийн хүрээнд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах замаар нийгэмд үнэ цэнийг бий болгох үр ашигтай эдийн засгийг дэмждэг.
6. БОУС-ыг боловсруулан, нэвтрүүлж, хэрэгжүүлснээр мэргэжлийн чадавхыг хөгжүүлэхэд үр дүнтэй арга замыг бий болгодог. Бусад ашиг тустай үр дүнгээс дурдвал:
 - Мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд тавигддаг шаардлагуудын хоорондох олон улсын ялгааг бууруулах;
 - Мэргэжлийн нягтлан бодогчдыг дэлхий даяар шилжин ажиллахыг дэмжих;

- Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын сайн жишиг практикийг тодорхойлох.
7. Нягтлан бодох бүртгэлийн боловсролд ашиглагдаж буй нэр томъёо нь нийтлэг нэг утгатай байдаггүй бөгөөд ижил нэр томъёог янз бүрийн бүс нутагт өөр утга агуулгаар ашигладаг байх боломжтой. Үзэл Баримтлал болон БОУС-д ашигласан үндсэн нэр томъёоны тодорхойлолт, тайлбаруудыг *НБББОУСЗ-өөс гаргасан Нэр Томъёоны Тайлбарт* тусгасан.

Үзэл Баримтлалын Зорилго

8. Энэхүү Үзэл Баримтлал нь НБББОУСЗ-ийн хувьд БОУС-ыг нэвтрүүлж хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хөгжүүлж, дэмжих үндсэн суурийг бий болгодог. Уг Үзэл Баримтлал нь мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг сургаж, хөгжүүлэхэд чиглэсэн ДНБХ-ны гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг дэмждэг.
9. Уг Үзэл Баримтлал нь мөн мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг суралцаж, хөгжихийг дэмждэг бусад оролцогч талуудад ач холбогдолтой юм. Эдгээр бусад оролцогч талуудаас дурдвал:
- Мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хүргэх, үнэлэхэд оролцдог их дээд сургуулиуд, ажил олгогчид болон бусад оролцогч талууд;
 - Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хяналт тавих үүрэгтэй зохицуулагч байгууллагууд;
 - Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролтой холбоотой хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагуудыг хариуцдаг засгийн газрын эрх бүхий байгууллагууд;
 - Өөрсдийн сургалт, хөгжлийг хариуцдаг мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид;
 - НБББОУСЗ-ийн ажил үүрэг болон түүний мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын чиглэлээр хэвлэл нийтлэл боловсруулах арга барилыг сонирхдог бусад аливаа оролцогч талууд.
10. Энэхүү Үзэл Баримтлалын үр ашгийг дурдвал:
- НБББОУСЗ-ийн хэвлэл нийтлэлийн үндэс суурийг бий болгох замаар стандарт тогтоох үйл явцыг үр дүнтэй, ашиг тустай болгоно;
 - БОУС-ууд нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролтой холбоотой нийтлэг ойлголтуудад суурилдаг учраас өөр хоорондоо нийцтэй байна;
 - НБББОУСЗ-ийн шийдвэрийн үндэс суурь болсон ойлголтууд нь Үзэл Баримтлалд багтсан байдаг учир НБББОУСЗ-ийн шийдвэрүүд илүү ил тод, хариуцлагатай болно.

Үзэл Баримтлалын Хамрах Хүрээ

11. Энэхүү Үзэл Баримтлал нь БОУС-уудын үндэс болсон сургалтын ойлголтуудыг тодорхойлсон боловч уг Үзэл Баримтлалаар ДНБХ-ны гишүүн байгууллагуудад тавигдах шаардлагуудыг тогтоохгүй юм. НБББОУСЗ нь БОУС-ыг боловсруулахдаа энэхүү Үзэл Баримтлалд тодорхойлсон ойлголтуудыг ашигладаг. Мөн уг Үзэл Баримтлалд тусгасан ойлголтуудыг аль нэг БОУС-д тусгайлан дурдаагүй мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын бусад асуудалд ашиглах боломжтой.
12. БОУС болон НБББОУСЗ-ийн бусад хэвлэл нийтлэлийн зорилгоор НБББОУСЗ-өөс мэргэжлийн нягтлан бодогч гэж нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадавхыг эзэмшиж, илтгэн харуулж, цааш

хөгжүүлдэг, мөн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн байгууллага болон эрх олгогч байгууллагаас гаргасан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх ёстой хувь хүн хэмээн тодорхойлсон.

13. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн байгууллагуудад ДНБХ-ны гишүүн байгууллагууд багтах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн байгууллага эсвэл эрх олгогч байгууллага нь ДНБХ-ны гишүүн биш тохиолдолд БОУС-ыг олон улсын сайн жишиг практик болгож авч үзнэ.
14. Ёс зүйн дүрэм нь мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн зарчмуудыг тогтоодог. Ёс зүйн дүрэм нь ерөнхийдөө *Нягтлан Бодогчдын Олон Улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм* (“НБОУЁЗСЗ-ийн Дүрэм”)-ээс бүрдэх бөгөөд ингэхдээ түүнийг бүхэлд нь эсвэл НБОУЁЗСЗ-ийн Дүрэмд тусгасан стандартуудаас хатуудуулахгүйгээр дотооддоо боловсруулсан ёс зүйн дүрмийн үндэс суурь болгож ашигладаг.
15. НБББОУСЗ-өөс мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч гэж МАШХ-ийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлсэн хувь хүн хэмээн тодорхойлсон.
16. НБББОУСЗ-өөс нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр мэргэжлийн нягтлан бодогчдын өргөнөөр хийж гүйцэтгэдэг эсвэл олон нийтийн ашиг сонирхлын төлөө чиглэсэн ажил үүрэгт тавигдах шаардлагуудыг тодорхойлдог.

ХОЁРДУГААР БҮЛЭГ – БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТУУД

Мэргэжлийн Чадавх

17. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын ерөнхий зорилго нь (а) мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх, болон (б) мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалах явдал юм.
18. Мэргэжлийн чадавх гэдэг нь ажил үүргийг тогтоосон стандартын дагуу гүйцэтгэх чадвар юм. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандарт, үзэл баримтлал, баримт нотолгоо, үйл явцын талаарх мэдлэгээс илүү давсан ойлголт бөгөөд энэ нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага зэргийг хослуулан ашиглахыг хэлнэ.

Сургалтын Үр Дүн, Чадавхын Цар Хүрээ ба Ур Чадварын Түвшин

19. Тодорхой чадавхын хүрээ тус бүрийн хувьд шаардлагатай мэдлэг, ойлголт, хэрэглээний гүнзгийрүүлсэн агуулгыг тодорхойлсон сургалтын үр дүнгийн талаар хэд хэдэн БОУС-д тусгасан. Сургалтын үр дүнг ажлын орчин эсвэл мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээнд авч үздэг.
20. Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ажиллаж буй мэргэжлийн нягтлан бодогчийн техникийн чадавхын сургалтын үр дүнгийн жишээ гэвэл “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) эсвэл холбогдох бусад стандартын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан зэрэг санхүүгийн тайлангуудыг бэлтгэх” явдал юм. Энэхүү сургалтын үр дүнд хүрэхийн тулд СТОУС-ын талаарх мэдлэг, тухайн нөхцөл байдалтай холбоотой эсэхийг үнэлэх чадвар болон холбогдох СТОУС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх чадварууд шаардлагатай.
21. Холбогдох цогц сургалтын үр дүнг тодорхойлсон ангиллууд болох чадавхын цар хүрээг БОУС-д тусгасан. Жишээ нь: *Санхүүгийн нягтлан бодох бүртгэл ба тайлагнал, Удирдлагын нягтлан бодох бүртгэл.*
22. МАШХ-ийн хүрээнд холбогдох сургалтын үр дүнд хүрэхээр зорьж буй агуулгыг илтгэсэн ур чадварын түвшинг чадавхын цар хүрээ тус бүрийн хувьд тогтоосон байдаг. Чадавхын цар хүрээнд харгалзах ур чадварын түвшинг тогтоохдоо ажлын орчны ойлгомжгүй, төвөгтэй, тодорхойгүй байдлыг харгалзаж үздэг. Хавсралт 1-д ур чадварын суурь, дунд, ахисан түвшний талаар дэлгэрэнгүй авч үзсэн болно. Эдгээр түвшин нь мэргэжлийн нягтлан бодогч карьерынхаа туршид мэргэжлийн чадавхаа хөгжүүлэхэд гардаг нийтлэг ахиц дэвшлийг харуулдаг. МАШХ-ийн эцэст эзэмшсэн байвал зохих чадавхын цар хүрээнд харгалзах ур чадварын түвшинг БОУС-д тодорхойлсон.
23. ДНБХ-ны гишүүн байгууллага нь (а) нэмэлт чадавхын цар хүрээг оруулах; (б) чадавхын цар хүрээнд харгалзах ур чадварын түвшинг нэмэгдүүлэх; эсвэл (в) нэмэлт сургалтын үр дүнг боловсруулж болно. Жишээ нь, ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодогчид эсвэл мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг тодорхой ажил үүргийг гүйцэтгэх эсвэл тодорхой аж үйлдвэрийн салбарт ажиллахад нь бэлтгэх үед эдгээр өөрчлөлтийг оруулах шаардлага гарч болно.

Сургалт ба Хөгжүүлэлт

24. Сургалт ба хөгжүүлэлт гэж мэргэжлийн нягтлан бодогч карьерынхаа туршид мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалах байнгын үйл явцыг хэлнэ. НБББОУСЗ-өөс сургалт ба хөгжүүлэлтийн үндсэн төрлүүдийг дараах байдлаар тодорхойлсон:

*Боловсрол*¹

¹ НБББОУСЗ нь “боловсрол” гэдэг нэр томъёог өөрсдийн нэр болон хэвлэл нийтлэлд ашигладаг боловч уг нэр томъёоны тодорхойлолтоор сургалт ба хөгжүүлэлтийн бүхий л үйл явцыг хамруулдаг.

Боловсрол гэдэг нь мэдлэг, ур чадвар болон бусад чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой зохион байгуулалт бүхий системтэй үйл явц бөгөөд академик орчинд ерөнхийдөө явагддаг боловч заавал тийм байх албагүй үйл явц юм.

Сургалт

Сургалт гэж боловсрол болон практик туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хэлнэ. Сургалтаар практик хэрэглээг онцлон авч үздэг бөгөөд ихэвчлэн ажлын байранд эсвэл зохиомол ажлын орчинд явагддаг.

Практик Туршлага

Практик туршлага гэж мэргэжлийн чадавхыг хөгжүүлэхтэй холбоотой ажлын байран дээрх болон бусад арга хэмжээг хэлнэ.

25. Суралцаж хөгжих үйл ажиллагаанд боловсрол, сургалт болон практик туршлагаас гадна (а) дасгалжуулах, (б) танилын хүрээгээ тэлэх, (в) зөвлөгөө өгөх, (г) ажиглалт хийх, (д) эргэцүүлэх, (е) өөрт чиглэсэн тодорхой зохион байгуулалтгүй мэдлэг олж авах зэрэг албан бус сургалтыг хамруулж болно.
26. Сургалт ба хөгжүүлэлтийн ялгаатай төрлүүдийн ашиглагдах цар хүрээ янз бүр байж болно. Жишээ нь, МАШХ-ийн эхний үе шатуудад сургалт, хөгжүүлэлтийн сүүлийн үе шатуудтай харьцуулахад мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол зэрэг боловсролын асуудалд илүү анхаарч болно. МТХ-ийн явцад практик туршлага болон сургалтаар дамжуулан сургалт, хөгжүүлэлтэд илүү их ач холбогдол өгч болно.

Ерөнхий Боловсрол

27. Ерөнхий боловсролоор (а) суурь мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлж, (б) мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт хувь хүнийг элсэж орохоор бэлтгэхэд нь тусалж, мөн (в) насан туршийн сургалт, хөгжлийг дэмждэг.
28. Ерөнхий боловсрол нь мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хүрээнд эзэмшсэн техникийн чадавх, мэргэжлийн ур чадвар болон мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хослуулж ашиглахад тусалдаг. Энэ нь шийдвэр гаргах ур чадвар, үнэлэмж болон үл итгэх үзлийг хөгжүүлэхэд дэмжлэг болдог. Ерөнхий боловсролын сэдвүүдийн жишээ гэвэл (а) түүхэн үзэл санаа, үйл явдлуудыг ойлгох, (б) янз бүрийн соёлын талаарх мэдлэг олж авах, (в) дэлхийн эдийн засаг, улс төр, нийгмийн хүчний талаар ойлголцотой болох зэрэг орох боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.
29. Ерөнхий боловсролыг олон янзын өөр арга замаар ялгаатай орчин нөхцөлд авч болно. Ерөнхий боловсрол нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэж орохоос өмнө эхлэх бөгөөд МАШХ болон МТХ-ийн туршид үргэлжилж болно.

Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт

30. МАШХ гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд тэргүүн ээлжинд шаардлагатай мэргэжлийн чадавхыг эзэмших сургалт, хөгжүүлэлтийг хэлнэ.
31. МАШХ-д мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол, практик туршлага болон үнэлгээг хамруулдаг. НБББОУСЗ-өөс эдгээр нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон:

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсрол

Ерөнхий боловсролд суурилсан бөгөөд (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хөгжүүлэхэд чиглэсэн боловсрол болон сургалт юм.

Практик туршлага

Практик туршлага гэж мэргэжлийн чадавхыг хөгжүүлэхтэй холбоотой ажлын байран дээрх болон бусад арга хэмжээг хэлнэ.

Үнэлгээ

Сургалт, хөгжүүлэлтийн үр дүнд эзэмшсэн мэргэжлийн чадавхад өгсөн үнэлэлтийг хэлнэ.

32. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадавхыг эзэмшсэн гэдгээ нотлон харуулах хүртэл МАШХ нь үргэлжилнэ. Энэхүү мэргэжлийн чадавхыг эзэмшсэн гэдгээ нотлон харуулах нэг үр дүн гэвэл ДНБХ-ны гишүүн байгууллагад гишүүнчлэлтэй болох явдал юм.
33. Мэргэшил, тусгай эрх эсвэл батламж (“мэргэшил”) гэдэг нь хувь хүнийг мэргэжлийн зэрэгт хүрсэн эсвэл ДНБХ-ны гишүүн байгууллагад гишүүнээр элссэнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч буй явдал юм. Олон улсын хэмжээнд мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэшлийн түвшинг тодорхойлоход хууль эрх зүйн болон зохицуулалтын хувьд ихээхэн ялгаатай байдаг бөгөөд тухайн түвшинд карьерынхаа эхэн үед эсвэл нэлээн сүүлд ч хүрч болно. ДНБХ-ны гишүүн байгууллага бүр МАШХ-ийг дуусгах болон өөрсдийн гишүүдийн мэргэшлийн түвшинд хүрэх үеийн хоорондын зохих харилцан уялдааг тодорхойлж болно.

Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил

34. МТХ нь мэргэжлийн нягтлан бодогчдыг өөрсдийн ажил үүргийг чадварлагаар үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжоор хангах зорилгоор мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалахад чиглэсэн сургалт, хөгжүүлэлт юм. МТХ нь МАШХ-ийн явцад эзэмшсэн (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага зэрэгт чиглэсэн сургалтын үр дүнг тасралтгүй хөгжүүлэх боломжийг олгодог.
35. Өөрчлөлт гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогчдыг карьерынхаа туршид өөрсдийн мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалахыг шаарддаг мэргэжлийн нягтлан бодогчдын ажлын орчин нөхцөл дэх чухал шинж чанар юм. Өөрчлөлт хийх дарамт олон эх сурвалжаас ирдэг бөгөөд үүнд (а) олон нийтийн хүлээлт, (б) даяарчлал, (в) технологийн дэвшил, (г) бизнесийн нарийн төвөгтэй байдал, (д) нийгмийн өөрчлөлт, (е) зохицуулалт, хяналт нэмэгдэх зэрэг багтах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүний үр дүнд, мэргэжлийн нягтлан бодогчдын хувьд үйл явц, технологи, мэргэжлийн стандарт, зохицуулалтын шаардлагууд, ажил олгогчийн хэрэгцээ болон бусад тал дээр гарах өөрчлөлтүүдийг урьдчилан харж, дасан зохицоход шаардагдах боловсрол, сургалт, мэдлэг, ур чадварыг идэвхийлэн эзэмших шаардлагатай учир тасралтгүй сургалт нь МТХ-ийн салшгүй нэг хэсэг юм.
36. Мэргэжлийн нягтлан бодогчид өөрсдийн карьерын явцад шинэ ажил үүрэг хүлээн авч гүйцэтгэхийн хэрээр мэргэжлийн чадавхын шаардлагууд өөрчлөгдөж болно. Жишээ нь, бизнесийн салбарт ажиллаж буй мэргэжлийн нягтлан бодогч нь нягтлан бодох бүртгэлийн багш болох эсвэл нягтлан бодох бүртгэлийн техник мэргэжилтэн нь аудитын чиглэлээр ажиллах хүсэлтэй байж болно. МТХ нь МАШХ-тэй ижил төстэй олон элементүүдийг агуулдаг бөгөөд мөн шинэ ажил үүрэгт шилжиж ажиллах үед шаардагдаж болзошгүй (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг илүү өргөн хүрээнд гүнзгийрүүлэн хөгжүүлдэг.
37. МТХ нь хувь хүмүүст ажлын байран дээрээ мэргэжлийн чадавхаа хөгжүүлэх боломжийг олгодог практик туршлагыг багтаадаг. Мэргэжлийн нягтлан бодогчийн карьер өсч дэвшихийн хэрээр тодорхой зохион байгуулалт бүхий сургалтын арга хэмжээнээс илүүтэйгээр практик туршлага болон албан бус сургалтанд ач холбогдол өгөх хандлагатай байдаг.

Үнэлгээ, Хэмжилт ба Мониторинг

38. Үнэлгээ, хэмжилт ба мониторинг нь мэргэжлийн чадавхыг илтгэн харуулах, болон сургалт, хөгжүүлэлт үр дүнтэй байгаа эсэхийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг.
39. Үнэлгээг үнэлүүлж буй хувь хүн нь мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн чадавхтай болохоо харуулсан баримт нотолгоог цуглуулахад ашиглана. Түүнчлэн, үнэлгээ нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн чанарыг сайжруулахад ашиглаж болох чухал ач холбогдолтой мэдээллийг бий болгодог. Үнэлгээг үр дүнтэй хийснээр хүчинтэй, хангалттай, найдвартай, эрх тэгш, ил тод байдлын өндөр түвшинд хүрнэ. Мэргэжлийн чадавхыг үнэлэхдээ ихэвчлэн өөр өөр үнэлгээний үйл ажиллагааг хослуулж ашигладаг.
40. Үнэлгээнд мэргэжлийн чадавхын хэмжилт багтдаг. Үнэлгээний хүрээнд (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг эзэмшсэн болохыг нотолсон баримтыг үнэлж, гаргаж өгөх зэргийг хэмжилтэнд хамруулна.
41. Хэмжилтийн хандлагууд нь мэдэгдэхүйц гарц (жишээ нь, ажлын байрны гүйцэтгэл, ажлын байрыг зохиомлоор бий болгох, бичгийн шалгалт авах, өөрийгөө үнэлэх), тоон үзүүлэлтээр хэмжигдэх орц (жишээ нь, МТХ-ийн хичээлийн цаг эсвэл түүнтэй адилтгах сургалтын нэгж), эсвэл эдгээрийг хоёуланг нь хослуулан хэмжихэд чиглэдэг.
42. Мониторинг гэдэг нь мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалж буйг илтгэн харуулсан нотолгоог цуглуулах, хянах, баталгаажуулах системтэй үйл явц юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ – НБББОУСЗ-ӨӨС ГАРГАСАН ХЭВЛЭЛ НИЙТЛЭЛ

Боловсролын Олон Улсын Стандарт

43. БОУС-ыг заавал дагаж мөрдөх ёстой бөгөөд ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчид болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн боловсролын шаардлагыг тогтоох үед ашигладаг.
44. БОУС нь (а) мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэж орох, (б) мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулсан МАШХ, (в) мэргэжлийн нягтлан бодогчдод зориулсан МТХ-ийн шаардлагуудыг тогтоодог.
45. НБББОУСЗ нь (а) дэлхий дахины соёл, хэл, болон боловсрол, эрх зүй, нийгмийн тогтолцооны ялгаатай байдал, болон (б) мэргэжлийн нягтлан бодогчдын гүйцэтгэдэг олон төрлийн ажил үүргийг харгалзан авч үздэг. БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад БОУС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэхэд уян хатан байдлыг бий болгодог зарчимд суурилсан стандарт хэлбэрээр боловсруулсан. ДНБХ-ны гишүүн байгууллага бүр БОУС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх хамгийн сайн арга замыг тодорхойлох шаардлагатай бөгөөд Гишүүний Үүрэг Хариуцлагын Дүрэм (“ГҮХД”)–ыг дагаж мөрдөнө. Мөн НБББОУСЗ нь бие даасан ДНБХ-ны гишүүн байгууллагуудыг БОУС-д зааснаас илүү өндөр сургалт, хөгжүүлэлтийн шаардлагуудыг мөрдөх боломжтой болохыг хүлээн зөвшөөрдөг.
46. НБББОУСЗ-өөс стандартыг боловсруулахад дагаж мөрдөх үйл явцыг *НБББОУСЗ-ийн Ажлын Удирдамж*-д тусгасан байдаг.
47. БОУС-ыг Хавсралт 2-т тусгасан *НБББОУСЗ-ийн Төсөл Боловсруулах Журам*-ын дагуу бичиж найруулсан.

НБББОУСЗ-өөс Гаргасан Бусад Хэвлэл Нийтлэл

48. НБББОУСЗ-өөс БОУС-ыг дэмжих зорилгоор ДНБХ-ны гишүүн байгууллагуудад сургалт, хөгжүүлэлтийн сайн практикийг хэрэгжүүлэхэд нь туслах бусад хэвлэл нийтлэл болон нэмэлт дэмжих материалуудыг гаргадаг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ - ДНБХ-НЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

БОУС-тай Холбоотой ДНБХ-ны Гишүүдийн Үүрэг Хариуцлага

49. Бие даасан ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь өөрсдийн гишүүдийн гүйцэтгэдэг мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүрэгт тохирсон гишүүнчлэлийн чадавх болон шалгуурыг тодорхойлно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд болон хамтран ажилладаг байгууллагуудын үүрэг хариуцлагын талаар ГҮХД-д тусгасан. БОУС-тай холбоотой үүрэг хариуцлагын талаар *Гишүүний Үүрэг Хариуцлагын Дүрэм 2 буюу Мэргэжлийн Нягтлан Бодогчдод Зориулсан Боловсролын Олон Улсын Стандарт ба НБББОУСЗ-өөс Гаргасан Бусад Тунхаглал* (“ГҮХД 2”)-аас үзэх боломжтой.
50. Зарим ДНБХ-ны гишүүн байгууллагуудын хувьд тухайн бүс нутгийнхаа хууль, журмыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг. БОУС нь тэдгээр хууль, журмын дагуу ДНБХ-ны гишүүн байгууллагуудад тавигдсан боловсролын шаардлага, хязгаарлалтуудыг хууль эрх зүйн хүрээнд давж гарч чадахгүй юм. Хууль, журамд зааснаас илүү өндөр шаардлагыг БОУС-д тогтоосон тохиолдолд ДНБХ-ны гишүүн байгууллага нь БОУС-д хамарсан асуудлаар хамтарсан байдлаар эсвэл огт үүрэг хариуцлага хүлээгээгүй бол БОУС-ын шаардлагуудыг дагаж мөрдөх чиглэлээр сайтар анхаарч ажиллахыг ГҮХД 2-ын дагуу шаарддаг. Эдгээр тохиолдолд ДНБХ-ны гишүүн байгууллага нь (а) өөрийн үүрэг хариуцлагын түвшинг тодорхойлох, (б) ГҮХД 2-ын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа хамгийн сайнаар биелүүлэх чиглэлээр зохих арга хэмжээг авах, (в) БОУС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээдийг холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг дэмжиж болно.

Хавсралт 1

УР ЧАДВАРЫН ТҮВШНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү ур чадварын түвшний тодорхойлолт нь БОУС болон бусад хэвлэл нийтлэлд тусгасан сургалтын үр дүнг НБББОУСЗ-өөс хэрэгжүүлэхийг дэмждэг. Үүнд ур чадварын гурван түвшинг тодорхойлсон. Эдгээр тодорхойлолтууд нь сургалтын үр дүнгийн хамтаар мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн ялгаатай ажил үүрэг гүйцэтгэх болон өөр өөр чиглэлээр ажиллахад зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад гишүүн байгууллагад хэрэглэгдэнэ.

Ур Чадварын Түвшин	Тодорхойлолт
Суурь түвшин	<p>Ерөнхийдөө суурь түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах зүйлс дээр төвлөрдөг:</p> <ul style="list-style-type: none"> ● Зохистой удирдлагын дагууажиллахдаа үүрэг даалгавраа гүйцэтгэхийн тулд техникийн чадавхын хүрээнд холбоотой үндсэн зарчим болон томъёоллыг тодорхойлох, тайлбарлах, нэгтгэх; ● Зохистой мэргэжлийн ур чадварыг ашиглан өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх; ● Өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын ач холбогдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх; ● Энгийн асуудлуудыг шийдвэрлэх, мөн нарийн төвөгтэй ажил эсвэл асуудлуудыг удирдлага эсвэл мэргэжлийн хүмүүст хүргүүлэх; ● Аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Суурь түвшний сургалтын үр дүнд доод түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Дунд түвшин	<p>Ерөнхийдөө дунд түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> ● Ажил гүйцэтгэх болон шийдвэр гаргахдаа холбогдох техникийн чадавхын хүрээний үндсэн зарчим болон томъёоллыг бие дааж хэрэглэх, харьцуулах болон шинжлэх; ● Ажил үүргээ гүйцэтгэхдээ техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг хослуулах; ● Ажил үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хэрэглэх; ● Нягтлан бодох бүртгэлийн болон бусад оролцогч талуудад аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Дунд түвшний сургалтын үр дүнд дунд зэргийн ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Ахисан түвшин	<p>Ерөнхийдөө ахисан түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> ● Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдах, мөн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зөвлөгөө өгөхийн тулд олон төрлийн техникийн чадавхаас зохистой зарчим

	<p>болон томъёоллыг сонгох болон нэгтгэх ;</p> <ul style="list-style-type: none">● Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдахдаа техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг нэгтгэх ;● Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бодитоор хэрэгжүүлэх тохиолдолд мэргэжлийн шийдвэр гаргах● Хязгаарлагдмал хяналттай нарийн төвөгтэй асуудлыг үнэлэх, судлах болон шийдвэрлэх;● Нарийн төвөгтэй асуудлыг урьдчилан таамаглах, зөвлөх болон шийдлийг боловсруулах;● Олон төрлийн оролцогч талуудад холбогдох мэдээллийг өргөн хүрээтэй, итгэл үнэмшилтэй тайлбарлах. <p>Ахисан түвшний сургалтын үр дүнд ахисан түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
--	---

НБББОУСЗ-ИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Хэл Зүй ба Бүтэц

БОУС-ыг боловсруулах явцад зохистой үг хэллэгийг сонгохдоо боломжтой бол *НБББОУСЗ-ийн Төсөл Боловсруулах Журам* болон *НБББОУС-өөс гаргасан Нэр Томьёоны Тайлбар* (“Нэр Томьёоны Тайлбар”)-ыг чиглэл болгоно. НБББОУСЗ-ийн тунхаглалд тусгасан тодорхойлолтууд нь Нэр Томьёоны Тайлбарт багтсан байдаг. Нэр Томьёоны Тайлбар нь орчуулга, тайлбар болон хэрэглээг дэмжих зорилготой юм. Эдгээр тодорхойлолтууд нь хууль, журам эсвэл бусад зорилгоор гаргасан тодорхойлолтыг няцаах зорилгогүй болно.

БОУС-ын бүтцийг дараах сэдвүүдийг тусад нь бүлэг болгон оруулж зохион байгуулна: Оршил, Зорилго, Шаардлагууд, болон Тайлбар Материал.

Оршил

Оршил материалд БОУС бүрийн талаарх зохих ойлголтыг агуулсан цар хүрээ болон хүчинтэй мөрдөх хугацаатай холбоотой мэдээллийг тусгана.

Зорилго

БОУС-уудад тухайн стандартын зорилгыг тодорхой тусгасан байна. ДНБХ-ны гишүүн байгууллага нь зорилгын тусламжтайгаар тухайн стандартын ерөнхий зорилго болон юуг биелүүлэх ёстойгоо ойлгож авахаас гадна тус зорилгод хүрэхийн тулд илүү ихийг хийх шаардлагатай эсэхээ шийддэг.

Шаардлагууд

Зорилго нь түүнд хүрэхэд хэрэгцээтэй тодорхой заасан шаардлагуудад тулгуурлана. Шаардлагуудыг тогтоохдоо үргэлж “ёстой” гэсэн үг хэллэгийг ашиглана.

Тайлбар Материал

Тайлбар материал нь хамрах хүрээ, зорилго, шаардлагуудыг илүү дэлгэрэнгүй тайлбарлахад чиглэнэ. Тайлбар материал нь ДНБХ-ны гишүүн байгууллагуудад шаардлагуудыг хэрэгжүүлэхэд тус дэм болох бөгөөд тэдгээрийг хэрхэн биелүүлэх жишээг багтааж болно. Тайлбар материал нь аливаа нэмэлт шаардлагуудыг тогтоохгүй бөгөөд хэрэгжилтийг дэмжих зорилготой байдаг.

НБББОУСЗ-ӨӨС ГАРГАСАН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР (2015 ОНЫ 4 ДҮГЭЭР САР)

1. Энэхүү нэр томьёоны тайлбарт тодорхойлолт нэр томьёог багтаасан бөгөөд тэдгээрийн ихэнхийг одоогийн хүчин төгөлдөр НБББОУСЗ-ийн тунхаглалд тусгайлан тодорхойлсон болно. НБББОУСЗ нь гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа явуулдаг өөр өөр улс орнуудад нэр томьёонуудыг ялгаатай нийтлэг утга болон өнгө аясаар ойлгож, хэрэглэдэг байж болохыг хүлээн зөвшөөрдөг. Нэр томьёоны тайлбарт гишүүн байгууллагуудын нэр томьёонуудын хэрэглээг зааварчлаагүй. Харин нэр томьёоны тайлбар нь НБББОУСЗ-өөс гаргасан БОУС болон БОУПТ-ын хүрээнд тусгай утгаар ашиглагдах тодорхойлолт нэр томьёонуудын жагсаалт юм.
2. Од (*)-оор тэмдэглэсэн үгс нь энэхүү нэр томьёоны тайлбарт тодорхойлсон нэр томьёо болохыг илэрхийлнэ.

Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч - Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлтийн* хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг* эхлүүлсэн хувь хүн.

**Үнэлгээ* - Сургалт, хөгжүүлэлтийн үр дүнд эзэмшсэн мэргэжлийн чадавхад өгсөн үнэлэлт.*

**Үнэлгээний үйл ажиллагаа* - Мэргэжлийн чадавхын тодорхой талбаруудыг тусгайлан үнэлэх зорилгоор боловсруулсан тэдгээр арга, үйл ажиллагаа.*

Нийлмэл хандлага – Орц* болон гарцад* суурилсан хандлагуудын элементүүдийг нэгтгэсэн нийлмэл хандлага.

Чадавхын цар хүрээ – Холбогдох цогц сургалтын үр дүнг* тодорхойлсон ангилал.

**Агуулгын хүчинтэй байдал (Үнэлгээний)*–Үнэлгээний* хувьд үнэлгээний үйл ажиллагаа нь үнэлэгдэж буй мэргэжлийн чадавхын* тодорхой агуулга, ойлголтыг зохистойгоор хамааруулж байгаа эсэх байдал.

Мэргэжлийн тасралтгүй хөгжил (МТХ)–Мэргэжлийн нягтлан бодогчдыг* өөрсдийн ажил үүргийг* чадварлагаар үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжоор хангах зорилгоор мэргэжлийн чадавхыг* хөгжүүлж, хадгалахад чиглэсэн мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлтийн* дараах сургалт, хөгжүүлэлт.

**Нэгдсэн боловсрол*–Академик сургалт болон бүтэн цагийн ажлын туршлагыг хослуулсан хугацааг (жишээ нь, хичээлийн улирал, семестр, хичээлийн 3 улирал) багтаасан ерөнхийдөө зэрэг олгох зорилготой боловсролын* хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрөөр ерөнхийдөө зэрэг авахад тавигдах шаардлагуудыг гүйцээхэд нэмэлт хугацаа шаардлагатай болдог.

**Боловсрол*–Хувь хүний мэдлэг, ур чадвар болон бусад чадамжийг эзэмшиж хөгжүүлэхэд чиглэсэн системтэй үйл явц бөгөөд ерөнхийдөө академик орчинд явагддаг боловч заавал тийм байх албагүй үйл явц юм.

Эрх тэгш байдал (үнэлгээний)–Үнэлгээний* хувьд үнэлгээний үйл ажиллагаа* нь шударга бөгөөд төөрөгдөлгүй эсэх байдал.

Сэдвийн нийцлийн хүчинтэй байдал (үнэлгээний)–Үнэлгээний* хувьд үнэлгээний үйл ажиллагаа* нь юуг хэмжихийг зорьсон түүнийгээ хэмжиж чадаж байгаа эсэх байдал.

Санхүүгийн тайлан–Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээнд аж ахуйн нэгжийн эдийн засгийн нөөц эсвэл үүргийг тодорхой хугацааны байдлаар эсвэл тодорхой хугацаанд гарсан өөрчлөлтийг мэдээлэхэд чиглэсэн тодруулгыг агуулсан санхүүгийн түүхэн мэдээллийг тодорхой зохион байгуулалт, бүтцээр илэрхийлснийг хэлнэ. “Санхүүгийн тайлан” гэсэн нэр томьёо нь ерөнхийдөө холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын шаардлагуудаар тодорхойлсон иж бүрэн санхүүгийн тайлангуудыг хэлэх боловч дан ганц санхүүгийн тайланг бас хэлж болно. Тодруулга нь холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээнд илэрхий зөвшөөрөгдсөн эсвэл бусад байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд шаардлагатай хэмээн тодорхойлж санхүүгийн тайлангийн нүүр хэсэгт, эсвэл тэмдэглэлд эсвэл эшлэл татаж

оруулсан тайлбар мэдээллээс бүрдэнэ.

Аудит хийлгэх шаардлагатай санхүүгийн тайлан гэдэг нь эрх бүхий байгууллагаас хяналт тавьдаг аж ахуйн нэгжийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайланг хэлнэ.

Фирм–Хувиараа үйлчилгээ үзүүлэгч, нөхөрлөл, компани эсвэл мэргэжлийн нягтлан бодогчдын бусад аж ахуйн нэгж.

Албан ёсны боловсрол–Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн ажлын байранд суурилагүй бүрэлдэхүүн хэсэг.

Сайн практик–Мэргэжлийн нягтлан бодогчдын боловсрол*, хөгжилд чухал нөлөөтэй гэж үздэг тэдгээр элементүүдийг хэлэх бөгөөд мэргэжлийн чадавхыг* эзэмшихэд шаардагдах стандарт жишгийн дагуу гүйцэтгэнэ.*

Мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлт (МАШХ)–Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг* гүйцэтгэхэд тэргүүн ээлжинд шаардлагатай чадавхыг эзэмших сургалт, хөгжүүлэлт.**

Орцын хэмжүүр–Сургалт, хөгжүүлэлтэд оруулсан хөрөнгө оруулалтад голчлон чиглэсэн орцод суурилсан хэмжүүр. Жишээ нь, аливаа хувь хүн курст хамрагдвал зохих цагийн тоо эсвэл хамруулсан тодорхой сэдвүүд .*

Орцод суурилсан хандлага–Мэргэжлийн нягтлан бодогчдод мэргэжлийн чадавхаа* хөгжүүлж, хадгалахад шаардагдах сургалтын хэмжээг тодорхойлох арга.*

Оюун ухааны ур чадвар–Мэргэжлийн нягтлан бодогчийн асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах болон мэргэжлийн сайн шийдэл баримтлах чадамжтай холбоотой ур чадварууд.*

Хүнтэй харилцах харилцааны ур чадвар–Мэргэжлийн нягтлан бодогчийн бусадтайгаа үр дүнтэй харилцаж ажиллах чадамжтай холбоотой ур чадварууд.*

Сургалт ба Хөгжүүлэлт–Мэргэжлийн карьерын туршид мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалах байнгын үйл явц.*

Сургалтын үр дүн–Тодорхой чадавхын цар хүрээнд шаардлагатай мэдлэг, ойлголт, хэрэглээний талаарх гүнзгийрүүлсэн агуулга.*

Мониторинг–Мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалж буйг илтгэн харуулсан нотолгоог цуглуулах, хянах, баталгаажуулах системтэй үйл явц.

Зохион байгуулалтын ур чадвар–Боломжит нөөц бололцоо болон хүмүүсээс оновчтой үр дүн, гарцыг олж авахын тулд аливаа байгууллагад эсвэл байгууллагатай үр ашигтай ажиллах мэргэжлийн нягтлан бодогчийн чадамжтай холбоотой ур чадварууд.*

Гарцын хэмжүүр–Мэргэжлийн нягтлан бодогч нь тодорхой чадавхыг тусгайлан хөгжүүлсэн эсэхэд анхаардаг гарцад суурилсан хэмжүүр.*

Гарцад суурилсан хандлага–Мэргэжлийн нягтлан бодогчдыг сургалтын үр дүнд хүрэх замаар мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалж байгааг илтгэн харуулахыг шаарддаг арга.*

Хувийн ур чадвар–Мэргэжлийн нягтлан бодогчийн хувь хүний хандлага болон зан байдалтай холбоотой ур чадварууд.*

Практик туршлага–Мэргэжлийн чадавхыг хөгжүүлэхтэй холбоотой ажлын байран дээрх болон бусад арга хэмжээ.

Практик туршлагатай чиглүүлэгч–Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг хангалттай практик туршлага хуримтлуулахад нь чиглүүлэх, зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үүрэгтэй мэргэжлийн нягтлан бодогч.**

Таамаглах боломжтой хүчинтэй байдал (үнэлгээний)–Үнэлгээний хувьд үнэлгээний үйл ажиллагааны агуулга нь үнэлэхээр зорьж буй мэргэжлийн чадавхын* тодорхой асуудалд хамааралтай эсэх байдал.*

Мэргэжлийн нягтлан бодогч–Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадавхыг эзэмшиж, илтгэн харуулж, цааш хөгжүүлдэг, мөн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн байгууллага эсвэл эрх олгогч байгууллагаас* гаргасан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх ёстой хувь хүн.

Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол–Ерөнхий боловсрол дээр суурилсан бөгөөд (а) мэргэжлийн мэдлэг*, (б) мэргэжлийн ур чадвар*, болон (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг* эзэмшүүлэх боловсрол болон сургалт.

Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөр – Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд* мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлтийн* төгсгөлд эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхаа* хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан хөтөлбөр. Үүнд, их дээд сургуулиуд, бусад дээд боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд болон ажил олгогчдоос санал болгосон эрдмийн зэрэг болон курс сургалтаар олж авсан албан ёсны боловсролоос* гадна ажлын байран дээрх сургалтыг тус тус хамааруулна.

Мэргэжлийн чадавх–Ажил үүргийг* тогтоосон стандартын дагуу гүйцэтгэх чадвар.

Мэргэжлийн үнэлэмж–Аудит, нягтлан бодох бүртгэл болон ёс зүйн стандартын хүрээнд гэрээт ажлын нөхцөл байдалд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргахдаа холбогдох сургалт, мэдлэг, туршлагыг ашиглах.

Мэргэжлийн мэдлэг–Мэргэжлийн нягтлан бодогчдод* хэрэгцээтэй мэдлэгийн нэн чухал хэсгийг хамтдаа бүрдүүлж буй нягтлан бодох бүртгэл болон бусад бизнесийн чиглэлийг хамарсан сэдвүүд.

Мэргэжлийн үл итгэх үзэл–Алдаа эсвэл залилангаас үүдэн буруу илэрхийлсэн байж болзошгүй нөхцөл байдалд сэрэмжтэй үл итгэх сэтгэлгээгээр хандаж, нотолгоог шүүмжлэлтэйгээр үнэлэх хандлага.

Мэргэжлийн ур чадварууд–Мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн чадавхаа* илтгэн харуулах зорилгоор техникийн чадавх* болон мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагатай* хослуулан ашигладаг оюун ухааны, хүнтэй харилцах харилцааны, хувийн болон зохион байгуулалтын ур чадварууд.

Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага–Мэргэжлийн нягтлан бодогчдыг* мэргэжлийн гишүүд болгож буй шинж чанарууд. Үүнд мэргэжлийн зан төлвийн ялгаатай шинж чанарыг тодорхойлоход чухалд тооцогдох, ерөнхий холбогдолтой ёс зүйн зарчмууд багтана.

Мэргэшил–Тодорхой цаг үед хувь хүнийг мэргэжлийн нягтлан бодогч* гэж хүлээн зөвшөөрөгдөх шаардлагуудыг хангасан гэж үзсэн эсвэл үргэлжлүүлэн хангаж буй мэргэжлийн нягтлан бодогч* гэсэн мэргэшил.

Эргэцүүлэх үйл явц–Карьерынхаа аль ч шатанд ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид* ирээдүйн үйл ажиллагаагаа сайжруулах үүднээс (бодитоор эсвэл дууриах хэлбэрээр) өөрсдийн туршлагад дүгнэлт хийх замаар мэргэжлийн чадавхаа* тасралтгүй хөгжүүлж буй давтамжит үйлдэл.

Холбогдох ёс зүйн шаардлагууд–Мэргэжлийн нягтлан бодогчдын* мөрдөх ёстой ёс зүйн шаардлагууд бөгөөд Нягтлан Бодогчдын Олон Улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (НБОУЁЗСЗ-ийн Дүрэм) болон аливаа үндэсний илүү хязгаарлагдмал шаардлагуудаас үндсэндээ бүрдэнэ.

Найдвартай байдал (үнэлгээний)–Үнэлгээний* хувьд хэмжилтийн хандлага нь ижил нөхцөл байдалд дараалан ижил үр дүнтэй байсан эсэхийг харуулсан чанар эсвэл төлөв байдал болон үнэлгээний үйл ажиллагаа* нь ижил нөхцөл байдалд дараалан ижил үр дүнг илэрхийлсэн эсэх байдал.

Ажил үүрэг–Тодорхой хүлээлт бүхий үүрэг хариуцлага.

Мэргэшсэн байдал–Гишүүн байгууллагаас мэргэжлийн нягтлан бодогчийн* ажилд хамааралтай үйл ажиллагаа эсвэл аливаа нэг чиглэл эсвэл чиглэлүүдээр ялгагдах онцлог чадавх эзэмшсэн өөрийн хэсэг гишүүдийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдал.

Хангалттай байдал (үнэлгээний) –Үнэлгээний* хувьд үнэлгээний үйл ажиллагаа нь мэдлэг болон хэрэглээний гүнзгий, өргөн хүрээний тэнцвэртэй бөгөөд янз бүрийн нөхцөл байдал болон агуулгаар ашиглагддаг өөр өөр чиглэлийн материалыг нэгтгэсэн эсэх байдал.

Хангалттай байдал (практик туршлагын)–Практик туршлага* нь мэдлэг болон хэрэглээний хувьд гүнзгий, өргөн хүрээний тэнцвэртэй бөгөөд шаардлагатай үед янз бүрийн нөхцөл байдал болон агуулгаар ашиглагддаг өөр өөр чиглэлийн материалыг хослуулах боломжтой эсэх байдал.

Практик туршлагын өргөн цар хүрээнд дараах хүчин зүйлс нөлөөлдөг, тухайлбал: ажил үүргийн мөн чанар, ур чадварын түвшин, албан ёсны боловсролын* өмнөх түвшин, үндэсний эсвэл орон нутгийн хууль тогтоомж; зохицуулагч байгууллагуудын шаардлагууд; мэргэжлийн чадавхын* талаарх олон нийтийн хүлээлт.

Практик туршлагын* гүнзгий байдалд дараах хүчин зүйлс нөлөөлдөг, тухайлбал: үүрэг даалгаврын олон төрөл болон нарийн төвөгтэй байдал; хяналт тавьж, зөвлөгөө өгөх дэмжлэгийн түвшин.

Техникийн чадавх–Ажил үүргийг тогтоосон стандартын дагуу гүйцэтгэхэд мэргэжлийн мэдлэгийг* ашиглах чадварыг техникийн чадавх гэж тодорхойлсон.

Сургалт–Боловсрол* болон практик туршлагыг* нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, хөгжүүлэлтийн* үйл ажиллагаа. Сургалтаар практик хэрэглээг онцлон авч үздэг бөгөөд ихэвчлэн ажлын байранд эсвэл зохиомол ажлын орчинд явагддаг.

Ил тод байдал (үнэлгээний)–Үнэлгээний* хувьд үнэлэх гэж буй чадавхын цар хүрээ* болон үйл ажиллагааны хугацаа зэрэг үнэлгээний үйл ажиллагааны* талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд ил тод толилуулсан эсэх байдал.

Хүчинтэй байдал–Хэмжилтийн хандлагаар юуг хэмжих хэрэгтэй түүнийгээ хэмжиж байгаа эсэхийг харуулсан чанар эсвэл төлөв байдал.

Батлах боломжтой нотолгоо–Нотлох боломжтой, бичгэн эсвэл цахим хэлбэрээр хадгалсан бодит баримт нотолгоо.

Ажлын бүртгэл–Үүрэг даалгаврын мөн чанар, гүйцэтгэсэн ажлууд болон тэдгээр үүрэг даалгавар, ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацааг баримтжуулсан хувь хүмүүсийн хадгалсан тэмдэглэл. Мөн ажлын бүртгэл нь ажлын үүрэг даалгаврыг гүйцэтгэсний үр дүнд эзэмшсэн чадавхуудын талаарх баримтыг агуулсан байж болно.

ӨМНӨХ ҮГ

БОУС нь (а) мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэж орох, (б) мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулсан МАШХ, (в) мэргэжлийн нягтлан бодогчдод зориулсан МТХ-ийн шаардлагуудыг тогтоодог. НБББОУСЗ-ийн стандартыг боловсруулахад дагаж мөрдвөл зохих горимыг *Зохистой Ажиллагааны Горим* (2010) баримт бичигт тусгасан. БОУС тус бүрийн бүтцийг дараах бүлгүүдийг оруулж зохион байгуулна: Танилцуулга (тухайлбал, Цар хүрээ ба Хүчинтэй мөрдөх хугацаа), Зорилго, Шаардлагууд болон Тайлбар Материал.

Мэргэжлийн Нягтлан Бодогчид ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал (2015) нь БОУС-уудын үндэс болсон үзэл баримтлалын суурийг бүрдүүлдэг боловч энэхүү Үзэл Баримтлалд ДНБХ-ны гишүүн байгууллагуудад тавигдах шаардлагуудыг тогтоогоогүй болно.

НБББОУСЗ-ийн тунхаглалд тусгасан тодорхойлолтууд нь *НБББОУСЗ-өөс гаргасан Нэр Томьёоны Тайлбар*-т багтсан байдаг. Нэр томьёоны тайлбар нь орчуулга, тайлбар болон хэрэглээг дэмжих зорилготой юм. Эдгээр тодорхойлолтууд нь хууль, журам эсвэл бусад зорилгоор гаргасан тодорхойлолтыг няцаах зорилгогүй болно.

Мөн НБББОУСЗ нь НБББОУСЗ-ийн цахим хуудасны Тодруулах Хэсэгт байршуулсан одоогийн хүчин төгөлдөр БОУС-уудын ойлголтыг дэмжих зорилгоор Чиглүүлэх Тайлбар материалыг боловсруулсан. Чиглүүлэх Тайлбар материалд дараах зүйлс багтсан: Одоогийн хүчин төгөлдөр БОУС-уудын Дүгнэлтийн Үндэслэл хэмээх баримт бичиг; хянан засварлах төслийн үр дүнд оруулсан өөрчлөлтүүдийн хураангуйг агуулсан Гүүр Болсон Баримт Бичиг; стандарт тогтоох үйл явц, БОУС-ыг хэрэгжүүлэхэд ДНБХ-ны гишүүн байгууллагуудын үүрэг хариуцлага, НБББОУСЗ-ийн одоогийн хүчин төгөлдөр БОУС-ыг боловсруулахдаа дагаж мөрддөг зохих горимын үйл ажиллагаа зэргийг тайлбарласан Ажилтнуудын Хариулсан Асуултууд хэмээх баримт бичиг (2015); БОУС тус бүрийн гол зарчмууд болон орсон томоохон өөрчлөлтүүдийг тайлбарласан ажилтнуудын бэлтгэсэн танилцуулга болон ярианы тэмдэглэл.

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 1

МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР (2014)-Т ТАВИГДАХ ЭЛСЭЛТИЙН ШААРДЛАГА

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1–5
Хүчинтэй Мөрдөх Хугацаа	6
Зорилго	7
Шаардлага	8-10
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1–A3
Зорилго	A4–A6
Шаардлага	A7–A12

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав:А1–А3-р параграф)

1. Энэхүү Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС) нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах боловсролын шаардлагуудыг тогтоож, мэдээлэл хүргэхдээ ашиглах зарчмыг тодорхойлсон байдаг. Мэргэжлийн элсэлтийн шаардлагуудыг доорх стандартуудад тусгасан:
 - (а) БОУС 2, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Техникийн чадавх /2015/,*
 - (б) БОУС 3, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн ур чадвар /2015/,*
 - (в) БОУС 4, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага /2015/,*
 - (г) БОУС 5, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Практик Туришлага /2015/, ба*
 - (д) БОУС 6, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Ур чадварын үнэлгээ /2015/.*
2. Энэхүү БОУС-ыг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах шаардлагыг тогтоох болон мэдээлэх үүрэгтэй. Түүнчлэн, энэхүү БОУС нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг боловсролын байгууллага, зохицуулагч, ажил олгогч, засгийн газрын эрх бүхий байгууллага мөн бусад оролцогч талуудад дэмжлэг үзүүлж болно.
3. БОУС нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч нарт мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг амжилттай дүүргэх боломжоор хангахын зэрэгцээ ДНБХ-ны гишүүн байгууллагын ивээл дор мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг уян хатан хүртээмжтэй болгох зарчмыг тодорхойлдог. Энэхүү БОУС нь:
 - (а) хөтөлбөрийг амжилттай дуусгах боломж;
 - (б) хөтөлбөрийн элсэлтийн шаардлагын нийцэл;
 - (в) болон (с) элсэлтийн шаардлагын ялгаатай хэлбэрүүдийг тайлбарладаг.
4. Энэхүү БОУС нь (а) мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эзэмших ялгаатай арга зам болон (б) улс орнуудын засаглалын болон зохицуулалтын хоорондох ялгаа зэргээс хамаарч улс орон бүрт тавигдах шаардлага ялгаатай байж болохыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн, БОУС нь иж бүрэн эсвэл мэргэжлийн цол зэрэг авах нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрөөс зөвхөн нэг л төрлийн дуусгах цэг гэдгийг мөн адил хүлээн зөвшөөрдөг.
5. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Боловсролын Олон Улсын Стандартын Онолын Үзэл Баримтлал ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгч (2015)*-д ашигласан нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартын зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр томъёоны тайлбар (2015)*-т багтсан болно.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

6. Энэхүү БОУС-ыг 2014 оны 07 сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго (Лав: А4–А6-р параграф)

7. Энэхүү боловсролын олон улсын стандартын зорилго нь үнэн зөв, ижил тэгш олон нийтийн эрх ашгийг хамгаалсан мэргэжлийн нягтлан бодогчийн боловсролын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

Шаардлага (Лав: А7–А12-р параграф)

8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь элсэхэд тавигдах шаардлагыг хэтрүүлэхгүйгээр мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах боловсролын шаардлагыг тодорхойлох ёстой бөгөөд ингэснээр зөвхөн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэх боломжтой хүмүүст л боломж олгох юм.
9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлээр сурч буй хувь хүмүүс, боловсролын үйлчилгээ үзүүлэгчид зэрэг оролцогч талуудад боловсролын элсэлтийн шаардлагыг тогтооход баримталсан зарчмыг тайлбарлах ёстой.
10. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь хувь хүмүүст мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэх боломжтой эсэхээ үнэлэхэд нь зориулсан мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах ёстой.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-5-р параграф)

- A1. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөр нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн төгсгөлд эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Эдгээр нь их, дээд сургууль болон бусад дээд боловсролын байгууллагуудын олгодог боловсролын зэрэг, сургалтын хөтөлбөр ДНБХ-ны гишүүн байгууллагууд, ажил олгогчид түүнчлэн ажлын байран дахь сургалтаар олж авсан албан ёсны боловсролоос бүрддэг. Иймд МАШХ-ийн үеийн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн загварыг боловсруулахад ДНБХ-ны гишүүн орноос гадна бусад оролцогч талуудын оролцоог ихээхэн шаарддаг.
- A2. ДНБХ-ны гишүүн байгууллагуудын мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн элсэлтийн шаардлагыг тогтооход тавих хяналт, оролцоо нь янз бүр байдаг. Жишээлбэл, зарим улс оронд элсэлтийн шаардлагыг их, дээд сургуулиуд эсвэл засгийн газраас тогтоодог. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг эзэмших олон арга зам байдаг. Жишээлбэл, а) боловсролын зэрэг авч суралцдаг уламжлалт арга, б) тухайн салбарт нь ажиллаж туршлага хуримтлуулах, мөн в) бүрэн дунд боловсролын түвшнээс элсэх зэрэг орно. Түүнчлэн, улс орнууд болон ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь хөдөлмөрийн зах зээлийн орчин нөхцлөөрөө ялгаатай байдаг.
- A3. ДНБХ-ны гишүүн байгууллага нь гишүүнчлэлийн үүргийг хангуулах хэд хэдэн арга зам байдаг. Жишээлбэл, ДНБХ-ны гишүүн байгууллагаас илүүтэй их, дээд сургуулиуд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах шаардлагыг тогтоох үе байдаг. Энэ үед, ДНБХ-ны гишүүн байгууллага нь их, дээд сургуулиудад боловсролын олон улсын стандартын зорилгыг тайлбарлах замаар хамтран ажиллаж, оюутнууд цаашид ДНБХ-ны гишүүн байгууллагад гишүүнээр элсэхэд илүү хялбар байдлыг бий болгодог.

Зорилго (Лав: 7-р параграф)

- A4. Боловсролын олон улсын стандартын зорилго нь олон нийтийн эрх ашгийг хамгаалахад оршдог. Энэхүү БОУС нь Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах шаардлагаар дамжуулан мэргэжлийн нягтлан бодогчоор суралцаж буй хүмүүст мэргэжлийн сонголтоо хийхдээ мэдээлэлд тулгуурлан өөрсдийн боловсролыг сонгоход тусалдаг. Эдгээр элсэлтийн шаардлагууд нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт амжилт гаргах боломжтой хүмүүсийг элсүүлэх хэмжээнд хязгаарлагддаг. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн гишүүд эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхыг эзэмшсэн байх хэрэгтэй бөгөөд үүнийг баталгаажуулахын тулд техникийн чадавх, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага болон практик туршлага, үнэлгээний талаар БОУС 2, 3, 4, 5 болон 6-д тусгасан.
- A5. Энэхүү БОУС нь олон тооны чанартай мэргэжлийн нягтлан бодогчдыг бэлтгэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх замаар олон нийтийн эрх ашгийг төлөөлдөг. Ингэхдээ мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавих зарчмын шаардлагыг хэт өндөр тогтоох (мэргэжил эзэмшихэд үл шаардагдах хүндрэл бэрхшээл учруулах), эсвэл хэтэрхий бага (хувь хүн амжилттай суралцах болмжтой гэж хуурмагаар итгэх магадлалтай) тогтоохоос зайлсхийдэг, Иймд эдгээр элсэлтийн

шаардлагууд нь нөөцөө үр ашигтай ашиглах болон хувь хүнийг мэдээлэлд тулгуурлан мэргэжлээ сонгоход туслалцаа үзүүлдэг.

- А6. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчийн ажил бол техникийн чадавх, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг амжилттай эзэмшсэн мэргэжил гэдгийг энэ мэргэжлийг сонгох гэж буй хувь хүмүүст мэдээлэх замаар үр дүнтэй, үр ашигтай ажил мэргэжлийн шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулдаг. Хувь хүмүүс зөвхөн шаардлагатай мэдээлэл хангалттай байгаа үед л шийдвэр гаргах боломжтой байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллагууд цаг ямагт мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлээр сурч буй хүмүүст өгч буй зөвлөгөөг цуглуулж, шинжилж байвал уг зөвлөгөө нь илүү найдвартай байна. ДНБХ-ны гишүүн байгууллагаас өгсөн мэдээлэлд дараах зүйлс багтвал зохино:
- (а) Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрүүдийн элсэлтийн шаардлагуудыг өөрчлөх;
 - (б) Зөвхөн тухайн хувь хүн мэргэжлийн нягтлан бодогчин хөтөлбөрийг амжилттай дүүргэх боломжтой байх үед л тухай хүнийг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжил эзэмшихийг дэмжих;
 - (в) Ур чадварыг эзэмшснийг дүгнэх босго түвшин;
 - (г) Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг хэрхэн эзэмшихтэй холбоотой ойлголт болон холбогдох зардлын талаарх ил тод мэдээлэл; ба
 - (д) Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснээр олж авах ур чадвар, мэдлэг ба хандлагуудыг тодорхойлсон ур чадварын зураглал зэрэг өөрийгөө оношлох хэрэгсэл.

Шаардлагууд (Лав: 8-10-р параграф)

- А7. Амжилттай дүүргэх боломжит хувилбарыг тодорхойлох нь олон хүчин зүйлээс хамаарсан шүүлтийн асуудал юм. Зорилго нь а) хувь хүнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн талаар аль болох бүрэн мэдээллээр хангагдсаны үндсэн дээр мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийг сонгох эсэхээ шийдэхэд туслах, б) мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудад аль болох холбоотой, ашигтай мэдээллийг хуваалцаж дэмжих. ДНБХ-ы гишүүдийн байгууллагуудын ялгаатай мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрөөс шалтгаалан үг хэллэгийг харилцан адилгүй ойлгож болдог. ДНБХ-ны гишүүн байгууллагууд амжилттай дүүргэх боломжтой хувилбарыг илтгэсэн хүчин зүйлүүдийг тогтоож болно. Жишээлбэл, мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн элсэлтийн шалгуурт хувь хүний мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийг сонгоход шаардагдах ур чадварыг тодорхойлох зэрэг орно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж болно. Үүнд: а) эдийн засаг, бизнес, болон хууль эрхзүйн зорчин, б) шаардлагатай урьдчилсан мэдлэг, в) суралцах явцад эзэмших мэдлэг, г) нягтлан бодогчийн үүрэг; болон д) бусад холбогдох хүчин зүйлс орно.
- А8. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэхэд шаардагдах техникийн чадавх, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг элсэлтийн шаардлагад оруулж болно. Үүнд их, дээд сургуулийн эрдмийн зэрэг хүртэхээр суралцаж эхлэхэд их, дээд сургуулийн эрдмийн зэрэг, болон

мэргэжлийн цол хэргэм шаардахыг хоридоггүй. Элсэлтийн шаардлагыг тогтоохдоо ДНБХ-ны гишүүн байгууллага нь хэт өндөр эсвэл хэтэрхий шалдар булдар биш тухайн нөхцөл тохирсон шаардлага тогтоох хэрэгтэй. Элсэлтийн хэт өндөр шалгуур гэдэгт нэр заасан их, дээд сургуулийн тухайлан нэр дурдсан хичээлийг судалсан байх, эсвэл тодорхой ажлын туршлагыг эзэмшсэн байвал зохих хамгийн бага хугацааг тодорхойлох зэрэг орно. Иймэрхүү хэт өндөр саад бэрхшээлээс зайлсхийх зорилго нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн стандартыг эсвэл нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг сулруулахгүйгээр мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт хамрагдах боломжийг уян хатан болгоход оршино. Харин мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт элсэн орох болон гарах олон янзын арга замууд байдаг ба МАШХ-ийг эзэмших ялгаатай арга замууд бий.

- A9. Улс орон болон төрлөөс хамааран харилцан адилгүй байдгаас шалтгаалан ДНБХ-ны гишүүн байгууллагуудын мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт оролцогчдод тавигдах элсэлтийн шаардлага нь хоорондоо ялгаатай байж болно. Жишээлбэл, зарим мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогч талуудад тавигдах элсэлтийн шаардлага нь зөвхөн сайн түвшний бичиг үсэг тайлагдсан болон тооны ур чадвар байдаг. Эсрэгээр, мэргэжлийн тодорхой үүрэгт зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт оролцогчдод тавигдах элсэлтийн шаардлага нь хувь хүнийг дээд боловсролтой эсвэл түүнтэй дүйцэх хэмжээний боловсролтой байхыг шаарддаг.
- A10. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид өөрсдийн а) техникийн чадавх, б) мэргэжлийн ур чадвар, в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлагыг өөр өөрсдийн ажлын туршлага, сургалт эсвэл чадвар зэрэг харилцан адилгүй арга замаар хөгжүүлсэн байдаг. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлэх уян хатан байдал нь МАШХ-ийг эзэмших гэж буй мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд тавих шаардлагыг сулруулж болохгүй. Үүний тулд ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэх боломжийг хангасан уян хатан элсэлтийн шаардлагыг баталж болно. Энэхүү уян хатан байдал нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй хамруулах зорилготой байдаг болохоос олон төрлийн мэргэжлийн нягтлан бодогчийн бий болгох зорилгогүй юм. Жишээ нь, ДНБХ-ны гишүүн байгууллага нь урьдчилсан шалгаруулалтын тавигдах шаардлагыг тодорхойлсон (жишээлбэл, их дээд сургууль эсвэл түүнтэй адил) боловч холбогдох практик туршлагаас хамааран их дээд сургуулийн зэрэггүй мөртлөө ажлын туршлагатай бол нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсролын хөтөлбөрт шууд орохыг зөвшөөрдөг байж болно.
- A11. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт тавигдах элсэлтийн шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлох тусгай шалгуурыг тогтоож болно. Үүнд мэргэшил, суралцсан анги, элсэлтийн шалгалт, эсвэл туршлага зэргийг оруулж болно. Элсэлтийн шаардлагад ДНБХ-ны гишүүн байгууллагын зүгээс зохистой гэж үзсэн мэргэшил, туршлага, эсвэл бусад шаардлагуудын аль нэг (эсвэл эдгээрээс оролцуулсан) үнэлгээг багтааж болно. Энэ мэдээллийг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн танилцуулга хэвлүүлэх, эсвэл ДНБХ-ны гишүүн байгууллагуудын веб сайтуудад байршуулах хэлбэрээр мэдээлнэ.
- A12. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь хувь хүмүүст мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлийг сонгон мэргэжлийн нягтлан бодогчийн боловсролын хөтөлбөрийг

амжилттай дүүргэх эсэхийг шийдвэрлэхдээ тухайн хөтөлбөрийн агуулга, түвшин, хөтөлбөрийн үнэлгээний арга зүйг харгалзахыг зөвлөж тусалдаг.

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 2

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ- ТЕХНИКИЙН ЧАДАВХ (2015)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1-4
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	5
Зорилго.....	6
Шаардлага	
Техникийн Чадавхын Сургалтын Үр Дүн.....	7
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт.....	8
Техникийн Чадавхын Үнэлгээ.....	9
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1-A6
Зорилго	A7
Техникийн Чадавхын Сургалтын Үр Дүн....	A7-A12
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт.....	A13-A14
Техникийн Чадавхын Үнэлгээ.....	A15-A16
Хавсралт 1: Ур Чадварын Түвшний Тодорхойлолт	

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А1–А6-р параграф)

1. Мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлт (МАШХ)-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих техникийн чадавхыг энэ БОУС-д тодорхойлсон болно. Техникийн чадавх нь тодорхойлсон стандарт хэмжээнд үүрэг гүйцэтгэхэд ашиглах мэргэжлийн мэдлэг юм.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь МАШХ нь энэхүү БОУС-ын шаардлагад нийцсэн байх нөхцлийг хангах үүрэгтэй. Үүнээс гадна, БОУС нь боловсролын байгууллагууд, ажил олгогчид, хууль эрхзүйн зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллагууд, ба мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн сургалт ба хөгжлийн үйл явцыг дэмждэг бусад оролцогч талуудад хэрэгцээтэй байдаг.
3. Энэхүү БОУС-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих техникийн чадавхыг бүрэн тодорхойлох чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхой заасан. *БОУС 3, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Ур Чадвар (2015)*, ба *БОУС 4, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагууд (2015)* гэсэн стандартуудад МАШХ-тэй чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхой заасан. Эдгээр БОУС-ууд нь хамтдаа МАШХ-ийн төгсгөлд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхойлсон.
4. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчид болон Мэргэжлийн Нягтлан Бодогч болохыг Эрмэлзэгчдийн Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал (2015)*-д ашигласан нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр томъёоны тайлбар (2015)*-т багтсан болно.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

5. Энэхүү БОУС-ыг 2015 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго (Лав: А7-р параграф)

6. Мэргэжлийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэхийн тулд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид МАШХ-ийн эцэст эзэмшвэл зохих техникийн чадавхыг тодорхойлоход энэхүү стандартын зорилго оршино.

Шаардлагууд

Техникийн Чадавхын Сургалтын Үр Дүн (Лав: А8-А12-р параграф)

7. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих техникийн чадавхын сургалтын үр дүнг тодорхойлох ёстой. Эдгээр сургалтын үр дүнд эзэмших чадавхыг Хүснэгт А-д харуулав.

Хүснэгт А: Техникийн Чадавхын Сургалтын Үр Дүн

Чадавхын Хамрах Хүрээ (Ур Чадварын Түвшин¹)	Сургалтын Үр Дүн
(а) Санхүүгийн нягтлан бодох бүртгэл ба тайлагнал (Дунд түвшин)	i. Ажил гүйлгээ болон бусад үйл явдлуудад нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөрдөх. ii. Ажил гүйлгээ болон бусад үйл явдлуудад Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон бусад холбогдох стандартуудыг мөрдөх. iii. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдлыг үнэлэх. iv. Нэгтгэсэн санхүүгийн тайланг багтаасан санхүүгийн тайлангуудыг СТОУС эсвэл бусад холбогдох стандартын дагуу бэлтгэх. v. Санхүүгийн тайлангууд болон холбогдох тодруулгуудыг тайлбарлах. vi. Санхүүгийн бус мэдээллийг агуулсан тогтвортой байдлын тайлангууд ба нэгдсэн тайлангуудыг тайлбарлах.
(б) Удирдлагын нягтлан бодох бүртгэл (Дунд түвшин)	i. Бүтээгдэхүүний өртгийн тооцоо, зөрүүгийн шинжилгээ, бараа материалын удирдлага, төсөвлөлт болон төлөвлөгөө зэрэгт удирдлагын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх арга техникийг хэрэглэх. ii. Зардлын хүчин зүйл болон зардлын төлөв байдлыг шинжлэхэд тохирох тоон аргыг хэрэглэх. iii. Удирдлагын шийдвэр гаргалтанд холбогдолтой мэдээллээр хангахад шаардагдах санхүүгийн болон санхүүгийн бус өгөгдөлд дүн шинжилгээ хийх. iv. Удирдлагын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төлөвлөлт, төсөвлөлт, өртгийн удирдлага, чанарын хяналт, гүйцэтгэлийн хэмжилт, болон бенчмаркинг зэргийг хамарсан тайлангуудыг бэлтгэх. v. Бүтээгдэхүүн болон бизнесийн сегментийн гүйцэтгэлийг үнэлэх.
(в) Санхүү болон санхүүгийн удирдлага (Дунд түвшин)	i. Банкны санхүүжилт, санхүүгийн хэрэгслүүд, ба өрийн бичиг, эзний өмч ба үнэт цаасны зах зээлүүдээс байгууллагын авч болох боломжит ялгаатай санхүүгийн эх үүсвэрүүдийг харьцуулах. ii. Байгууллагын мөнгөн гүйлгээ болон ажлын капиталын шаардлагуудыг шинжлэх. iii. Харьцааны шинжилгээ, чиг хандлагын шинжилгээ болон мөнгөн гүйлгээний шинжилгээ тооцоолох аргуудыг ашиглан байгууллагын одоогийн болон ирээдүйн санхүүгийн нөхцөл байдлыг шинжлэх. iv. Байгууллагын капиталын өртгийг тооцоолоход ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдийн зохистой байдлыг үнэлэх. v. Капитал хөрөнгө оруулалтын шийдвэрийн үнэлгээнд капитал төсөвлөлтийн арга техникийг ашиглах. vi. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, бизнес төлөвлөлт ба ург хугацааны удирдлагад ашиглагддаг орлого, хөрөнгөд

¹ МАШХ-ийн эцэст эзэмшсэн байвал зохих чадавхын цар хүрээнд хамаарах ур чадварын түвшин (Хавсралт 1-д тодорхойлсон).

	тулгуурласан болон зах зээлийн үнэлгээний аргыг тодорхойлох.
(г) Татвар (Дунд түвшин)	<p>i. Үндэсний татварын нийцэл болон баримтжуулалтын шалгуурыг тайлбарлах.</p> <p>ii. Хувь хүмүүс болон албан байгууллагуудын шууд болон шууд бус татварын тооцооллыг бэлтгэх.</p> <p>iii. Нарийн, төвөгтэй биш олон улсын гүйлгээтэй холбоотой татварын асуудлыг шийдвэрлэх.</p> <p>iv. Татварын төлөвлөлт, татвараас зайлсхийх, болон татварыг нуун дарагдуулах зэргийн хоорондын ялгааг тайлбарлах.</p>
(д) Аудит ба баталгаажуулалт (Дунд түвшин)	<p>i. Санхүүгийн тайлангийн аудитын зорилго болон үе шатуудыг тодорхойлох.</p> <p>ii. Холбогдох аудитын стандартууд (жишээ нь, аудитын олон улсын стандарт), ба санхүүгийн тайланд аудит хийхэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг тайлбарлах.</p> <p>iii. Санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг үнэлж, аудитын стратегийн нөлөөллийг авч үзэх.</p> <p>iv. Аудитын ажилд ашигласан тоон шинжилгээний аргуудыг тайлбарлах.</p> <p>v. Аудит баталгаажуулалтын ажлын гол элементүүд болон тэдгээртэй холбоотой стандартуудыг тайлбарлах.</p>
(е) Засгийн газар, эрсдэлийн менежмент ба дотоод хяналт (Дунд түвшин)	<p>i. Эзэмшигч, хөрөнгө оруулагчид болон засаглалын эрх бүхий хүмүүсийн эрх үүргийг багтаасан мөн оролцогч талуудын засаглал, тодруулга болон ил тод байдлын шаардлагын үүргийг тодорхойлдог сайн засаглалын зарчмыг тодорхойлох.</p> <p>ii. Байгууллагын засаглалын бүтцийн бүрэлдэхүүнд шинжилгээ хийх.</p> <p>iii. Эрсдэлийн менежментийн бүтцийг ашиглан байгууллагын эрсдэл болон боломжуудыг шинжлэх.</p> <p>iv. Санхүүгийн тайлантай холбоотой дотоод хяналтын бүтцэд шинжилгээ хийх.</p>
(ё) Бизнесийн хууль тогтоомж болон дүрэм журмууд (Дунд түвшин)	<p>i. Хуулийн этгээдүүдийн ялгаатай хэлбэрийг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журмыг тайлбарлах.</p> <p>ii. Мэргэжлийн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулж буй орчинд тохирох хууль тогтоомж, дүрэм журмыг тайлбарлах.</p>
(ж) Мэдээлэл технологи (Дунд түвшин)	<p>i. Мэдээлэл технологийн ерөнхий хяналт болон холбогдох хэрэглээний хяналтуудын зохистой байдалд шинжилгээ хийх.</p> <p>ii. Өгөгдлийн шинжилгээ болон шийдвэр гаргалтад мэдээллийн технологи хэрхэн хувь нэмэр оруулж байгааг тайлбарлах.</p> <p>iii. Бизнесийн шинжилгээний дагуу шийдвэр гаргалтыг дэмжихийн тулд мэдээллийн технологи ашиглах.</p>
(з) Бизнесийн ба зохион байгуулалтын орчин (Дунд түвшин)	<p>i. Эдийн засгийн, хуулийн, улс төрийн, нийгмийн, техникийн, олон улсын болон соёлын нөлөө зэрэг голлох хүчин зүйлүүдэд хамаарах байгууллагын орчныг тодорхойлох.</p> <p>ii. Олон улсын худалдаа болон санхүүжилтэд нөлөөлж буй дэлхийн орчны нөхцөл байдлыг судлах.</p> <p>iii. Олон улсын компаниуд, цахим худалдаа болон хөгжиж буй зах зээл зэрэг даяаршлын онцлог шинжийг тодорхойлох.</p>
(й) Эдийн засаг (Суурь)	<p>i. Микро болон макро эдийн засгийн суурь зарчмуудыг тодорхойлох.</p> <p>ii. Бизнесийн үйл ажиллагааны макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн үр нөлөөг тодорхойлох.</p>

	iii. Төгс өрсөлдөөнт зах зээл, монополь өрсөлдөөнт зах зээл, монополь болон олигархи зэрэг зах зээлийн бүтцийн ялгаатай төрлүүдийг тодорхойлох.
(к) Бизнесийн стратеги болон удирдлага	i. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг хийж болох олон төрлийн арга замыг тодорхойлох.
(Дунд түвшин)	ii. Байгууллагын үйл ажиллагааны болон бүтцийн ялгаатай нэгжүүдийн зорилго болон ач холбогдлыг тодорхойлох.
	iii. Байгууллагын стратегид нөлөөлж болохуйц гадаад болон дотоод хүчин зүйлийг шинжлэх.
	iv. Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд ашиглах үйл явцуудыг тодорхойлох.
	v. Хувь хүн, баг, хамт олон болон байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад байгууллагын зан төлөвийн онолыг хэрхэн ашиглахыг тодорхойлох.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт (Лав: А13-А14-р параграф)

8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь БОУС–ын сургалтын үр дүнг амжилттай байлгахын тулд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрүүдийг тогтмол хянаж шинэчлэх ёстой.

Техникийн Чадавхын Үнэлгээ (Лав: А15-А16-р параграф)

9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн техникийн чадавхыг үнэлэх зохистой үнэлгээний аргыг тодорхойлох ёстой.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-4-р параграф)

- A1. МАШХ-ийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлсэн хувь хүнийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч гэнэ. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэхэд чиглэсэн чадавхыг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд олгодог анхны сургалт болон хөгжүүлэлт юм. МАШХ нь ерөнхий боловсрол дээр үндэслэдэг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр, практик туршлага, болон үнэлгээ зэрэг багтдаг. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн эзэмших хүртэл үргэлжилдэг.
- A2. Олон улсын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэшлийн (эсвэл лиценз) зэргийг тодорхойлох хууль эрх зүйн болон зохицуулалтын мэдэгдэхүйц ялгаанууд байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллага бүр гишүүдийнхээ мэргэшлийн (эсвэл лиценз) зэрэг болон МАШХ-ийн төгсгөлийн хоорондох зохистой харилцааг тодорхойлдог.
- A3. МАШХ-д техникийн чадавхыг оруулах нь мэргэжлийн нягтлан бодогч болох үүргийг гүйцэтгэх суурийг тавьдаг. Техникийн чадавхыг цаашид хөгжүүлэх асуудал нь Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (МТХ) бөгөөд үүнийг *БОУС 7 Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (2014)*-д тусгасан.
- A4. Мэргэжлийн чадавхыг тайлбарлах болон ангилах олон ялгаатай арга зам байдаг. БОУС-ын хүрээнд мэргэжлийн чадавх гэдэг нь тодорхой стандартын дагуу үүрэг гүйцэтгэх чадавх юм. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандартууд, үзэл баримтлалууд, агуулга, баримт болон горим журмаас илүү бөгөөд энэ нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлагын нэгдэл болон хэрэглээ байдаг.
- A5. Чадавхын хамрах хүрээ гэдэг нь сургалтын үр дүнг тодорхойлсон ангилал юм. Техникийн чадавхын хүрээнд санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, татвар ба эдийн засаг мэргэжлийн ур чадварын хүрээнд оюуны болон зохион байгуулалтын ур чадварууд, мөн мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлагын ур чадварын хүрээнд мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн үнэлэмж зэрэг ёс суртахууны зарчмууд орно.
- A6. Сургалтын үр дүн нь тодорхой чадавхын хүрээн дэх бүлгүүдэд шаардлагатай мэдлэг, ойлголт, хэрэглээний гүнзгийрүүлсэн агуулгыг тодорхойлно. Сургалтын үр дүнг ажлын орчин эсвэл мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд авч үздэг.

Зорилго (Лав: 6-р параграф)

- A7. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих техникийн чадавхыг тодорхойлох нь хэд хэдэн зорилготой. Энэ нь олон нийтийн эрх ашгийг хамгаалж, мэргэжлийн нягтлан бодогчийн ажлын чанарыг дээшлүүлж мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг.

Техникийн Чадавхын Сургалтын Үр Дүн (Лав: 7-р параграф)

- A8. Хүснэгт А-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн цаашдын нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн чиглэл эсвэл гүйцэтгэх үүргээс үл хамааран эзэмшвэл зохих техникийн чадавхыг жагсаасан. Эдгээр сургалтын үр дүн нь мэргэжлийн нягтлан бодогчдод аудитын гэрээт ажлын түнш, татварын мэргэжилтэн гэх зэргээр нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үүрэг гүйцэтгэхэд шаардагдах суурийг хангаж өгдөг.
- A9. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн загварын хувьд Хүснэгт А-д харуулсан 11 чадавхын хамрах хүрээ нь тодорхой нэг курс, хичээлийн нэртэй яг адилхан биш байж болно. Түүнчлэн, нэг ур чадварын хүрээтэй холбоотой сургалтын үр дүн нь нэг ба түүнээс дээш сургалтад эсвэл хичээлд хамрагдсанаар эзэмшихээр байж болно. Жишээ нь, санхүүгийн нягтлан бодох бүртгэл ба тайлагналын сургалтын үр дүнг хоёр ба түүнээс дээш тооны санхүүгийн нягтлан бодох бүртгэл ба тайлагналын сургалт эсвэл хичээлүүдэд хамрагдан эзэмшиж болно. Зарим сургалтын үр дүнгийн эзэмшвэл зохих мэдлэг нь хэд хэдэн өөр сургалтууд болон хичээлүүдээр дамжин хэрэгжиж болох бөгөөд эдгээрийн аль нь ч тухайн ур чадварын хүрээнд дангаараа зориулагдаагүй байж болно. Жишээлбэл, мэдээллийн технологийн сургалтын үр дүнд удирдлагын нягтлан бодох бүртгэл, аудит болон баталгаажуулалтын хичээлүүдээр сургалтын холбогдох материалыг нэгтгэх замаар хүрч болно. Түүнчлэн, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсролын хөтөлбөрт хамрагдах ур чадварыг эзэмших дараалал нь Хүснэгт А-д үзүүлсэн дарааллаас ялгаатай байж болно. Жишээ нь, эдийн засаг нь Хүснэгт А-д ур чадварын хүрээийн жагсаалтын төгсгөлд байдаг боловч мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн явцад нэлээд эрт судалсан байж болно.
- A10. Ур чадварын түвшнийг тодорхойлох болон ангилах олон төрлийн арга зам байдаг. НББОУСЗ-ийн боловсруулсан тодорхойлолтыг Хавсралт 1 *Ур Чадварын Түвшний Тодорхойлолт*-д заасан.
- A11. Хүснэгт А-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих ур чадварын түвшинг чадавх тус бүрээр нь тогтоосон байдаг. Энэхүү түвшний ур чадвар нь холбогдох сургалтын үр дүнд эзэмшвэл зохих агуулгыг тусгасан. Сургалтын үр дүн болон чадавхын хамрах хүрээний ур чадварын түвшин нь хамтдаа ДНБХ-ны гишүүн байгууллагуудыг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрөө боловсруулахад нь мэдээллээр хангаж тусалдаг.
- A12. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт дараах зүйлсийг тусгаж болно. Үүнд: (а) нэмэлт чадавхын хамрах хүрээг оруулах; (б) ур чадварын түвшнийг зарим чадавхын хүрээнд өсгөх; эсвэл (в) энэхүү БОУС-д заагаагүй нэмэлт сургалтын үр дүнг боловсруулах зэрэг орно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид тодорхой нэг салбарт (жишээ нь, улсын сектор) эсвэл тодорхой үүрэг гүйцэтгэх үед (жишээ нь, удирдлагын нягтлан бодогч эсвэл аудитор) эдгээр нэмэлт зүйлсийг тусгаж болно.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт (Лав: 8-р параграф)

- A13. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд МАШХ-ийн эцэст зохих мэргэжлийн чадавхыг

эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд боловсруулдаг. Эдгээр хөтөлбөрүүдэд их дээд сургуулиуд, бусад дээд боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд, ажил олгогчид, мөн ажлын байран дахь сургалт албан ёсны мэргэшлийн болон сургалтаар олж авсан хөтөлбөрүүдийг багтаадаг. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн загварт ДНБХ-ны гишүүн байгууллагуудаас бусад оролцогч талуудын нэлээдгүй саналыг оруулж болно.

- A14. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг тогтмол хянаж, шинэчилж байх шаардлага нь мэргэжлийн нягтлан бодогч үйл ажиллагаа явуулж буй хурдацтай өөрчлөгдөж байгаа болон нарийн төвөгтэй орчны нөлөөг тусгахад чиглэдэг. Ердийн хяналтын мөчлөг нь гурваас таван жилийн хооронд байх боловч мэргэжлийн нягтлан бодогчдод хамааралтай хууль тогтоомж, дүрэм журам болон стандартад гарсан өөрчлөлтийн улмаас илүү их давтамжтай байх нь зохистой байж болно.

Техникийн Чадавхын Үнэлгээ (Лав: 9-р параграф)

- A15. БОУС 6 *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт -Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ*-нд техникийн чадавх болон бусад мэргэжлийн чадавхын элементүүдийг үнэлэхэд ашигладаг үнэлгээний загварыг боловсруулах зарчмыг тусгасан байдаг.
- A16. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн техникийн чадавхыг олон төрлөөр үнэлж болно. Зохистой үнэлгээний дараах аргууд байж болно. Үүнд: (а) товч хариулахыг шаардсан асуултуудаас бүрдсэн бичгийн шалгалтууд, (б) кейс дасгалууд, (в) эссэ бичих, (г) зорилтот шалгалт, (д) ажлын байрны үнэлгээ, болон (е) МАШХ-ээс чөлөөлөх эрхийг олгосон өмнөх сургалтын үр дүн зэрэг орно.

Хавсралт 1

Ур Чадварын Түвшний Тодорхойлолт:

Энэхүү ур чадварын түвшний тодорхойлолт нь НББОУСЗ-өөс баталсан Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС) 2, 3, 4-үүдэд тусгасан сургалтын үр дүнг тодорхойлсон. Үүнд ур чадварын гурван түвшинг тодорхойлсон. Эдгээр тодорхойлолтууд нь сургалтын үр дүнгийн хамтаар мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үүрэг гүйцэтгэх болон өөр өөр чиглэлээр ажиллахад зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад гишүүн байгууллагад хэрэглэгдэнэ.

Ур Чадварын Түвшин	Тодорхойлолт
Суурь түвшин	<p>Ерөнхийдөө суурь түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Зохистой удирдлагын дагуу ажиллахдаа үүрэг даалгавраа гүйцэтгэхийн тулд техникийн чадавхын хүрээтэй холбоотой үндсэн зарчим болон томъёоллыг тодорхойлох, тайлбарлах, нэгтгэх; • Зохистой мэргэжлийн ур чадварыг ашиглан өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх; • Өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын ач холбогдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх; • Энгийн асуудлуудыг шийдвэрлэх, мөн нарийн төвөгтэй ажил эсвэл асуудлуудыг удирдлага эсвэл мэргэжлийн хүмүүст хүргүүлэх; • Аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Суурь түвшний сургалтын үр дүнд бага түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Дунд түвшин	<p>Ерөнхийдөө дунд түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил гүйцэтгэх болон шийдвэр гаргахдаа холбогдох техникийн чадавхын хүрээний үндсэн зарчим болон томъёоллыг бие дааж хэрэглэх, харьцуулах болон шинжлэх; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ тулд техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг хослуулах; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хэрэглэх; • Нягтлан бодох бүртгэлийн болон бусад оролцогч талуудад аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Дунд түвшний сургалтын үр дүнд дунд зэргийн ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Ахисан түвшин	<p>Ерөнхийдөө ахисан түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдах, мөн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зөвлөгөө өгөхийн тулд олон төрлийн техникийн чадавхаас зохистой зарчим болон томъёоллыг сонгох болон нэгтгэх; • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдахдаа техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг нэгтгэх; • Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бодитоор хэрэгжүүлэх тохиолдолд мэргэжлийн шийдвэр гаргах;

	<ul style="list-style-type: none">• Хязгаарлагдмал хяналттай нарийн төвөгтэй асуудлыг үнэлэх, судлах болон шийдвэрлэх;• Нарийн төвөгтэй асуудлыг урьдчилан таамаглах, зөвлөх болон шийдлийг боловсруулах;• Олон төрлийн оролцогч талуудад холбогдох мэдээллийг өргөн хүрээтэй, итгэл үнэмшилтэй тайлбарлах. <p>Ахисан түвшний сургалтын үр дүнд ахисан түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
--	---

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 3

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ- МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР (2015)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1-4
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	5
Зорилго.....	6
Шаардлага	
Мэргэжлийн Ур Чадварын Сургалтын Үр Дүн.....	7
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт	8
Мэргэжлийн Ур Чадварын Үнэлгээ.....	9
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1-A7
Зорилго	A8
Мэргэжлийн Ур Чадварын Сургалтын Үр Дүн.....	A9-A14
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт	A15-A16
Мэргэжлийн Ур Чадварын Үнэлгээ.....	A17-A19
Хавсралт 1: Ур Чадварын Түвшний Тодорхойлолт	

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А1–А7-р параграф)

1. Мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлт (МАШХ)-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварыг энэхүү БОУС-д тодорхойлсон. Мэргэжлийн ур чадвар нь мэргэжлийн нягтлан бодогчийн техникийн чадавх болон мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын хамт хэрэглэх (а) оюуны, (б) хувийн болон олон нийтийн харилцаа, (в) хувийн, (г) зохион байгуулалтын ур чадвар тус тус орно.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд МАШХ нь энэхүү БОУС-ын шаардлагад нийцсэн байх нөхцлийг хангах үүрэгтэй. Үүнээс гадна, БОУС нь боловсролын байгууллагууд, ажил олгогчид, хууль эрхзүйн зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллагууд, ба мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн сургалт ба хөгжлийн үйл явцыг дэмждэг бусад оролцогч талуудад хэрэгцээтэй байдаг.
3. Энэхүү БОУС-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих техникийн чадавхыг бүрэн тодорхойлох чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхой заасан. *БОУС 3, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Ур Чадвар (2015)*, ба *БОУС 4, Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагууд (2015)* гэсэн стандартуудад МАШХ-тэй чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхой заасан. Эдгээр БОУС-ууд нь хамтдаа МАШХ-ийн төгсгөлд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих чадавхын хамрах хүрээ болон сургалтын үр дүнг тодорхойлсон.
4. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчид болон Мэргэжлийн Нягтлан Бодогч болохыг Эрмэлзэгчдийн Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал (2015)*-д ашигласан нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр томъёоны тайлбар (2015)*-т багтсан болно.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

5. Энэхүү БОУС-ыг 2015 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго (Лав: А8-р параграф)

6. Мэргэжлийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэхийн тулд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид МАШХ-ийн эцэст эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварыг тодорхойлоход энэхүү стандартын зорилго оршино.

Шаардлагууд

Мэргэжлийн Ур Чадварын Сургалтын Үр Дүн (Лав: А9-А14-р параграф)

ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих мэргэжлийн ур чадварын сургалтын үр дүнг тодорхойлох ёстой. Эдгээр сургалтын үр дүнд эзэмших ур чадварыг Хүснэгт А-д харуулав.

Хүснэгтт А: Мэргэжлийн Ур Чадварын Сургалтын Үр Дүн

Чадавхын Хамрах Хүрээ (Ур Чадварын Түвшин ¹)	Сургалтын Үр Дүн
(а) Оюуны ур чадвар (Дунд түвшин)	i. Мэдээллийг төрөл бүрийн эх сурвалж ба судалгаа, шинжилгээ болон нэгтгэлийн үндсэн дээр үнэлэх. ii. Холбогдох бүх баримт, нөхцөл байдалд тулгуурлан үндэслэл сайтай дүгнэлт гаргахын тулд сонголтуудыг тодорхойлж үнэлэхэд мэргэжлийн шийдлийг ашиглах. iii. Дүгнэлт гаргах болон асуудлыг шийдвэрлэхэд хэзээ мэргэжилтнээс зөвлөгөө авахыг тодорхойлох. iv. Асуудлыг шийдвэрлэхэд шалтгааныг олж, нарийн дүн шинжилгээ, шинэлэг сэтгэлгээг ашиглах. v. Зохион байгуултгүй, олон талт асуудлыг шийдвэрлэх шийдлийг санал болгох.
(б) Хувийн болон олон нийтийн харилцаа (Дунд түвшин)	i. Байгууллагын зорилгод хүрэхийн тулд хамтын ажиллагааг дэмжих ба багаар ажиллах. ii. Аман болон бичгэн хэлбэрийг ашиглан, илтгэх үедээ тодорхой бөгөөд товчхон ярих, албан болон албан бус нөхцөлд асуудлыг танилцуулах, хэлэлцүүлэх. iii. Бүхий л харилцааны үед хэл, соёлын ялгааны талаар мэдлэгтэй байх. iv. Идэвхтэй сонсох, үр дүнтэй ярилцлагын аргыг ашиглах. v. Гэрээ хэлэлцээр хийх, шийдэлд хүрэхийн тулд хэлцлийн ур чадварыг ашиглах. vi. Зөрчилдөөнийг багасгах эсвэл шийдвэрлэх, асуудлыг шийдэх, мөн бусад боломжийг нэмэгдүүлэхийн тулд зөвлөгөөний ур чадварыг ашиглах. vii. Дэмжлэг үзүүлэх болон итгэл үнэмшил төрүүлэх хэмжээнд санаагаа илэрхийлэх болон бусдад нөлөөлөх.
(в) Хувийн (Дунд түвшин)	i. Насан туршид суралцах тэмүүлэлтэй байх. ii. Бүх төрлийн мэдээллийг үнэлэхдээ асуулт асууж, нарийн үнэлгээ хийх замаар мэргэжлийн үл итгэх үзлийг хэрэглэх. iii. Бусдын санал сэтгэгдлийг сонсож, түүнийг хүлээж авах замаар хувийн гүйцэтгэлийг дүгнэх, өөрийн гэсэн өндөр стандартыг тогтоож, хяналт тавих. iv. Мэргэжлийн үүрэг, даалгаврыг амжилттай гүйцэтгэхийн тулд цаг хугацаа болон нөөц боломжоо удирдах. v. Хүндрэлийг урьдчилан таамаглаж боломжит шийдлийг төлөвлөх. vi. Шинэ боломжид нээлттэй сэтгэлгээгээр хандах.
(г) Зохион байгуулалт (Дунд түвшин)	i. Ажил гүйцэтгэх эцсийн хугацаанд амжихын тулд тогтсон практикын дагуу өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх. ii. Өөрийн төдийгүй мөн бусдын ажил байгууллагын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг дүгнэх.

¹ МАШХ-ийн эцэст эзэмшсэн байвал зохих чадавхын цар хүрээнд хамаарах ур чадварын түвшин (Хавсралт 1-д тодорхойлсон).

	iii. Бусдыг урамшуулах, хөгжүүлэхийн тулд хүний нөөцийн менежментийн ур чадварыг ашиглах.
	iv. Ажил үүргийг гүйцэтгэхэд чиглүүлэх ур чадварыг ашиглах.
	v. Байгууллагын зорилгод хүрэхийн тулд удирдах ур чадварыг ашиглан бусдад нөлөөллөх.
	vi. Бүтээмж болон үр дүнг нэмэгдүүлэх болон шийдвэр гаргалтыг сайжруулахад тохирох арга хэрэгсэл, технологийг ашиглах.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрүүдийн Хяналт (Лав: А15-А16-р параграф)

8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь БОУС–ын сургалтын үр дүнг амжилттай байлгахын тулд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрүүдийг тогтмол хянаж шинэчлэх ёстой.

Мэргэжлийн Ур Чадварын Үнэлгээ (Лав: А17-А19-р параграф)

9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн техникийн чадавхыг үнэлэх зохистой үнэлгээний аргыг тодорхойлох ёстой.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-4-р параграф)

- A1. МАШХ-ийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлсэн хувь хүнийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч гэнэ. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэхэд чиглэсэн чадавхыг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд олгодог анхны сургалт болон хөгжүүлэлт юм. МАШХ нь ерөнхий боловсрол дээр үндэслэдэг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр, практик туршлага, болон үнэлгээ зэрэг багтдаг. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийг эзэмших хүртэл үргэлжилдэг.
- A2. Олон улсын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэшлийн (эсвэл лиценз) зэргийг тодорхойлох хууль эрх зүйн болон зохицуулалтын мэдэгдэхүйц ялгаанууд байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллага бүр гишүүдийнхээ мэргэшлийн (эсвэл лиценз) зэрэг болон МАШХ-ийн төгсгөлийн хоорондох зохистой харилцааг тодорхойлдог.
- A3. Мэргэжлийн чадавхыг тайлбарлах олон ялгаатай арга зам байдаг. БОУС-ын хүрээнд, мэргэжлийн чадавх гэдэг нь тогтоосон стандартын дагуу үүрэг гүйцэтгэх чадвар юм. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандарт, үзэл баримтлалууд, баримт нотолгоо, болон үйл явцын мэдлэгээс илүү бөгөөд энэ нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлагын нэгдэл болон хэрэглээ байдаг.
- A4. МАШХ-д мэргэжлийн ур чадварыг оруулах нь мэргэжлийн нягтлан бодогч болох үүргийг гүйцэтгэх суурийг тавьдаг. Мэргэжлийн ур чадварыг цаашид хөгжүүлэх асуудал нь Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (МТХ) бөгөөд үүнийг БОУС 7 *Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (2014)*-д тусгасан.
- A5. Энэхүү БОУС-ы хүрээнд, мэргэжлийн ур чадварыг дараах 4 төрөлд хуваадаг:
- (а) *Оюун ухааны чадавх нь* гэдэгт мэргэжлийн нягтлан бодогчийн асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах болон мэргэжлийн шийдэл баримтлахыг;
 - (б) *Хувийн болон олон нийтийн харилцааны чадавх* гэдэгт мэргэжлийн нягтлан бодогчийн бусадтайгаа үр дүнтэйа жиллах болон харилцахыг;
 - (в) *Хувийн чадавх* гэдэгт мэргэжлийн нягтлан бодогчийн хувь хүний хандлага болон зан байдлыг;
 - (г) *Зохион байгуулалтын* чадавх гэдэгт мэргэжлийн нягтлан бодогч байгууллагын ажлыг хамгийн үр дүнтэйгээр хийж гүйцэтгэхийн тулд хүний болон боломжит нөөц бололцоог зөв зохистой ашиглахыг тус тус хэлнэ.
- A6. Чадавхын хамрах хүрээ гэдэг нь сургалтын үр дүнг тодорхойлсон ангилал юм. Мэргэжлийн ур чадварын хүрээнд оюуны болон зохион байгуулалтын ур чадвар, техникийн чадавхын хүрээнд санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, татвар ба эдийн засаг, мөн мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлагын ур чадварын хүрээнд мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн үнэлэмж зэрэг ёс зүйн зарчмууд орно.

- A7. Сургалтын үр дүн нь тодорхой чадавхын хүрээн дэх бүлгүүдэд шаардлагатай мэдлэг, ойлголт, хэрэглээний гүнзгийрүүлсэн агуулгыг тодорхойлно. Сургалтын үр дүнг ажлын орчин эсвэл мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд авч үздэг.

Зорилго (Лав: 6-р параграф)

- A8. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварыг тодорхойлох нь хэд хэдэн зорилготой. Энэ нь олон нийтийн эрх ашгийг хамгаалж, мэргэжлийн нягтлан бодогчийн ажлын чанарыг дээшлүүлж мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг.

Мэргэжлийн Ур Чадварын Сургалтын Үр Дүн (Лав: 7-р параграф)

- A9. Хүснэгт А-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн цаашдын нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн чиглэл эсвэл гүйцэтгэх үүргээс үл хамааран эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварыг жагсаасан. Эдгээр сургалтын үр дүн нь мэргэжлийн нягтлан бодогчдод аудитын гэрээт ажлын түнш, татварын мэргэжилтэн гэх зэргээр нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үүрэг гүйцэтгэхэд шаардагдах суурийг хангаж өгдөг.
- A10. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн загварын хувьд Хүснэгт А-д харуулсан 4 чадавхын хамрах хүрээ нь тодорхой нэг курс, хичээлийн нэртэй яг адилхан биш байж болно. Түүнчлэн, нэг ур чадварын хүрээтэй холбоотой сургалтын үр дүнг (жишээ нь, зохион байгуулалтын) нэг ба түүнээс дээш сургалтад эсвэл хичээлд хамрагдсанаар эзэмшихээр байж болно. Зарим сургалтын үр дүнгийн эзэмшвэл зохих мэдлэг нь (жишээ нь, оюун ухааны) нь хэд хэдэн өөр сургалтууд болон хичээлүүдээр дамжин хэрэгжиж болох бөгөөд эдгээрийн аль нь ч тухайн ур чадварын хүрээнд дангаараа зориулагдаагүй байж болно.
- A11. Ур чадварын түвшинг тодорхойлох болон ангилах олон төрлийн арга зам байдаг. НББОУСЗ-ийн боловсруулсан тодорхойлолтыг Хавсралт 1 *Ур Чадварын Түвшний Тодорхойлолт*-д заасан.
- A12. Хүснэгт А-д, МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих ур чадварын түвшинг чадавх тус бүрээр нь тогтоосон байдаг. Энэхүү түвшний ур чадвар нь холбогдох сургалтын үр дүнд эзэмшвэл зохих агуулгыг тусгасан. Сургалтын үр дүн болон чадавхын хамрах хүрээний ур чадварын түвшин нь хамтдаа ДНБХ-ны гишүүн байгууллагуудыг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрөө боловсруулахад нь мэдээллээр хангаж тусалдаг.
- A13. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт дараах зүйлсийг тусгаж болно. Үүнд, (а) нэмэлт чадавхын хамрах хүрээг оруулах; (б) ур чадварын түвшнийг зарим чадавхын хүрээнд өсгөх; эсвэл (в) энэхүү БОУС-д заагаагүй нэмэлт сургалтын үр дүнг боловсруулах зэрэг орно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид тодорхой нэг салбарт (жишээ нь, улсын сектор) эсвэл тодорхой үүрэг гүйцэтгэх үед (жишээ нь, удирдлагын нягтлан бодогч эсвэл аудитор) эдгээр нэмэлт зүйлсийг тусгаж болно.

A14. ДНБХ-ны гишүүн байгууллагууд, сурган хүмүүжүүлэгчид, болон бусад оролцогч талууд нь үндэсний болон соёлын орчныг харгалзан мэргэжлийн ур чадвар сургалт, хөгжүүлэлтийн хамгийн оновчтой аргыг тодорхойлохыг дэмждэг. Оновчтой арга гэдэг нь зохион байгуулалттай сургалтын хөтөлбөрүүд болон практик туршлагыг хослуулсан сургалтын болон хөгжүүлэлтийн үйл ажиллагааны хольцыг агуулсан байдаг. Жишээлбэл, мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн ажлын байран дахь мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд ажлын туршлагатай чиглүүлэгчид чухал үүргийг гүйцэтгэдэг.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт (Лав: 8-р параграф)

A15. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд МАШХ-ийн эцэст зохих мэргэжлийн чадавхыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд боловсруулдаг. Эдгээр хөтөлбөрүүдэд их дээд сургуулиуд, бусад дээд боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд, ажил олгогчид, мөн ажлын байран дахь сургалт албан ёсны мэргэшлийн болон сургалтаар олж авсан хөтөлбөрүүдийг багтаадаг. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн загварт ДНБХ-ны гишүүн байгууллагуудаас бусад оролцогч талуудын нэлээдгүй саналыг оруулж болно.

A16. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг тогтмол хянаж, шинэчилж байх шаардлага нь мэргэжлийн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулж буй хурдацтай өөрчлөгдөж байгаа болон нарийн төвөгтэй орчны нөлөөг тусгахад чиглэдэг. Ердийн хяналтын мөчлөг нь гурваас таван жилийн хооронд байх боловч мэргэжлийн нягтлан бодогчдод хамааралтай хууль тогтоомж, дүрэм журам болон стандартад гарсан өөрчлөлтийн улмаас илүү их давтамжтай байх нь зохистой байж болно.

Мэргэжлийн Ур Чадварын Үнэлгээ (Лав: 9-р параграф)

A17. БОУС 6, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ* (2015)-нд мэргэжлийн ур чадвар болон бусад мэргэжлийн чадавхын элементүүдийг үнэлэхэд ашигладаг үнэлгээний загварыг боловсруулах зарчмыг тусгасан байдаг.

A18. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн ур чадварыг олон төрлөөр үнэлж болно. Ажлын байрны загварчлал болон багаар ажиллах дасгалууд нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч нарт хамаарах мэргэжлийн ур чадвартай холбоотой сургалтын үр дүнг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны жишээнүүд юм. Практик туршлага нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид өөрсдийн мэргэжлийн ур чадвараа харуулахын тулд үнэлгээний үйл ажиллагаанд оролцох боломжийг олгодог. Эдгээр үйл ажиллагаануудын жишээнд (а) өдрийн тэмдэглэл хөтлөх, (б) 360 градусын үнэлгээнд оролцох, (в) эзэмшвэл зохих сургалтын үр дүнд хүрсэнийг нотлох баримт бэлдэх, эсвэл (г) практик туршлагатай чиглүүлэгчийн удирлаган дор ажиллах зэрэг орно.

A19. Ажлын байран дахь мэргэжлийн ур чадварын үнэлгээ нь найдвартай байдал, хууль ёсны, өмч хөрөнгө, ил тод байдал болон хангалттай байдал зэргийг өндөр түвшинд

хангахын тулд бичгийн шалгалтаас ялгаатай аргыг шаарддаг. Жишээлбэл, үнэлгээний дараах аргууд байж болно. Үүнд:

- (a) Үнэлгээний тодорхойгүй байдлыг хамгийн бага байлгах, мөн ил тод байдал болон найдвартай байдлын нэмэгдүүлэхийн тулд тодорхой, нарийвчилсан сургалтын үр дүнг тодорхойлох;
- (б) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг үнэлэх ажлын байрны үнэлээчдийг сургах; болон
- (в) Мэргэжлийн ур чадварыг хангалттай, найдвартай болон тэгш үнэлэх ажлын байрны загвар боловсруулах.

Хавсралт 1

Ур Чадварын Түвшний Тодорхойлолт:

Энэхүү ур чадварын түвшний тодорхойлолт нь НББОУСЗ-өөс баталсан Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС) 2, 3, 4-үүдэд тусгасан сургалтын үр дүнг тодорхойлсон. Үүнд, ур чадварын гурван түвшинг тодорхойлсон. Эдгээр тодорхойлолтууд нь сургалтын үр дүнгийн хамтаар мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үүрэг гүйцэтгэх болон өөр өөр чиглэлээр ажиллахад зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад гишүүн байгууллагад хэрэглэгдэнэ.

Ур Чадварын Түвшин	Тодорхойлолт
Суурь түвшин	<p>Ерөнхийдөө суурь түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Зохистой удирдлагын дагуу ажиллахдаа үүрэг даалгавраа гүйцэтгэхийн тулд техникийн чадавхын хүрээтэй холбоотой үндсэн зарчим болон томъёоллыг тодорхойлох, тайлбарлах, нэгтгэх; • Зохистой мэргэжлийн ур чадварыг ашиглан өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх; • Өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын ач холбогдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх; • Энгийн асуудлуудыг шийдвэрлэх, мөн нарийн төвөгтэй ажил эсвэл асуудлуудыг удирдлага эсвэл мэргэжлийн хүмүүст хүргүүлэх; • Аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Суурь түвшний сургалтын үр дүнд бага түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Дунд түвшин	<p>Ерөнхийдөө дунд түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил гүйцэтгэх болон шийдвэр гаргахдаа холбогдох техникийн чадавхын хүрээний үндсэн зарчим болон томъёоллыг бие дааж хэрэглэх, харьцуулах болон шинжлэх; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ тулд техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг хослуулах; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хэрэглэх; • Нягтлан бодох бүртгэлийн болон бусад оролцогч талуудад аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Дунд түвшний сургалтын үр дүнд дунд зэргийн ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Ахисан түвшин	<p>Ерөнхийдөө ахисан түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдах, мөн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зөвлөгөө өгөхийн тулд олон төрлийн техникийн чадавхаас зохистой зарчим болон томъёоллыг сонгох болон нэгтгэх; • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдахдаа техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг нэгтгэх; • Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бодитоор

	<p>хэрэгжүүлэх тохиолдолд мэргэжлийн шийдвэр гаргах;</p> <ul style="list-style-type: none">• Хязгаарлагдмал хяналттай нарийн төвөгтэй асуудлыг үнэлэх, судлах болон шийдвэрлэх;• Нарийн төвөгтэй асуудлыг урьдчилан таамаглах, зөвлөх болон шийдлийг боловсруулах;• Олон төрлийн оролцогч талуудад холбогдох мэдээллийг өргөн хүрээтэй, итгэл үнэмшилтэй тайлбарлах. <p>Ахисан түвшний сургалтын үр дүнд ахисан түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
--	--

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 4

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ - МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ, ЁС ЗҮЙ БА ХАНДЛАГА (2015)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1–6
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	7
Зорилго.....	8
Шаардлагууд	
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Хамрах Хүрээ.....	9
Холбогдох Ёс Зүйн Шаардлагууд.....	10
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Талаарх Сургалтын Үр Дүн.....	11
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт.....	12
Эргэцүүлэх Үйл Явц.....	13
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Үнэлгээ.....	14
Тайлбар Материал	
ДНБХ-ны Тунхаглалд багтсан Тодорхойлолтуудын Тайлбар.....	A1–A2
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A3–A11
Зорилго.....	A12
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Хамрах Хүрээ.....	A13–A15
Холбогдох Ёс Зүйн Шаардлагууд.....	A16
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Талаарх Сургалтын Үр Дүн.....	A17–A31
Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт.....	A32–A33
Эргэцүүлэх Үйл Явц.....	A34–A38
Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Үнэлгээ.....	A39–A42

Хавсралт 1: Ур Чадварын Түвшний Тодорхойлолт

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А3–А11-р параграф)

1. Энэхүү БОУС нь мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлт (МАШХ)-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн суралцах шаардлагатай мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын сургалтын үр дүнг тодорхойлно. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогчдыг мэргэжлийн гишүүд болгож буй шинж чанар юм. Үүнд мэргэжлийн зан төлвийн ялгаатай шинж чанарыг тодорхойлоход чухалд тооцогдох, ерөнхий холбогдолтой ёс зүйн зарчмууд багтана.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагуудын зүгээс МАШХ-ыг энэхүү БОУС-ын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Үүнээс гадна, уг БОУС нь боловсролын байгууллагууд, ажил олгогчид, зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллагууд болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн сургалт, хөгжүүлэлтийн үйл явцыг дэмждэг бусад оролцогч талуудад хэрэгцээтэй байдаг.
3. Мэргэжлийн нягтлан бодогчийн суралцаж хөгжих үйл явц карьерынх нь туршид үргэлжлэх бөгөөд мэргэжлийн нягтлан бодогчдын карьерт өөрчлөлт орж, тэд илүү өргөн хүрээнд ёс зүйн асуудалд өртөж байгаа тул МАШХ-ийн явцад олж авсан мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага нь мөн Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (МГХ)-өөс хамааралтай.
4. Энэхүү БОУС нь холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролд хамааруулсан байдаг. Эдгээр холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэргэжлийн ёс зүйн үндсэн 5 зарчмуудад хуваадаг. Үүнд: шударга байдал, бодит байдал, мэргэжлийн чадавх ба хянамгай байдал, нууцлалыг хадгалах болон мэргэжлийн зан төлөв.
5. Энэхүү БОУС-д МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг тодорхойлсон чадавхын цар хүрээ болон сургалтын үр дүнг тодорхой заасан. БОУС 2, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Техникийн Чадавх* (2015), БОУС 3, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Ур Чадвар* (2015) стандартуудад МАШХ-д багтсан анхаарал хандуулах гол чиглэлүүдтэй холбоотой сургалтын үр дүн болон чадавхын цар хүрээг заасан байдаг. Эдгээр БОУС-ууд нь хамтдаа МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих мэргэжлийн чадавхыг тодорхойлсон сургалтын үр дүн болон чадавхын цар хүрээг тодорхой заасан байдаг.
6. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчид ба Мэргэжлийн Нягтлан Бодогчид болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал* (2015)-д ашигласан гол нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр Томъёоны Тайлбар* (2015)-т багтаасан болно. Аудит ба Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөл (АБОУСЗ)-ийн тунхаглалын нэмэлт нэр томъёог Тайлбар Материал хэсэгт оруулсан.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

7. Энэхүү БОУС-ыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөнө.

Зорилго (Лав: А12-р параграф)

8. Энэхүү БОУС-ын зорилго нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргээ биелүүлэхийн тулд МАШХ-ийн эцэст эзэмшиж хөгжүүлсэн байвал зохих мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бий болгоход оршино.

Шаардлагууд

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Хамрах Хүрээ (Лав: А13-А15-р зүйл)

9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд (а) мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх, болон (б) олон нийтийн ашиг сонирхлын үүднээс ёс суртахуунтай ажиллахад нь зориулж мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын хамрах хүрээг мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлж өгөх шаардлагатай.

Холбогдох Ёс Зүйн Шаардлагууд (Лав: А16-р параграф)

10. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт холбогдох ёс зүйн шаардлагуудыг тусгасан байх шаардлагатай.

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Талаарх Сургалтын Үр Дүн (Лав: А17-А31-р параграф)

11. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшсэн байвал зохих мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын талаарх сургалтын үр дүнг тодорхойлно. Эдгээр сургалтын үр дүнд хүснэгт А-д багтсан зүйлсийг хамруулна.

Хүснэгт А: Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Талаарх Сургалтын Үр Дүн

Чадавхын Цар Хүрээ (Ур Чадварын Түвшин ¹)	Сургалтын Үр Дүн
(а) Мэргэжлийн үл итгэх үзэл ба мэргэжлийн үнэлэмж (Дунд түвшин)	(i) Санхүүгийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг үнэлэхдээ шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах.
	(ii) Холбогдох бүх баримт болон нөхцөл байдалд үндэслэн сайтар үндэслэлтэй дүгнэлт гаргахын тулд боломжит хувилбаруудыг тодорхойлж үнэлэх.
(б) Ёс зүйн зарчмууд	(i) Ёс зүйн мөн чанарыг тайлбарлах.
	(ii) Дүрэмд суурилсан болон зарчимд суурилсан ёс зүйн хандлагын давуу болон сул талуудыг тодорхойлох.
	(iii) Ёс зүйн асуудлуудыг тогтоож, ямар үед ёс зүйн зарчмуудыг ашиглахыг тодорхойлох.
	(iv) Авах боломжтой арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн ёс зүйн үр дагаврыг тодорхойлох.
	(v) Шударга, бодитой, мэргэжлийн чадавхтай, хянамгай байх, нууцлалыг хадгалах зэрэг ёс зүйн үндсэн зарчмууд болон мэргэжлийн зан төлвийг

¹ МАШХ-ийн эцэст эзэмшсэн байвал зохих чадавхын цар хүрээнд хамаарах ур чадварын түвшин (Хавсралт 1-д тодорхойлсон).

	ёс зүйн асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглаж, зохистой арга хандлагыг тодорхойлох.
	(vi) Стандартуудад ² нийцүүлэн холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэргэжлийн зан төлөвт ашиглах.
(в) Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг (Дунд түвшин)	(i) Мэргэжлийн үүднээс болон нийгмийн хариуцлагын ойлголттой холбоотойгоор ёс зүйн үүргийг тодорхойлох.
	(ii) Бизнес болон сайн засаглалтай холбоотой ёс зүйн үүргийг тодорхойлох.
	(iii) Хууль болон ёс зүйн хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх. Үүнд, хууль тогтоомж, журам болон олон нийтийн ашиг сонирхлын хоорондох харилцан хамаарлыг оруулна.
	(iv) Хувь хүн, мэргэжил болон олон нийтэд ёс зүйгүй зан төлөв гаргасны үр дагаварт дүн шинжилгээ хийх.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт (Лав: А32-А33-р параграф)

12. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь энэхүү БОУС-д тусгасан сургалтын үр дүнд хүрэхэд чиглэсэн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг тогтмол хянаж шинэчлэх үүрэгтэй.

Эргэцүүлэх Үйл Явц (Лав: А34-А38-р параграф)

13. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зориулж албажуулж баримтжуулсан байдлаар эргэцүүлэх үйл явцыг хамруулан мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын талаарх сургалт ба хөгжүүлэлтийн үйл ажиллагааг боловсруулна.

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Үнэлгээ (Лав: А39-А42-р параграф)

14. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг үнэлэх зохистой үнэлгээний үйл явцыг бий болгох ёстой.

² Эдгээр стандартуудад аудитын стандарт, нягтлан бодох бүртгэлийн стандарт болон мэргэжлийн нягтлан бодогчийн хийж буй ажилтай холбоотой бусад стандартууд багтана.

Тайлбар Материал

ДНБХ-ны Тунхаглалд Багтсан Тодорхойлолтуудын Тайлбар

- A1. АБОУСЗ-өөс гаргасан *Нэр Томьёоны Тайлбар*³ тодорхойлж, АБОУСЗ-ийн Тунхаглалд ашигласан дараах нэр томьёог БОУС-д ашиглана. Хүснэгт Б-д эдгээр нэр томьёо болон АБОУСЗ-өөс гаргасан *Нэр Томьёоны Тайлбар* дахь одоогийн тодорхойлолтыг харуулав.

Хүснэгт Б: БОУС 4-д Ашигласан АБОУСЗ-ийн Тодорхойлолтууд

Тодорхойлсон Нэр Томьёо	АБОУСЗ-өөс гаргасан <i>Нэр Томьёоны Тайлбар</i> дахь Тодорхойлолт
Мэргэжлийн үл итгэх үзэл	Алдаа эсвэл залилангаас үүдэн буруу илэрхийлсэн байж болзошгүй нөхцөл байдалд сэрэмжтэй үл итгэх сэтгэлгээгээр хандаж, нотолгоог шүүмжлэлтэйгээр үнэлэх хандлагыг хэлнэ
Мэргэжлийн үнэлэмж	Аудит, нягтлан бодох бүртгэл болон ёс зүйн стандартын хүрээнд аудитын гэрээт ажлын нөхцөл байдалд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргахдаа холбогдох сургалт, мэдлэг, туршлагыг ашиглахыг хэлнэ

- A2. АБОУСЗ-өөс гаргасан Тунхаглалд олон улсын стандартын дагуу хэрэгжүүлж буй аудит, шалгалт, баталгаажуулалт болон холбогдох гэрээт үйлчилгээг журамладаг. Иймд АБОУСЗ-өөс гаргасан Тунхаглалд “мэргэжлийн үл итгэх үзэл” болон “мэргэжлийн үнэлэмж”-ийн талаарх тайлбарууд нь агуулгын хувьд аудит, баталгаажуулалт болон холбогдох гэрээт үйлчилгээний хүрээнд хязгаарлагдсан байдаг. Гэхдээ энэхүү БОУС-д мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг илүү өргөн агуулгын хүрээнд авч үзэж, эдгээр нэр томьёог тайлбарлах болно.

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-6-р параграф)

- A3. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч гэж МАШХ-ийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлсэн хувь хүн юм. МАШХ гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч нь мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд тэргүүн ээлжинд шаардлагатай чадавхыг эзэмших сургалт, хөгжүүлэлтийг хэлнэ. МАШХ нь ерөнхий боловсрол дээр суурилах бөгөөд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсрол, практик туршлага, болон үнэлгээ зэргийг хамардаг. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр өөрсдийн сонгосон ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн чадавхыг эзэмших хүртэл үргэлжилнэ.
- A4. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогчдыг мэргэжлийн гишүүд болгож буй мэргэжлийн зан төлөв болон шинж чанарыг хэлнэ. Үүнд, мэргэжлийн зан төлвийн ялгаатай шинж чанарыг тодорхойлоход чухалд тооцогдох, ерөнхий холбогдолтой ёс зүйн зарчмууд багтана.
- A5. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагад дараах чанарууд багтана: (а) техникийн чадавх ба мэргэжлийн ур чадварууд, (б) ёс суртахууны зан төлөв (жишээ нь, хараат бус, бодитой, шударга байх, нууцлалыг хадгалах), (в) мэргэжлийн арга барил (жишээ нь, хянамгай байх, цаг хугацааг баримтлах, эелдэг найрсаг, хүндэтгэлтэй, хариуцлагатай, найдвартай байх), (г) илүү шилдэг болоход тэмүүлэх (жишээ нь, тасралтгүй хөгжиж,

³ Нэр Томьёоны Тайлбар, *АБОУСЗ-ийн Чанарын Хяналт, Аудит, Шалгалт, Бусад Баталгаажуулалт ба Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага - 2016-2017 оны Хэвлэл, 1 дүгээр боть.*

насан туршдаа суралцахаар шийдэх), ба (д) нийгмийн хариуцлага (жишээ нь, олон нийтийн ашиг сонирхлыг ойлгож, анхаарч үзэх).

- A6. Холбогдох ёс зүйн шаардлагуудыг⁴ мэргэжлийн нягтлан бодогчдын мөрдөх ёстой ёс зүйн шаардлагууд хэмээн тодорхойлсон бөгөөд Нягтлан Бодогчдын Олон Улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөлөөс гаргасан *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм* (НБОУЭЗСЗ-ийн Дүрэм) болон аливаа үндэсний илүү хязгаарлагдмал шаардлагуудаас үндсэндээ бүрддэг.
- A7. Мэргэжлийн чадавхыг олон янзаар тодорхойлж, ангилж болно. БОУС-ын хүрээнд мэргэжлийн чадавх гэдэг нь ажил үүргийг тогтоосон стандартын дагуу гүйцэтгэх чадварыг хэлнэ. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандарт, үзэл баримтлал, баримт нотолгоо, үйл явцын талаарх мэдлэгээс илүү давсан ойлголт бөгөөд энэ нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага зэргийг хослуулан, ашиглахыг хэлнэ.
- A8. Олон улсын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчдын чадвар (лиценз)-ыг тодорхойлох тал дээр хууль эрх зүйн болон зохицуулалтын хувьд ихээхэн ялгаатай байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллага бүр өөрсдийн гишүүдийн хувьд МАШХ-ийг дуусгах болон мэргэжлийн чадвар (лиценз) эзэмших хоёрын хоорондох зохистой харьцааг тодорхойлж болно.
- A9. МАШХ-д мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг оруулснаар мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэх суурийг тавьдаг. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг цаашид улам хөгжүүлэх асуудал нь БОУС 7 *Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил* (2014)-д тусгасан МТХ-ийн гол чиглэл юм.
- A10. Чадавхын цар хүрээ гэдэг нь холбогдох цогц сургалтын үр дүнг тодорхойлсон ангилал юм. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын чадавхад ёс суртахууны зарчим, мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн үнэлэмжийг; техникийн чадавхад санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, татвар болон эдийн засгийн асуудлуудыг; мэргэжлийн ур чадварын хувьд чадавхад оюун ухааны болон зохион байгуулалтын ур чадварыг багтаана.
- A11. Сургалтын үр дүнд тодорхой чадавх тус бүрийн хувьд шаардлагатай мэдлэг, ойлголт, хэрэглээний талаарх агуулгыг нарийвчлан тодорхойлно. Ажлын орчинд эсвэл мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээнд сургалтын үр дүнд хүрч болно.

Зорилго (Лав: 8-р параграф)

- A12. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хөгжүүлж, эзэмших шаардлагатай мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бий болгох нь хэд хэдэн зорилготой. Энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, мэргэжлийн нягтлан бодогчдын ажлын чанарыг дээшлүүлж, мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг.

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Хамрах Хүрээ (Лав: 9-р параграф)

⁴ Нэр Томъёоны Тайлбар, АБОУСЗ-ийн Чанарын Хяналт, Аудит, Шалгалт, Бусад Баталгаажуулалт ба Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага - 2016-2017 оны Хэвлэл, 1 дүгээр боть.

- A13. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын хамрах хүрээг НБОУЁЗСЗ-ийн Дүрэм⁵-д тусгасан үзэл баримтлалын цар хүрээний хандлага зэрэг холбогдох ёс зүйн шаардлагуудаар тодорхойлж болно.
- A14. Мэргэжлийн нягтлан бодогчид нь холбогдох ёс зүйн шаардлагуудын дагуу олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах үүрэг хариуцлага хүлээнэ. Тиймээс мэргэжлийн нягтлан бодогчийн үйл ажиллагаа нь зөвхөн ганц үйлчлүүлэгч эсвэл ажил олгогчийн хэрэгцээг хангахад төвлөрдөггүй.
- A15. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг багтаасан сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг бий болгох замаар мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийг олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллахыг хөхүүлэн дэмждэг. Олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах гэдэгт (а) олон нийтэд үзүүлэх нөлөөг анхаарч, санаа тавих, (б) нийгмийн хариуцлагад мэдрэмтгий хандах, (в) насан туршдаа суралцах, (г) чанартай, найдвартай, хариуцлагатай, цагийг баримталж, эелдэг найрсаг байх, (д) хууль, журмыг дээдлэх зэрэг багтана. Энэ нь мэргэжлийн нягтлан бодогчид ерөнхийдөө зах зээл болон эдийн засгийн үйл ажиллагаанд итгэх итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг гэсэн үзэл санааг дэмждэг.

Холбогдох Ёс Зүйн Шаардлагууд (Лав: 10-р параграф)

- A16. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг анхандаа тусдаа сургалт эсвэл хичээл мэтээр үзэж болно. Гэхдээ мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид хөгжиж дэвшихийн хэрээр мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бусад сургалт, хичээлтэй нэгтгэснээр ёс суртахууны үр дагаврыг илүү өргөн хүрээнд авч үзэж, хүлээн зөвшөөрөхөд тустай.

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Талаарх Сургалтын Үр Дүнг (Лав: 11-р параграф)

Сургалтын Үр Дүнг Нэмэгдүүлэх нь

- A17. МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн ирээдүйд сонирхож буй нягтлан бодох бүртгэлийн мэргэших чиглэл, ажил үүргээс үл хамааран эзэмшвэл зохих мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын талаарх сургалтын үр дүнг Хүснэгт А-д жагсааж харуулав. Эдгээр сургалтын үр дүнд мэргэжлийн нягтлан бодогчдод аудитын гэрээт ажлын партнер, татварын мэргэжилтэн зэрэг нягтлан бодох бүртгэлийн ялгаатай ажил үүргээр мэргэшиж хөгжих суурийг бий болгодог.
- A18. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт Хүснэгт А-д тусгасан 3 чадавхын цар хүрээг оруулахдаа тодорхойлсон сургалт, хичээлийн нэрсээс ялгаатай байдлаар тусгаж болно. Мөн нэг чадавхын цар хүрээ (жишээ нь, ёс зүйн зарчмууд)-тэй холбоотой сургалтын үр дүнд нэгээс илүү сургалт, хичээлийн дараа хүрч болно. Зарим сургалтын үр дүнд (жишээ нь, мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд) хэд хэдэн өөр сургалт, хичээлийн тусламжтайгаар хүрч болох бөгөөд тэдгээр сургалт, хичээлүүд нь тухайлсан нэг чадавхын цар хүрээнд зориулагдаагүй байж болно. Түүнчлэн, мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт багтсан чадавхын цар хүрээний эрэмбэ нь Хүснэгт А-д үзүүлсэн эрэмбэлэлтээс ялгаатай байх боломжтой (жишээ нь, олон нийтийн ашиг сонирхлын төлөөх үүргийг Хүснэгт А-д чадавхын цар хүрээний жагсаалтын төгсгөл

⁵ Танилцуулга ба Үндсэн Зарчмууд, *НБОУЁЗСЗ-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн Гарын Авлага – 2016 оны Хэвлэл.*

хэсэгт оруулсан боловч мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн нэлээд эхлэл хэсэгт тусгасан байх боломжтой).

- A19. Ур чадварын түвшинг тодорхойлж ангилах олон арга замууд бий. НБББОУСЗ-өөс боловсруулсан тодорхойлолтыг Хавсралт 1 буюу Ур Чадварын Түвшний Тодорхойлолт хэсэгт оруулав.
- A20. Хүснэгт А-д мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн МАШХ-ийн эцэст эзэмшсэн байвал зохих ур чадварын түвшинг чадавхын цар хүрээ тус бүрээр нь тогтоосон байдаг. Энэхүү ур чадварын түвшин нь холбогдох сургалтын үр дүнд хүрэхээр зорьж буй агуулгад хамааралтай юм. Чадавхын цар хүрээнд хамаарах ур чадварын түвшин болон сургалтын үр дүн нь хамтдаа ДНБХ-ны гишүүн байгууллагуудад өөрсдийн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулах мэдээллээр хангаж тусалдаг.
- A21. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт: (а) нэмэлт чадахийн цар хүрээг оруулах; (б) зарим чадавхын цар хүрээний хувьд ур чадварын түвшинг нэмэгдүүлэх; эсвэл (в) энэхүү БОУС-д тусгагдаагүй нэмэлт сургалтын үр дүнг тодорхойлж болно. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг тодорхой ажил үүргийг гүйцэтгэх (жишээ нь, удирдлагын нягтлан бодогч эсвэл аудиторроор ажиллах), эсвэл тодорхой аж үйлдвэрийн салбарт (жишээ нь, улсын салбарт) ажиллахад нь бэлтгэх үед эдгээрийг хэрэгжүүлэх боломжтой.

Сургалт, Хөгжүүлэлтийн Үйл Ажиллагааг Сонгох нь

- A22. ДНБХ-ны гишүүн байгууллагууд, сурган хүмүүжүүлэгчид, болон бусад оролцогч талуудыг үндэсний болон соёлын орчныг харгалзан үзэж мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг суралцаж, хөгжүүлэх хамгийн зохистой арга замыг тогтоохыг хөхүүлэн дэмждэг.
- A23. Сургалтын үр дүнд хүрэх арга замыг тодорхойлохдоо тодорхой бүтэц бүхий сургалтын хөтөлбөрүүд болон практик туршлагыг хослуулан сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд хамааруулах боломжтой. Энэхүү хослолыг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг ажлын байран дээрээ ашиглах таатай боломжийг олгох зорилгоор зохион байгуулж болно.
- A24. Сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд ДНБХ-ны гишүүн байгууллагууд, сурган хүмүүжүүлэгчид, болон бусад оролцогч талууд нь (а) мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын талаар боловсрол олгох, болон (б) ёс зүйтэй зан төлвийг төлөвшүүлэхэд таатай орчныг бүрдүүлж хэвээр хадгалах хоёрын хоорондын ялгааг тодорхойлж болно. МАШХ-ийн үр дүнд мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хөгжүүлэх боломжтой бөгөөд МТХ-ийн арга хэмжээ болон насан туршийн боловсролын хүрээнд карьерынхаа туршид үргэлжлүүлэн суралцаж хөгжүүлэх боломжтой.
- A25. ДНБХ-ны гишүүн байгууллагууд, сурган хүмүүжүүлэгчид болон бусад оролцогч талууд нь мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын хөгжүүлэлтийг сайжруулах идэвхтэй арга замыг ашиглахаар шийдэж болно. Үүнд, дараах арга замууд багтах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) Үүрэг гүйцэтгэх;
- (б) Тодорхойлсон уншлага болон онлайн материалуудыг хэлэлцэх;

- (в) Ёс зүйн төвөгтэй асуудлуудыг багтаасан бизнесийн нөхцөл байдалтай холбоотой кейс судалгаанд дүн шинжилгээ хийх;
- (г) Сахилгын дүрэм журам болон дүгнэлтийг хэлэлцэх;
- (д) Компани болон мэргэжлийн хэмжээнд шийдвэр гаргах туршлага бүхий илтгэгчдийг оролцуулан семинар зохион байгуулах; ба
- (е) Онлайн форум болон хэлэлцүүлгийн самбарыг ашиглах.

A26. Идэвхтэй арга замуудын тусламжтайгаар нарийн төвөгтэй удирдлагын шийдвэр гаргахаас үүдэлтэй хувь хүн болон бизнесийн хүрээнд үүсч болзошгүй маргаантай асуудлууд болон ёс зүйн үр дагаврыг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид илүү сайн ойлгож мэдэх боломжтой.

Мэргэжлийн Үл Итгэх Үзэл болон Мэргэжлийн үнэлэмж

A27. Мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд мэргэжлээрээ хөгжиж дэвшихэд үргэлж шулуун дардан байдаггүй. Эдгээр хүрээнд сургалт, хөгжүүлэлтийг үр өгөөжтэй төлөвлөхөд хянамгай байх шаардлагатай бөгөөд үүнд, зөвлөгөө чиглэл, эргэцүүлэх үйл явц, цаг хугацаа, практик туршлагыг чухалчилсан сургалтын арга зүйг багтаадаг.

Ёс Зүйн Зарчмууд болон Асуудлууд

A28. Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэжлийн чадамжийн хүрээнд үүрэг хүлээсэн бүхий л зүйлд ашиглана. (а) Ёс зүйн үзэл баримтлал, онол болон мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмуудын талаарх ойлголт, мэдлэгийг эзэмшиж, (б) эдгээрийг ажлын бус нөхцөл байдалд ашиглах боломжтой болсноор мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд ёс зүйн асуудлуудыг таньж мэдэн анхаарал хандуулахад нь тустай.

A29. Ёс зүйн зарчмууд болон асуудлуудын тал дээр мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг сургаж хөгжүүлэхдээ (а) бүх мэргэжлийн нягтлан бодогчдод тулгарч болзошгүй тухайлсан ёс зүйн асуудлууд, (б) мэргэжлийн нягтлан бодогчдод ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгарч болзошгүй ёс зүйн асуудлууд, (в) эдгээр ёс зүйн асуудлуудад тохирсон хариу арга хэмжээг боловсруулахад гол анхаарах зүйлс зэргийг харгалзаж үзэж болно.

A30. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд (а) өөрсдийн ажил дээр болон ажлын орчин дахь аливаа илэрхий ёс зүйн үр дагавар, маргаантай асуудлыг тодорхойлох, (б) ийм нөхцөл байдалд баримтлах үзэл санааг урьдчилан боловсруулах, (в) практик туршлагатай чиглүүлэгчидтэй энэ талаар хэлэлцэх зэргийг нь дэмжих замаар ёс зүйн зарчмуудад ач холбогдол өгөх асуудлыг шийдвэрлэх боломжтой.

A31. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд практик туршлагаа хэрэгжүүлэх явцад нь ёс зүйн асуудлууд болон үүсч болзошгүй маргаанууд тулгарах магадлалтай. Практик туршлагад суурилсан хөтөлбөрийг боловсруулж, хяналт тавих үүрэгтэй ажилтнууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд аливаа арга хэмжээ, нөхцөл байдлын талаар ёс зүйн эргэлзээтэй асуудал үүссэн тохиолдолд өөрсдийн ажлын орчинд эсвэл ДНБХ-ны гишүүн байгууллагын хүрээнд ажил олгогчид, зөвлөгчид болон чиглүүлэгчидтэйгээ зөвлөлдөх шаардлагатай эсэх талаар зөвлөмж өгч болно.

Мэргэжлийн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Хөтөлбөрийн Хяналт (Лав: 12-р параграф)

- A32. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд МАШХ-ийн төгсгөлд эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхаа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулдаг. Үүнд, их дээд сургуулиуд, бусад дээд боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд болон ажил олгогчдоос санал болгосон мэргэшил, сургалтаар олж авсан албан ёсны боловсролоос гадна ажлын байран дээрх сургалтыг тус тус хамааруулна. Тиймээс МАШХ-ийн явцад санал болгох мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад ДНБХ-ны гишүүн байгууллагуудаас бусад оролцогч талуудаас ихээхэн оролцоо шаардагдаж болно.
- A33. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг тогтмол хянаж, шинэчилж байх шаардлага нь мэргэжлийн нягтлан бодогчдын ажиллаж буй орчин хурдацтай өөрчлөгдөж, улам бүр нарийн төвөгтэй болж байгааг илтгэнэ. Ерөнхийдөө хөтөлбөрийг 3-5 жилийн давтамжтайгаар хянаж шинэчлэх боломжтой боловч мэргэжлийн нягтлан бодогчидтой холбоотой хууль тогтоомж, журам болон стандартад орсон өөрчлөлтүүдийг харгалзан үзэх зэргээр илүү ойр давтамжтайгаар хянаж шинэчлэх нь зохистой байж болно.

Эргэцүүлэх Үйл Явц (Лав: 13-р параграф)

- A34. Эргэцүүлэх үйл явц гэдэг нь *карьерынхаа аль ч шатанд ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид ирээдүйн үйл ажиллагаагаа сайжруулах үүднээс (бодитоор эсвэл дууриах хэлбэрээр) өөрсдийн туршилагад дүгнэлт хийх замаар мэргэжлийн чадавхаа тасралтгүй хөгжүүлж буй давтамжит үйлдэл юм.*
- A35. Эргэцүүлж үзэхүйц хамгийн бодитой туршлагыг ажлын байран дээрээсэ авч болно. Хэрвээ энэ нь боломжгүй эсвэл зохимжгүй бол “бодит амьдрал”-ын туршлагыг дууриах эсвэл олон нийтэд нээлттэй холбогдох кейс тохиолдлуудыг харгалзан үзэх нь тохиромжтой хувилбар байж болно.
- A36. Эргэцүүлэх үйл явцын баримт бичигт дараах зүйлс хамаарна:
- (а) Сургалтын бүртгэл, тайлан;
 - (б) Эргэцүүлсэн зүйлсийн тэмдэглэл;
 - (в) Хувь хүний хөгжлийн багц; эсвэл
 - (г) Шүүмжлэлт үйл явдлын тэмдэглэл.
- A37. Эргэцүүлэх үйл явцад зориулж хадгалах баримт бичгийн мөн чанар, хэлбэр, агуулга болон баримтжуулах ёс зүйн нөхцөл байдлын төрлүүдийн талаар мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид болон мэргэжлийн нягтлан бодогчдод удирдамж заавар өгөхдөө ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь нууцлал, хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагууд зэрэг хүчин зүйлсийг харгалзаж авч үзнэ. Тухайлбал, зарим ёс зүйн нөхцөл байдлууд илүү эмзэг бөгөөд хууль эрх зүйн болон сахилгын арга хэмжээ авахаар байж болох бөгөөд иймд тэдгээрийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хувьд баримтжуулж, хэлэлцэхэд тохиромжгүй байж болно.
- A38. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мөн практик туршлагатай чиглүүлэгчдэд зориулан эргэцүүлэх үйл явцыг хэрхэн практикт илүү хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж өгөх асуудлыг авч үзэх боломжтой.

Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагын Үнэлгээ (Лав: 14-р параграф)

- A39. БОУС 6, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт–Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ (2015)*-д мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлага болон мэргэжлийн чадавхын бусад

элементүүдийг үнэлэхэд ашиглах үнэлгээний үйл ажиллагааны загварыг боловсруулахад хэрэглэгдэх зарчмуудыг тодорхойлдог.

- A40. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг үнэлэхдээ олон янзын үнэлгээний үйл ажиллагааг ашиглах боломжтой. Тохиромжтой үнэлгээний үйл ажиллагаанд дараах зүйлс багтана: (а) богино хариулт шаардсан асуултууд бүхий бичгийн шалгалт, (б) кейс дасгал ажлууд, (в) эссэ бичлэг, (г) биет тест, (д) ажлын байрны үнэлгээ, ба (е) өмнөх сургалтыг бататгах.
- A41. Бичгийн шалгалтаас гадна албан ёсны боловсролын орчинд үнэлгээг хийж гүйцэтгэх бусад олон янзын аргууд байдаг. Үүнд:
- (а) Кейс дасгал ажлуудыг агуулсан мэдээллийн санг бий болгож, мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг эдгээр кейс дасгал ажлуудад үндэслэн боловсруулсан тестийг ажиллаж дуусгахыг шаардах;
 - (б) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг олон нийтэд нээлттэй тухайлсан кейс тохиолдлуудын талаар журнал, тэмдэглэлтэй болохыг шаарддаг кейс шинжилгээний системийг ашиглах;
 - (в) Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийн ёс зүйн асуудлуудад биет тестийн аргыг ашиглах; ба
 - (г) Ёс зүйн дүн шинжилгээ болон шийдвэр гаргах үйл явцыг үнэлэхдээ багаар нь кейс сургалтын дасгал ажиллуулж, семинар явуулах.
- A42. Ажлын байрны үнэлгээ нь албан ёсны боловсролын орчинд хийсэн үнэлгээнээс ялгаатай бөгөөд олон талаараа илүү хүндрэлтэй байдаг. Ажлын байран дээр мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хөгжүүлж буй байдлыг дараах аргуудаар үнэлж болно:
- (а) Ажлын байран дээр үүссэн ёс зүйн маргаантай асуудлуудыг хэлэлцэж, хялбар байдлаар шийдвэрлэх; ба
 - (б) Ёс зүйн шийдвэр гаргахад тавих хяналтыг гүйцэтгэлийн хяналт болон үнэлгээний хамт хэрэгжүүлэх.

Хавсралт 1

Ур Чадварын Түвшний Тодорхойлолт

Энэхүү ур чадварын түвшний тодорхойлолт нь Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС) 2, 3, 4-үүдэд тусгасан сургалтын үр дүнг НББОУСЗ-өөс хэрэгжүүлэхийг дэмждэг. Үүнд ур чадварын гурван түвшинг тодорхойлсон. Эдгээр тодорхойлолтууд нь сургалтын үр дүнгийн хамтаар мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн ялгаатай үүрэг гүйцэтгэх болон өөр өөр чиглэлээр ажиллахад зориулсан мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад гишүүн байгууллагад хэрэглэгдэнэ.

Ур Чадварын Түвшин	Тодорхойлолт
Суурь түвшин	<p>Ерөнхийдөө суурь түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Зохистой удирдлагын дагуу ажиллахдаа үүрэг даалгавраа гүйцэтгэхийн тулд техникийн чадавхын хүрээтэй холбоотой үндсэн зарчим болон томъёоллыг тодорхойлох, тайлбарлах, нэгтгэх; • Зохистой мэргэжлийн ур чадварыг ашиглан өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх; • Өгөгдсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын ач холбогдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх; • Энгийн асуудлуудыг шийдвэрлэх, мөн нарийн төвөгтэй ажил эсвэл асуудлуудыг удирдлага эсвэл мэргэжлийн хүмүүст хүргүүлэх; • Аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Суурь түвшний сургалтын үр дүнд бага түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Дунд түвшин	<p>Ерөнхийдөө дунд түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил гүйцэтгэх болон шийдвэр гаргахдаа холбогдох техникийн чадавхын хүрээний үндсэн зарчим болон томъёоллыг бие дааж хэрэглэх, харьцуулах болон шинжлэх; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ тулд техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг хослуулах; • Ажил үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хэрэглэх; Нягтлан бодох бүртгэлийн болон бусад оролцогч талуудад аман болон бичгийн харилцааг ашиглан энгийн ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл өгөх болон санал бодлоо илэрхийлэх. <p>Дунд түвшний сургалтын үр дүнд дунд зэргийн ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
Ахисан түвшин	<p>Ерөнхийдөө ахисан түвшний чадавхын сургалтын үр дүнд дараах чадавхыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдах, мөн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зөвлөгөө өгөхийн тулд олон төрлийн техникийн чадавхаас зохистой зарчим болон томъёоллыг сонгох болон нэгтгэх; • Төсөл болон өгөгдсөн ажлыг ахлах болон удирдахдаа техникийн чадавх болон мэргэжлийн ур чадварыг нэгтгэх; • Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг бодитоор хэрэгжүүлэх тохиолдолд мэргэжлийн шийдвэр гаргах; • Хязгаарлагдмал хяналттай нарийн төвөгтэй асуудлыг үнэлэх, судлах болон шийдвэрлэх;

	<ul style="list-style-type: none">• Нарийн төвөгтэй асуудлыг урьдчилан таамаглах, зөвлөх болон шийдлийг боловсруулах;• Олон төрлийн оролцогч талуудад холбогдох мэдээллийг өргөн хүрээтэй, итгэл үнэмшилтэй тайлбарлах. <p>Ахисан түвшний сургалтын үр дүнд ахисан түвшний ойлгомжгүй, төвөгтэй асуудлуудыг хамарсан ажлын орчин хамаардаг.</p>
--	--

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 5

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ-ПРАКТИК ТУРШЛАГА (2015)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1-7
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	8
Зорилго.....	9
Шаардлага	
Практик Туршлага.....	10-15
Практик Туршлагад Тавих Хяналт ба Мониторинг.....	16-19
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1-A4
Зорилго.....	A5-A6
Практик Туршлага.....	A7-A14
Практик Туршлагад Тавих Хяналт ба Мониторинг.....	A15-A21

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А1–А4-р параграф)

1. Энэхүү Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС) нь Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн бүрэн эзэмшсэн байх шаардлагатай практик туршлагыг тодорхойлно.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагуудын зүгээс МАШХ нь энэхүү БОУС-ын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Үүнээс гадна, уг БОУС нь боловсролын байгууллагууд, ажил олгогчид, зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллагууд, болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн сургалт, хөгжүүлэлтийн үйл явцыг дэмждэг бусад оролцогч талуудад хэрэгцээтэй байдаг.
3. Практик туршлага гэж мэргэжлийн чадавхыг хөгжүүлэхтэй холбоотой ажлын байран дээрх болон бусад арга хэмжээг хэлнэ. Практик туршлага нь МАШХ-ийн бүрэлдэхүүн хэсэг юм. МАШХ гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд тэргүүн ээлжинд шаардлагатай мэргэжлийн чадавхыг эзэмших сургалт, хөгжүүлэлтийг хэлнэ.
4. МАШХ-ийн туршид практик туршлага нь ерөнхий боловсрол болон мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрүүдэд тулгуурладаг. Олон нийтийн зүгээс мэргэжлийн нягтлан бодогчдыг өөрсдийн туршлага, мэдлэгийг ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглана гэсэн хүлээлттэй байдаг. Гэхдээ мэргэжлийн нягтлан бодогчдын гүйцэтгэдэг ажил үүрэг олон төрөл ялгаатай байдаг нь шаардлагатай практик туршлагыг ДНБХ-ны нэг гишүүн байгууллага нь нөгөөгөөсөө ялгаатай тогтоох, мөн олон төрлийн гишүүнчлэл олгодог бие даасан ДНБХ-ны гишүүн байгууллага дотооддоо хүртэл ялгаатай тодорхойлдогтой холбоотой. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь (а) өөрсдийн хэрэгцээ, шаардлагууд, (б) холбогдох зохицуулагч байгууллагуудын шаардлагууд, мөн (в) мэргэжлийн нягтлан бодогчдыг тодорхой чадавх эзэмшсэн гэж үзэх олон нийтийн хүлээлт зэрэгт нийцэх зорилгоор практик туршлагын шаардлагад өөрчлөлт оруулж болно.
5. МАШХ-д хамрагдсаны дараагаар (а) хууль ёсны аудитор, (б) мэргэшлийн бусад хэлбэр, эсвэл (в) зохицуулалтад хамаарах бусад ажил үүргүүд зэрэг бусад ажил үүргийг гүйцэтгэхэд хэрэгцээтэй мэргэжлийн чадавхын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчдыг хүргэхийн тулд практик туршлага шаардлагатай юм. Практик туршлага гэдэг нь МТХ-ийн туршид мэргэжлийн нягтлан бодогчид өөрсдийн ажил үүрэгтэй холбоотойгоор мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалах зорилготой насан туршийн сургалтын нэг хэсэг юм. Ажлын орчныг өөрчлөх, карьерын хувьд өсч дэвших эсвэл шинэ ажил үүрэггүйцэтгэхийн тулд мэргэжлийн нягтлан бодогчид мэргэжлийн чадавхын түвшингээ нэмэгдүүлж, шинэ чадавх эзэмших шаардлагатай болж болно. Энэ талаар БОУС 7, *Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил* (2014)-д тусгасан болно.
6. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмших практик туршлагыг төлөвлөж, хянахад практик туршлагатай чиглүүлэгч болон ажил олгогчид чухал үүрэг гүйцэтгэдэг.
7. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчид ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд Зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал* (2015)-д ашигласан нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр Томъёоны Тайлбар* (2015)-т багтсан болно.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

8. Энэхүү БОУС-ыг 2015 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго (Лав: А5–А6-р параграф)

9. Энэхүү БОУС-ын зорилго нь МАШХ-д хамрагдаж дууссаны эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэх хангалттай практик туршлагыг бий болгоход оршино.

Шаардлагууд (Лав: А7–А21-р параграф)

Практик Туршлагууд (Лав: А7–А9-р параграф)

10. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь МАШХ-ийн төгсгөлд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг практик туршлагыг бүрэн эзэмшсэн байхыг шаарддаг.
11. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадварууд, болон (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага зэргийг эзэмшсэн гэдгээ нотлон харуулахын тулд хангалттай практик туршлагатай байхыг шаарддаг.
12. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь дараах 3 хандлагын аль нэгийг ашиглан практик туршлагыг хэмжих өөрсдийн илүүд үзсэн хандлагыг боловсруулна:
 - гарцад суурилсан;
 - орцод суурилсан; эсвэл
 - нийлмэл хандлага.

Гарцад Суурилсан Хандлага (Лав: А10-р параграф)

13. Гарцад суурилсан хандлагыг ашиглаж буй ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь гарцын хэмжүүрийг ашиглан мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг практик туршлагыг эзэмшсэн гэдгээ нотлон харуулахыг шаарддаг.

Орцод Суурилсан Хандлага (Лав: А11-А13-р параграф)

14. Орцод суурилсан хандлагыг ашиглаж буй ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь орцын хэмжүүрийг ашиглан мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг практик туршлагыг эзэмшсэн гэдгээ нотлон харуулахыг шаарддаг.

Нийлмэл Хандлага (Лав: А14-р параграф)

15. Гарц болон орцод суурилсан хандлагуудыг хослуулан ашиглаж буй ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь 14 болон 15 дугаар зүйлд заасан гарц болон орцод суурилсан хандлагуудын холбогдох хамааралтай шаардлагуудыг дагаж мөрдөнө.

Практик Туршлагад Тавих Хяналт ба Мониторинг (Лав: А15-А21-р параграф)

16. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь практик туршлагатай чиглүүлэгчийн удирдлаган дор мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд практик туршлага эзэмшүүлэхийг шаарддаг.
17. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн практик туршлагыг ДНБХ-ны гишүүн байгууллага эсвэл холбогдох

- зохицуулагч байгууллагаас тодорхойлсон нийцтэй хэлбэрээр бүртгэж, нотлох баримтаар баталгаажуулахыг шаарддаг.
18. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн практик туршлагын талаарх бүртгэл тэмдэглэлийг практик туршлагатай чиглүүлэгчээр үе үе хянуулахыг шаарддаг.
 19. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хангалттай практик туршлагыг бүрэн эзэмшсэн эсэхийг үнэлэх зорилгоор зохих үнэлгээний үйл ажиллагааг бий болгох шаардлагатай.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-7-р параграф)

- A1. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч гэж МАШХ-ийн хүрээнд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлсэн хувь хүн юм. МАШХ гэдэг нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нь мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд тэргүүн ээлжинд шаардлагатай чадавхыг эзэмших сургалт, хөгжүүлэлтийг хэлнэ. МАШХ нь ерөнхий боловсролд тулгуурладаг бөгөөд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол, практик туршлага, болон үнэлгээ зэрэг багтдаг. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн хүрээнд өөрсдийн сонгосон ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадавхтай гэдгээ нотлон харуулах хүртэл МАШХ нь үргэлжилнэ.
- A2. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд МАШХ-ийн төгсгөлд эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхаа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулдаг. Үүнд, их дээд сургуулиуд, бусад боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд болон ажил олгогчдоос санал болгосон эрдмийн зэрэг болон курс сургалтаар олж авсан албан ёсны боловсролоос гадна ажлын байран дээрх сургалтыг тус тус хамааруулна. Тиймээс МАШХ-ийн явцад санал болгох мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад ДНБХ-ны гишүүн байгууллагуудаас бусад оролцогч талуудаас ихээхэн оролцоо шаардагдаж болно.
- A3. Мэргэжлийн чадавхыг олон янзаар тодорхойлж, ангилж болно. БОУС-ын хүрээнд, мэргэжлийн чадавх гэдэг нь ажил үүргийг тогтоосон стандартын дагуу гүйцэтгэх чадвар юм. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандарт, үзэл баримтлал, баримт нотолгоо, үйл явцын талаарх мэдлэгээс илүү давсан ойлголт бөгөөд энэ нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага зэргийг хослуулан, ашиглахыг хэлнэ.
- A4. Практик туршлагын тусламжтайгаар мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд чадавхаа хөгжүүлэх мэргэжлийн орчинг дараах байдлаар бүрдүүлж өгдөг. Үүнд:
- (а) Үйлчилгээ үзүүлж буй орчны талаар ойлгож мэдэх;
 - (б) Байгууллага болон бизнесийн үйл ажиллагааг хэрхэн явуулдаг талаарх ойлголтыг нэмэгдүүлж, мэргэжлийн ажил хэргийн харилцааг сайжруулах;
 - (в) Нягтлан бодох бүртгэлийн ажлыг бусад бизнесийн функц болон үйл ажиллагаатай хамааруулж ойлгодог байх;
 - (г) Практик болон бодит амьдралын нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг хөгжүүлэх (мөн БОУС 4, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлага (2015)*-ыг үз); ба
 - (д) Зохих түвшний хяналтан дор өсөн нэмэгдэх хариуцлагын түвшин бүрт хөгжих боломжтой байх.

Зорилго (Лав: 9-р параграф)

- A5. Хангалттай практик туршлага нь мэдлэг болон хэрэглээг гүнзгий, өргөн хүрээнд хослуулдаг бөгөөд шаардлагатай үед, янз бүрийн нөхцөл байдал болон агуулгаар ашиглагддаг өөр өөр чиглэлийн материалын нэгдэл болдог. Практик туршлагын өргөн цар хүрээнд дараах хүчин зүйлс нөлөөлдөг, тухайлбал: ажил үүргийн мөн чанар, нарийн төвөгтэй байдал; үндэсний эсвэл орон нутгийн хууль тогтоомж; зохицуулагч

байгууллагуудын шаардлагууд; мэргэжлийн чадавхын талаарх олон нийтийн хүлээлт. Практик туршлагын гүнзгий байдалд үүрэг даалгаврын олон төрөл болон нарийн төвөгтэй байдал, мөн хяналт, мониторингийн дэмжлэгийн түвшин зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг.

- А6. МАШХ-ийн төгсгөлд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих хангалттай практик туршлагыг хэрхэн бүрдүүлэх талаар тодорхойлох нь хэд хэдэн зорилготой байдаг. Энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, мэргэжлийн нягтлан бодогчдын ажлын чанарыг дээшлүүлж, мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хандах итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг.

Практик Туршлага (Лав: 10-12-р параграф)

- А7. МАШХ нь ерөнхий боловсролд тулгуурладаг бөгөөд мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол, практик туршлага, болон үнэлгээ зэрэг багтдаг. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийн хослол нь янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалан ялгаатай байж болох бөгөөд тухайлбал, үүнд олон төрлийн үүрэг даалгавар болон нарийн төвөгтэй байдал, шаардлагатай тусгайлсан мэдлэг, бие даасан байдлын түвшин болон МАШХ-ийн төгсгөлд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үнэлэмжийн түвшин зэрэг багтана. Мөн практик туршлага болон боловсролыг (а) ДНБХ-ны бие даасан гишүүн байгууллагуудаас тогтоосон дүрэм журам, (б) үндэсний болон орон нутгийн хууль тогтоомж, (в) зохицуулагч байгууллагуудын шаардлагууд, (г) олон нийтийн хүлээлт зэргээс шалтгаалан ялгаатайгаар хослуулах боломжтой юм.

- А8. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсрол болон практик туршлагын хоорондох зохистой тэнцвэрийг хэрхэн бүрдүүлэх талаар тодорхойлохдоо ДНБХ-ны гишүүн байгууллагууд дараах зүйлсийг харгалзаж үзэж болно:

- (а) Дагалдуулан сургах, дадлага хийлгэх, боловсрол ажлыг хослуулах, өөр ажилд түр томилох зэргээр практик хэрэглээнд онцгой ач холбогдол өгдөг зарим мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрөөр практик туршлагын шаардлагыг өргөжүүлж болно.
- (б) Академик болон мэргэжлийн ур чадварын сургалт нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийг эзэмших, нотлон харуулахад ач холбогдолтой. Гэхдээ сургалт нь дангаараа мэргэжлийн нягтлан бодогчийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн чадавхыг амжилттай эзэмшсэн эсэхийг заавал илэрхийлэх шаардлагагүй юм. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нь ажил дээрээс олж авсан туршлагаараа чадварлаг мэргэжлийн нягтлан бодогч болоход шаардлагатай олон ур чадваруудыг эзэмшдэг.
- (в) Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж дууссаны дараа эсвэл иймэрхүү хөтөлбөрийн явцад практик туршлагыг эзэмшиж болно.

- А9. Практик туршлагад тавигдах шаардлагууд болон хандлагыг тодорхойлохдоо ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь олон төрлийн хүчин зүйлсийг авч үзэж болно. Үүнд:

- (а) Олон нийтийн ашиг сонирхол, түүний дотор тухайн орон нутгийн орчны талаарх мэдлэг, олон нийтийн хүлээлт болон аливаа холбогдох зохицуулалтын шаардлагууд багтана;
- (б) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хэрэгцээ, үүнд МАШХ-д хамрагдаж дууссаны дараа тэдний гүйцэтгэх ажил үүргийн талаарх ойлголт багтана;

- (в) Ажил олгогчийн хэрэгцээ, үүнд бүтээмж, зардлын үр ашиг болон ажил олгогч нь аж үйлдвэр, засгийн газар, эсвэл олон нийтэд үйлчилдэг салбарт үйл ажиллагаа явуулдаг эсэхийг оруулна;
- (г) ДНБХ-ны гишүүн байгууллагын хэрэгцээ, түүний дотор зохицуулалтын шаардлагууд, бүтээмж болон зардлын үр ашиг зэрэг багтана.

Гарцад Суурилсан Хандлага (Лав: 13-р параграф)

- A10. Гарцад суурилсан хандлагын үед үнэлгээний зорилгоор ашиглаж болох нотолгоонд дараах зүйлс хамаарна:
- (а) Чадавхын зураглалын дагуу хүрсэн сургалтын үр дүнг хэмжих;
 - (б) Судалгааны төсөл эсвэл эргэцүүлсэн эссэг хянах; мөн
 - (в) Зохих чадавхын зураглалтай харьцуулсан ажлын бүртгэл. Ажлын бүртгэл гэдэг нь үүрэг даалгаврын мөн чанар, гүйцэтгэсэн ажлууд болон тэдгээр үүрэг даалгавар, ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацааг баримтжуулсан хувь хүмүүсийн хадгалсан тэмдэглэлийг хэлнэ.

Орцод Суурилсан Хандлага (Лав: 14-р параграф)

- A11. Орцод суурилсан хандлагуудаар хэмжиж баталгаажуулахад хялбар байдаг учраас чадавхыг хөгжүүлсэн байдлыг хэмжих шалгуур үзүүлэлт болгон ашигладаг. Орцод суурилсан хандлагууд нь тодорхой хязгаартай бөгөөд тухайлбал, эдгээр хандлагаар сургалтын үр дүн эсвэл хөгжүүлсэн чадавхыг үргэлж шууд хэмжиж болдоггүй. Уламжлал ёсоор, орцод суурилсан хандлагууд нь цаг хугацаанд үндэслэдэг бөгөөд тухайлбал, холбогдох үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, эсвэл практик туршлагын нийт хугацаа (өдөр, сар, эсвэл жил) зэрэг багтана.
- A12. Орцод суурилсан хандлагын үед хэмжилтийн зорилгоор ашиглаж болох нотолгоонд ирцийн бүртгэл, цагийн хуудас, ажлын байрны тэмдэглэл, ажлын бүртгэл, эсвэл журнал зэрэг багтана. Орцод суурилсан хандлагыг ашиглан шаардлагаа тодорхойлж буй ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хамрагдсан боловсролын хөтөлбөрийн бүтэц болон хамаарлыг авч үзэж болно. Ажлын байранд суурилсан туршлагаас (жишээ нь, дадлага хийх) үүссэн хэмжилтийн үр дүнтэй төстэй үр дүнг бий болгодог мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөр нь практик туршлагын нийт шаардлагыг илүү өргөжүүлж болно. Үүнтэй адилаар, Нягтлан бодох бүртгэлийн магистр зэрэг томоохон мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг дүүргэсэн тохиолдолд ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь практик туршлагын бүрэлдэхүүн хэсгийг багасгахаар шийдэж болно. Тухайлбал, орцод суурилсан хандлагыг сонгосон ДНБХ-ны гишүүн байгууллага нь (хэд хэдэн ДНБХ-ны гишүүн байгууллагуудын илүүд үзэж, хэрэгжүүлсний адилаар) 3 жилийн практик туршлага, эсвэл нягтлан бодох бүртгэл эсвэл бусад холбогдох чиглэлээр 2 жил суралцдаг магистрын зэрэг, эсвэл нягтлан бодох бүртгэлийн боловсрол болон хангалттай практик туршлага нь хамтдаа нийлээд хамгийн багадаа 5 жил болж байгаа зэргийг харгалзаж үзэж болно.
- A13. Бүрэлдэхүүн хэсгүүдийн тэнцвэрээс үл хамааран ерөнхийдөө мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж, хангалттай практик туршлага хуримтлуулсан байдаг гэсэн олон нийтийн хүлээлт байдаг.

Нийлмэл Хандлага (Лав: 15-р параграф)

A14. Орц болон гарцад суурилсан хандлагуудыг хослуулсан хандлагыг ДНБХ-ны гишүүн байгууллагаас боловсруулах боломжтой. Орцын нэгж нь хэмжиж буй мэргэжлийн чадавхад хувь нэмэр үзүүлдэг хэмээн үзэж болно. Тодорхой чадавхыг амжилттай эзэмшсэнээр орцыг шалгаж баталгаажуулах эсвэл зарим тохиолдолд орцын шаардлагыг орлуулахын аль нэгэнд ашиглах боломжтой.

Практик Туршлагад Тавих Хяналт ба Мониторинг (Лав: 16-19-р параграф)

A15. Практик туршлагатай чиглүүлэгч гэж мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг хангалттай практик туршлага хуримтлуулахад нь чиглүүлэх, зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үүрэгтэй мэргэжлийн нягтлан бодогчийг хэлнэ. Практик туршлагатай чиглүүлэгчид нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид болон ДНБХ-ны гишүүн байгууллагуудын хоорондох чухал харилцааг илтгэнэ. Тэд практик туршлагын хугацааг төлөвлөх үүрэгтэйгээс гадна мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг удирдаж чиглүүлдэг. Зарим нөхцөлд практик туршлагатай чиглүүлэгчид нь мөн мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зөвлөгөө дэмжлэг үзүүлж болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь практик туршлагатай чиглүүлэгчдэд зориулан сургалт зохион байгуулахаас гадна туслалцаа үзүүлэх болон чанарын хяналтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хоёуланг нь хийх боломжтой.

A16. Практик туршлагатай чиглүүлэгчид нь мониторингийн үүргээ гүйцэтгэхдээ бусдын туслалцааг авч болох бөгөөд тэдний зарим нь мэргэжлийн нягтлан бодогчид биш байж болно.

A17. Батлах боломжтой нотолгоо гэдэг нь батлах боломжтой, бичгэн эсвэл электрон хэлбэрээр хадгалсан бодит баримт нотолгоог хэлнэ.

A18. Нотлох баримтаар баталгаажсан практик туршлагын тэмдэглэлд практик туршлагатай чиглүүлэгчийн үе үе хийх хяналтын зорилго нь ДНБХ-ны гишүүн байгууллага эсвэл зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах явдал юм. Түүнчлэн, энэхүү үе үе хийгдэх хяналтыг хувь хүний ахиц дэвшилд мониторинг хийхэд мөн ашиглах боломжтой. Хэрвээ мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийн ажлын ахиц дэвшил нь хүлээлттэй нийцэхгүй байвал практик туршлагатай чиглүүлэгч нь ямар шалтгаантай болохыг тогтоож, ажлын ахиц дэвшлийг сайжруулахын тулд юу хийж болохыг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлыг хянаж дүгнэх боломжтой. Энэхүү үе үе хийгдэх мониторинг нь (а) практик туршлагатай чиглүүлэгч, ажил олгогч болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд өдийг хүртэлх хугацаанд хуримтлуулсан практик туршлагыг хянаж дүгнэх бололцоог бий болгодог, бөгөөд (б) мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийн ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулдаг.

A19. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хангалттай хэмжээнд практик туршлага хуримтлуулсан эсэхийг үнэлэхдээ ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь дараах үйл ажиллагааг харгалзан үзэж болно:

- (а) Хуримтлуулсан практик туршлагад мониторинг хийх, тайлагнах системийг бий болгох, үүнд түүврийн аргыг ашиглаж болно;
- (б) Ажил олгогч, практик туршлагатай чиглүүлэгч, болон мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд практик туршлагын хөтөлбөр болон тэдэнд хамааралтай үүрэг, хариуцлагын талаар нарийвчилсан зөвлөмжийг бичгээр өгөх;
- (в) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд зохих практик туршлагыг олгох зорилгоор ажил олгогчдын тохиромжтой эсэхийг баталгаажуулдаг механизмыг бий болгох;

- (г) Туршлага хуримтлуулж эхлэхээс өмнө практик туршлагын орчинд үнэлгээ хийж, баталгаажуулах. Тухайлбал, мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид нь зохих чиглэл, хяналт, зөвлөгөө, туслалцаа болон үнэлгээг авч чадаж байгаа эсэхийг тодорхойлох үүднээс практик туршлагын мөн чанар, хамрах хүрээ болон ажил олгогчдын сургалтын зохион байгуулалтыг хянаж үзэх;
 - (д) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн олж авсан практик туршлагын төлөвлөсөн мөн чанар, хамрах хүрээ, болон агуулгад орсон аливаа өөрчлөлтийг хамруулах зорилгоор ажил олгогчдын зүгээс тогтмол хугацаанд тайлагнах тогтолцоог бий болгох;
 - (е) МАШХ-д хамрагдаж дуусахаас өмнө мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид болон практик туршлагатай чиглүүлэгчийн бичгээр бэлтгэсэн танилцуулга материалд (аман хэлбэрээр дэлгэрүүлэх боломжтой) үндэслэн хуримтлуулсан практик туршлагыг үнэлэх (мөн БОУС 6, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ*-г үз);
 - (ж) Ажил олгогчдыг мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид болон практик туршлагатай чиглүүлэгчдэд хариу үнэлгээ өгч, чадавхыг эзэмшсэнийх нь дараа эргэж мэдээлэхийг хөхүүлэн дэмжих;
 - (з) Өмнө нь хүлээн зөвшөөрсөн ажил олгогчид болон практик туршлагатай чиглүүлэгчдэд мониторинг хийх. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь тэднийг нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөний улмаас холбогдох туршлагын шалгуурыг хангаж чадахгүй болсон тохиолдолд сайжруулах тал дээр зөвлөгөө өгөх эсвэл тэднийг хүлээн зөвшөөрөхөө болихыг зөвлөж болно; мөн
 - (и) Хангалттай практик туршлагыг ажлын бүртгэл зэрэг нотлох баримтаар баталгаажуулж, эзэмшсэн эсэхийг тодорхойлоход туслах зорилгоор мэргэжлийн нягтлан бодогчдод шаардагдах чадавхын талаарх сургалтыг тогтмол хугацаанд, цаг тухайд нь зохион байгуулах.
- A20. БОУС 6, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Чадавхын Үнэлгээ* (2015) нь хангалттай хэмжээнд практик туршлага хуримтлуулсан эсэхийг үнэлэхэд ашиглах үнэлгээний үйл ажиллагааны загварыг боловсруулахад хэрэглэгдэх зарчмуудыг тодорхойлдог.
- A21. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн хангалттай хэмжээнд практик туршлага хуримтлуулсан эсэхийг үнэлэхдээ олон янзын үйл ажиллагааг ашиглах боломжтой. Зохих үнэлгээний үйл ажиллагаанд БОУС 2, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Техникийн Чадавх* (2015), БОУС 3, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Ур Чадвар* (2015), болон БОУС 4, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт - Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлага* (2015)-д тусгасан МАШХ-ийн холбогдох чиглэлээрх ажлын байрны үнэлгээг оруулж болно.

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 6

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ-МЭРГЭЖЛИЙН ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ (2015)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1-5
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	6
Зорилго.....	7
Шаардлагууд	
Мэргэжлийн Чадавхын Албан Ёсны Үнэлгээ.....	8
Үнэлгээний Зарчим.....	9
Батлах Боломжтой Нотолгоо.....	10
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1-A3
Зорилго.....	A4
Мэргэжлийн Чадавхын Албан Ёсны Үнэлгээ.....	A5-A8
Үнэлгээний Зарчим.....	A9-A20
Батлах Боломжтой Нотолгоо.....	A21-A22

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А1–А3-р параграф)

1. Энэхүү БОУС нь Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн эзэмшвэл зохих мэргэжлийн чадавхын үнэлгээний шаардлагуудыг тодорхойлдог.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид МАШХ-ийн эцэст мэргэжлийн чадавхын зохистой түвшинд эзэмшсэн эсэхэд үнэлгээ өгөх үүрэгтэй байдаг. Түүнчлэн, энэхүү БОУС нь боловсролын байгууллагууд, ажил олгогчид, зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллагууд, ба мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн сургалт, хөгжлийг дэмждэг бусад оролцогч талуудад хэрэгтэй.
3. БОУС-ын хүрээнд, сургалт болон хөгжүүлэлтийн үр дүнд олж авсан мэргэжлийн чадавхад өгсөн үнэлэлтийг үнэлгээ гэж ойлгоно. МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэхэд чиглүүлэх чадавх хөгжүүлэх анхны сургалт болон хөгжүүлэлт юм. Гэсэн хэдий ч, сургалт болон хөгжүүлэлт нь мэргэжлийн нягтлан бодогчдын карьерын явцад мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалах байнгын үйл явц бөгөөд Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил (МТХ)-өөр үргэлжилдэг. МАШХ-ийн үед мэргэжлийн чадавхыг олж авахад анхаардаг бөгөөд харин МТХ-ийн үед мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалж үлдэхэд анхаардаг.
4. Энэхүү БОУС-д мэргэжлийн чадавхын үнэлгээний шаардлагуудыг нарийвчлан заасан байдаг. Үүнд:
 - БОУС 2, *Мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлт- Техникийн чадавх /2015/*, БОУС 3, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Ур Чадвар /2015/*, БОУС 4, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт-Мэргэжлийн Үнэ Цэнэ, Ёс Зүй ба Хандлагууд /2015/* эдгээр стандартад МАШХ-ийн үед анхаарвал зохих үнэлгээний шаардлагуудыг тодорхой заасан байдаг.
 - БОУС 5, *Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт – Практик Турилага /2015/-д* практик туршлагын үнэлгээний шаардлагыг заасан байдаг.
5. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчид болон Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдийн Боловсролын Олон Улсын Стандартын Үзэл Баримтлал (2015)-д* ашигласан гол нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр томъёоны тайлбар (2015)-т* багтсан болно.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

6. Энэхүү БОУС нь 2015 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

Зорилго (Лав: А4-р параграф)

7. Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид МАШХ-ийн эцэст мэргэжлийн үүргээ биелүүлэхэд шаардагдах зохих түвшний мэргэжлийн чадавхын түвшнийг тогтооход энэхүү стандартын зорилго оршдог.

Шаардлагууд

Мэргэжлийн Чадавхын Албан Ёсны Үнэлгээ (Лав: А5–А8-р параграф)

8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч нь мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэхэд хангалттай мэргэжлийн ур чадварыг эзэмшиж чадсан эсэхийг үнэлэхийн тулд МАШХ-ийн үеэр хийгдсэн үнэлгээний үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан албан ёсоор үнэлэх ёстой.

Үнэлгээний Зарчим (Лав: А9–А20-р параграф)

9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд өндөр түвшний найдвартай, хүчин төгөлдөр, шударга, ижил тэгш, ил тод болон шаардлага хангахуйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлох үнэлгээний үйл ажиллагааг бий болгох ёстой.

Батлах Боломжтой Нотолгоо (Лав: А21–А22-р параграф)

10. ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн мэргэжлийн чадавхын үнэлгээг батлах боломжтой нотолгоонуудад үндэслэн хийнэ.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1–5-р параграф)

- A1. Мэргэжлийн чадавхыг олон янзаар тодорхойлж, ангилдаг. БОУС-ын хувьд мэргэжлийн чадавх гэдэг нь тогтоосон стандартыг үүргийг гүйцэтгэх чадвар юм. Мэргэжлийн чадавх нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадварууд, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагын нэгдэл болон хэрэглээ бөгөөд энэ нь үйл явц, баримт, агуулга болон зарчмын мэдлэгээс илүү юм.
- A2. МАШХ-ийн үед дараах оролцогч талууд үнэлгээг хийж болно. Үүнд: ДНБХ-ны гишүүн байгууллагууд, ажил олгогчид, зохицуулагч байгууллагууд, тусгай зөвшөөрөл олгох нэгжүүд, их сургуулиуд, коллеж, болон боловсрол олгодог хувийн байгууллагууд орно. Хэдийгээр МАШХ-ийн үеэр мэргэжлийн чадавхын үнэлгээ хийх нь ДНБХ-ны үүрэг боловч, бусад оролцогч талууд үнэлгээний үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байж болно.
- A3. Мэргэжлийн нягтлан бодогчид МТХ-ийн үед мэргэжлийн чадавхыг үргэлж хөгжүүлж, хадгалахын тулд насан туршийн сургалтанд үргэлжлүүлэн хамрагддаг. Ажлын орчны өөрчлөлт, карьерын өсөлт, эсвэл шинэ үүрэг нь мэргэжлийн нягтлан бодогчдоос мэргэжлийн чадавхаа нэмэгдүүлэх, шинэ чадавх эзэмшихийг шаардаж болно. Үүнийг БОУС 7 *Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил* (2014)-д тодорхойлсон.

Зорилго (Лав: 7-р параграф)

- A4. МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийг зохих түвшний мэргэжлийн чадавх олж авсан эсэхийг тогтоох нь хэд хэдэн зорилготой. Эдгээр нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн нягтлан бодогчдын ажлын чанарыг сайжруулах, мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг болно.

Мэргэжлийн Чадавхын Албан Ёсны Үнэлгээ (Лав: 8-р параграф)

- A5. Мэргэжлийн чадавхын түвшинд хүрсэн эсэхийг албан ёсоор үнэлэхийн тулд ДНБХ-ны гишүүн байгууллагууд, МАШХ-ийн үед хамрагдсан нэг эсвэл хэд хэдэн үнэлгээний үйл ажиллагаанууд дээр үндэслэн дүгнэлт гаргах нь зүйтэй. МАШХ-ийн үеийн үйл ажиллагаануудын үнэлгээнд дараах үйл ажиллагаанууд байж болох ч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) МАШХ-ийн эцэст нэг удаагийн олон төрлийн сахилгын шийтгэлийн шалгалт хийх;
 - (б) МАШХ-ийн үеэр хийсэн мэргэжлийн чадавхын тодорхой талбаруудад чиглэсэн цуврал шалгалт; эсвэл
 - (в) МАШХ-ийн турш явагдсан цуврал шалгалтууд болон ажлын байрны үнэлгээнүүд.
- A6. Үнэлгээний үйл ажиллагаа нь мэргэжлийн чадавхын тодорхой талбаруудыг тусгайлан үнэлэхээр загварчлагдсан байдаг. МАШХ-ийн үеэр мэргэжлийн чадавхын тодорхой хэсгийг үнэлэхэд хэр зохицож байгаагаас хамааран үнэлгээний үйл

ажиллагааг сонгон авдаг. Үнэлгээний үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаанууд хамрагдах ба үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Бичгийн шалгалт;
- (б) Аман шалгалт;
- (в) Зорилтот тест;
- (г) Компьютерт суурилсан тест;
- (д) Ажил олгогчийн зүгээс чадавхыг үнэлэхээр хийсэн ажлын байрны үнэлгээ; болон
- (е) Ажлын байран дахь үйл ажиллагаануудын эцэст бүрдүүлсэн багц нотолгооны шалгалт.

A7. Үнэлгээний үйл ажиллагаануудыг ДНБХ-ны гишүүн байгууллагууд өөрсдийн тусгайлсан онцлогт тохируулан сонгож болдог. Үүнд дараах хүчин зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчийн газарзүйн байршлын тархалт болон хүртээмж;
- (б) ДНБХ-ны гишүүн байгууллагын боловсролын хүрээмж болон бусад эх үүсвэрүүдийн нөөц;
- (в) Үнэлүүлж буй мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн тоо болон мэдээлэл; болон
- (г) Ажил олгогчдоос зохион байгуулсан сургалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд хамрагдаж боломж.

A8. Мэргэжлийн нягтлан бодогчдын эзэмших ёстой мэргэжлийн чадавхуудын зохистой түвшнийг тогтооход дараах хүчин зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Мэргэжлийн нягтлан бодогчдын нарийн төвөгтэй болон ялгаатай үүрэг;
- (б) Мэргэжлийн чадавхын мөн чанар болон хэр хэмжээний талаарх бусад оролцогч талуудын (олон нийт, ажил олгогч, хууль эрхзүйн зохицуулагч байгууллагууд гэх мэт) хүлээлт;
- (в) Тухайлсан аж үйлдвэрийн салбарт ажиллаж буй мэргэжлийн нягтлан бодогчид шаардлагатай онцгой мэдлэг;
- (г) Ажил үүргийг гүйцэтгэхэд болон үнэлэхэд шаардагдах мэргэжлийн шийдвэр гаргах түвшин;
- (д) Санхүүгийн тайлангийн бэлтгэгч, татварын зөвлөх, эсвэл удирдлагын нягтлан бодогч гэх мэт мэргэжлийн нягтлан бодогчдын ялгаатай үүргүүд; болон
- (е) Ажлын орчны нарийн төвөгтэй байдал.

Үнэлгээний Зарчмууд (Лав: 9-р параграф)

A9. Мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөр нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийг МАШХ-ийн эцэст мэргэжлийн чадвар эзэмших үйл

явцад дэмжих зорилготой. Эдгээр хөтөлбөрүүдэд их дээд сургуулиуд, бусад дээд боловсролын байгууллагууд, ДНБХ-ны гишүүн байгууллагууд, ажил олгогч мөн ажлын байран дахь сургалт зэрэг эрдмийн олгох сургалтууд болон сургалт, дамжааг оруулсан албан боловсролууд багтдаг. Иймд МАШХ-ийн үеийн мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын хөтөлбөрийг гаргахад ДНБХ-оос гадна бусад оролцогч талуудын бодит оролцоо шаардлагатай.

- A10. МАШХ-ийн үеэр нэвтрүүлсэн хувь хүний үнэлгээний үйл ажиллагаануудад үнэлгээний зарчим хэрэгждэг. Гэсэн хэдий ч, хувийн үнэлгээний үйл ажиллагаа бүрд өндөр түвшний найдвартай байдал, хүчин төгөлдөр байдал, эрх тэгш байдал, ил тод байдал, болон хангалттай байдлыг бүрэн хангах байнгын боломж байдаггүй.
- A11. Үнэлгээний үйл ажиллагаа нь хэрвээ ижил нөхцөл байдалд, дараалан ижил үр дүнтэй байсан бол өндөр түвшний найдвартай байдалтай байдаг. Найдвартай байдал нь гарцаагүй хэмжигдэхүүн биш бөгөөд ялгаатай үнэлгээний үйл ажиллагаанууд нь ялгаатай түвшний найдвартай байдалтай байдаг. Хэрвээ үнэлгээчдийн дийлэнх нь өгөгдсөн нөхцөл байдалд бие даан ижил үнэлгээнд хүрвэл, үнэлгээний үйл ажиллагаа нь өндөр түвшний найдвартай байдалтай байна гэсэн үг юм.
- A12. Найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон арга замууд байдаг. Жишээлбэл:
- (a) Бичгийн шалгалтын найдвартай байдлыг шалгалтын асуулт болон зааварт хоёрдмол утгатай үг хэллэг хэрэглэхээс татгалзах замаар нэмэгдүүлж болно;
 - (б) Тест дуусахаас өмнө, дотоодын болон гадны хяналт шалгалт явуулах замаар зорилтот шалгалтын найдвартай байдлыг нэмэгдүүлж болно; мөн
 - (в) Харьцангуй өндөр түвшний ур чадвартай үнэлэгчдийг сонгох болон тэднийг өгөгдсөн даалгаврыг үнэлэх зохистой сургуулилтаар хангах замаар ажлын байрны шалгалтын найдвартай байдлыг нэмэгдүүлж болно.
- A13. Үнэлэхийг зорьсон зүйлсээ үнэлж чадаж байвал үнэлгээний үйл ажиллагаа нь өндөр түвшинд хүчин төгөлдөр байна. Хүчин төгөлдөр байдал нь туйлын хэмжүүр биш юм. Ялгаатай үнэлгээний үйл ажиллагаанууд ялгаатай түвшний хүчинтэй төгөлдөр байдалтай байж болно. Хүчин төгөлдөр байдал нь дараах олон хэлбэртэй байж болно:
- (a) Сэдвийн нийцлийн хүчинтэй байдал - Хэрэв үнэлгээний үйл ажиллагаа нь хэмжихийг зорьсон хэмжилтийн үр дүнд хүрч чадаж байвал үнэлгээний өндөр түвшний сэдвийн нийцэлтэй байна.
 - (б) Таамаглах боломжтой хүчинтэй байдал - Хэрэв үнэлэхээр зорьсон үнэлэх үйл ажиллагааны агуулгын хувьд мэргэжлийн чадавхтай хамааралтай байвал өндөр түвшний таамаглах боломжтой хүчинтэй байдалтай байна.
 - (в) Агуулгын хүчинтэй байдал – Хэрэв үнэлгээний үйл ажиллагаа нь үнэлэгдэж буй мэргэжлийн чадавхын тодорхой агуулга, ойлголтыг агуулж байвал өндөр түвшний агуулгын хүчинтэй байдалтай байна.
- A14. Хүчин төгөлдөр байдлыг нэмэгдүүлэх олон арга замууд байна. Жишээлбэл:
- (a) Мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдийн тодорхой нэг нягтлан бодох стандартыг хэрэглэх чадавхыг шалгахын тулд энгийн, гүйцэд биш мэдээллүүд

дээр үндэслэн шалгахын оронд илүү дэлгэрэнгүй, илүү хамааралтай кейс дээр ажиллуулснаар сэдвийн нийцлийг нэмэгдүүлж болно;

- (б) Бичгийн шалгалтын үр дүнгээс илүүтэйгээр багыг хэр сайн удирдаж байгаагаар нь ажлын байрны үнэлгээ хийснээр удирдах чадварын үнэлгээнд таамаглах боломжтой хүчинтэй төгөлдөр байдлыг нэмэгдүүлж болно; мөн
 - (в) Тодорхой нэг мэргэжлийн чадавхыг үнэлэхийн тулд шалгалтанд цөөн хэдэн ойлголт биш илүү олон ойлголтуудыг оруулснаар агуулгын хүчинтэй төгөлдөр байдлыг нэмэгдэж болно.
- A15. Хэрэв үнэлгээний үйл ажиллагаа нь шударга, төөрөгдөлгүй байвал өндөр түвшний эрх тэгш байдалтай байна. Эрх тэгш байдал нь туйлын хэмжүүр биш бөгөөд ялгаатай үнэлгээний үйл ажиллагаа нь өөр өөр түвшний эрх тэгш байдалтай байж болно. Хэрэв үнэлгээний үйл ажиллагааг боловсруулж байгаа хүмүүс ялгаварлахаас сэргийлэх боломжуудыг мэдэж байвал эрх тэгш байдлыг нэмэгдүүлж болно.
- A16. Эрх тэгш байдлыг нэмэгдүүлэхийн тулд үнэлгээний үйл ажиллагааг дараах олон янзаар зохион байгуулж болно:
- (а) Үнэлгээний үйл ажиллагааг компьютерт суурилсан технологид үндэслэн явуулж байгаа тохиолдолд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид бүгд ашиглах боломжтой эсэхийг тодорхой болгосноор эрх тэгш байдал нэмэгдэнэ.
 - (б) Бүх мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид мэдэх боломжгүй соёлын мэдлэгтэй холбоотой асуултуудыг дахин хянаж асуултуудаас хассанаар эрх тэгш байдал нэмэгдэнэ.
- A17. Үнэлгээний үйл ажиллагаанд чадавхын хүрээний хамрах хүрээ, үйл ажиллагааны хугацаа гэх мэт нарийвчилсан мэдээллүүдийг олон нийтэд зарласнаар ил тод байдлын түвшин өндөр болно. Өндөр түвшний ил тод байдал нь МАШХ-ийн үеийн үнэлгээний үйл ажиллагааг бүхэлд нь авч үзэхэд мөн адил хамаарна. Ил тод байдал нь туйлын хэмжүүр биш бөгөөд ялгаатай үнэлгээний үйл ажиллагаанууд ялгаатай түвшний ил тод байдалтай байж болно. Оролцогч талуудад ойлгомжтой, хүртээмжтэй харилцаатай байх нь өндөр түвшний ил тод байдалд хүргэдэг.
- A18. Үнэлгээний үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх олон арга замууд байдаг. Жишээлбэл:
- (а) МАШХ-ийн үеэр явагдах үнэлэх үйл ажиллагааны бүрэн бүтэн байдалтай холбоотойгоор мэргэжлийн чадавхын аль хэсгийг үнэлэх, үнэлгээний үйл ажиллагааны төрөл, болон үнэлгээний хуваарь зэргийг олон нийтэд нээлттэй мэдээлж зарласнаар ил тод байдлыг нэмэгдүүлж болно;
 - (б) Ажлын байрны үнэлгээнд ажил олгогчид аль ажилтны чадварыг үнэлэх вэ гэхээсээ илүү ажилтны аль чадвар нь үнэлэгдэх боломжтой байна вэ гэдэг тал дээр харилцвал ил тод байдлыг нэмэгдүүлж болно; мөн
 - (в) Шалгалт боловсруулах, үнэлэх, удирдахтай холбоотой мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй байлгаснаар шалгалт зохион байгуулах болон шалгалт авах ил тод байдлыг нэмэгдүүлж болно.

- A19. Үнэлгээний үйл ажиллагаа нь (а) мэдлэг болон хэрэглээний гүнзгий болон өргөн хүрээний тэнцвэртэй байдалтай, (b) олон төрлийн хамрах хүрээг тухайн нөхцөл байдал болон агуулгад хэрхэн ашиглахыг нэгтгэсэн материал байвал өндөр түвшний хүртээмжтэй байна. МАШХ-ийн үеэр явагдах үнэлгээний үйл ажиллагааны бүрэн бүтэн байдалд өндөр түвшний хүртээмжтэй байдал мөн хамаарна. Хүртээмжтэй байдал нь туйлын хэмжүүр биш бөгөөд ялгаатай үнэлгээний үйл ажиллагаанууд нь ялгаатай түвшний хүртээмжтэй байдалтай байж болно.
- A20. Үнэлгээний үйл ажиллагаанд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх олон арга зам байдаг. Жишээлбэл:
- (а) МАШХ-ийн үеэр үнэлэх шаардлагатай техник чадавх, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг нарийвчилсан түвшинд үнэлэх үйл ажиллагаанууд бий болсноор хүртээмжтэй байдал нэмэгдэж болно.
 - (б) Ажлын байрны үнэлгээтэй холбогдолтой хангалттай байдлыг нэмэгдүүлэхийн тулд мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид янз бүрийн нөхцөл байдалд олон төрлийн мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ, ёсзүй, болн хандлагыг хэрхэн ашиглаж байгаа мэргэжлийн чадавхаа үзүүлж болно.

Батлах Боломжтой Нотолгоо (Лав: 10-р параграф)

- A21. Батлах боломжтой нотолгоо гэдэг нь нотлох боломжтой, бичгийн эсвэл цахим хэлбэрээр хадгалсан бодит баримтууд юм. Батлах боломжтой нотолгоо дээр үндэслэсэн мэргэжлийн чадавхын үнэлгээ нь ДНБХ-ны гишүүн байгууллагыг хянадаг эсвэл зохицуулалт хийдэг гуравдагч талын шаардлагад нийцэж болно. Түүнчлэн батлах боломжтой нотолгоо нь МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчид зохих түвшний мэргэжлийн чадавх эзэмшсэн гэдэгт итгэх оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлж болно.
- A22. Батлах боломжтой нотолгооны жишээг дурдвал:
- (а) Сургалт амжилттай дүүргэсний батламж;
 - (б) Шалгалтанл амжилттай үр дүн үзүүлсэнийг нотлох бүртгэл; ба
 - (в) Ажил олгогчдоос мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчдэд заасан чадавхыг эзэмшсэн тухай нотолгоо.

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 7

МЭРГЭЖЛИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ (2014)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1-7
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	8
Зорилго	9
Шаардлага	
МТХ-ийн Дэмжлэг.....	10
МТХ-д Хамрагдах Боломж.....	11
Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчдод Зайлшгүй Шаардлагатай МТХ.....	12-16
Мониторинг ба Хэрэгжилт.....	17
Тайлбар Материал	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A1-A4
МТХ-ийн Дэмжлэг.....	A5
МТХ-д Хамрагдах Боломж.....	A6-A9
Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчдод Зайлшгүй Шаардлагатай МТХ.....	A10-A21
Мониторинг ба Хэрэгжилт.....	A22-A31

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А1–А4-р параграф)

1. Харилцагчид, ажил олгогч болон бусад оролцогч талуудад чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх ингэснээр нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд олон нийтийн итгэлийг бэхжүүлэхийн тулд мэргэжлийн нягтлан бодогч МТХ-ийн хүрээнд зайлшгүй хөгжүүлэн хадгалах шаардлагатай мэргэжлийн ур чадварыг энэхүү Боловсролын Олон Улсын Стандарт (БОУС)-д тодорхойлдог.
2. Энэхүү БОУС нь Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны гишүүн байгууллагуудад чиглэсэн болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь энэ БОУС-ын шаардлагын дагуу мэргэжлийн нягтлан бодогчдын МТХ-ийн шаардлагыг тодорхойлох үүрэг хүлээдэг. Түүнчлэн, энэ БОУС нь мэргэжлийн нягтлан бодогчдын МТХ-ийг дэмждэг боловсролын байгууллага, ажил олгогч, зохицуулагчид, засгийн газрын эрх бүхий байгууллага болон бусад оролцогч талуудад дэмжлэг үзүүлдэг.
3. МТХ-ийн үйл ажиллагаануудаар дамжуулан мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болон хадгалах нь мэргэжлийн нягтлан бодогчдын хариуцлага хэдий ч, энэхүү БОУС нь дараах үүргийг ДНБХ-ны гишүүн байгууллагуудаар хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг:
 - (а) Мэргэжлийн нягтлан бодогчдын насан турш суралцах үйл явцыг дэмжих;
 - (б) Мэргэжлийн нягтлан бодогчдыг МТХ-д суралцах боломж, нөөцөөр хангах;
 - (в) Олон нийтийн эрх ашгийг хамгаалахад хэрэгцээтэй мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх болон хадгалахад мэргэжлийн нягтлан бодогчдод туслах замаар зохих ёсны хэмжилтийн, хяналтын, болон нийцлийн горимуудыг баталж мөрдүүлэх.
4. МТХ нь Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн үргэлжлэл бөгөөд МАШХ нь мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгч цаашид мэргэжлийн нягтлан бодогч болж өөрийн үүргийг чадварлагаар үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжийг олгохын тулд мэргэжлийн чадавхыг хөгжүүлдэг сургалт юм. МТХ нь МАШХ-ийн дараах сургалт ба хөгжүүлэлт бөгөөд мэргэжлийн нягтлан бодогч өөрсдийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаарлагатай мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх болон хадгалахад чиглэдэг. Мэргэжлийн тасралтгүй хөгжил нь (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадварууд, (в) мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй ба хандлага, болон (г) мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлтээр олж авсан чадварууд зэргийг хангадаг ба эдгээр нь мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийн үйл ажиллагаа ба хариуцлагыг оновчтой боловсронгуй болгоход чиглэдэг. Түүнчлэн мэргэжлийн нягтлан бодогчид шинэ ур чадвар шаардсан шинэ үүрэг гүйцэтгэж болно. Ийм тохиолдолд, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн явцад мэргэжлийн анхан шатны хөгжүүлэлтийн хүрээнд судалдаг ур чадварууд дээр нэмж өргөн хүрээний эсвэл гүнзгий мэдлэг, ур чадварууд болон үнэ цэний үүрэг хариуцлагад шаардлагатай ур чадваруудыг эзэмшинэ.
5. МТХ нь боловсрол, практик туршлага болон сургалтаас гадна (а) дасгалжуулах болон зөвлөгөө өгөх, (б) танилын хүрээ тэлэх, (в) ажиглалт хийх, санал хүсэлт өгөх, ба эргэцүүлэл хийх, (г) өөрт чиглэсэн болон тодорхой бус мэдлэг олж авах зэрэг сургалт ба хөгжүүлэлтийн үйл ажиллагааг мөн хамардаг.
6. МТХ-д хамрагдаж байгаа эсэхийг дараах гурван хандлагаар хэмждэг:

- (а) Гарцад суурилсан хандлага- мэргэжлийн нягтлан бодогчийг мэргэжлийн ур чадвараа хөгжүүлж, хадгалсан эсэхээ харуулахыг шаарддаг үр дүнд тулгуурласан гарцын арга;
 - (б) Орцод суурилсан хандлага - мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалахад шаардагдах сургалтын хэмжээг тодорхойлох арга;
 - (в) Нийлмэл хандлага - орц болон гарцад суурилсан хандлагын элементүүдийг үр ашигтай байдлаар нэгтгэх замаар мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалахад шаардагдах сургалтын хэмжээ болон хүрэх үр дүнг тодорхойлдог арга хандлага.
7. Энэхүү БОУС ба *Мэргэжлийн Нягтлан Бодогч болон Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгчдэд зориулсан Боловсролын Олон Улсын Стандартын Тунхаглал (2015)*-д хэрэглэсэн гол нэр томъёоны тодорхойлолт ба тайлбарыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-ийн *Нэр Томъёоны Тайлбар*-т тусгасан.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

8. Энэхүү БОУС-ыг 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго

9. ДНБХ-ны гишүүн байгууллагын зорилго нь харилцагчид, ажил олгогч болон бусад оролцогч талуудад олон нийтийн эрх ашигт нийцсэн чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэхийн тулд МАШХ-ийн дараа зохих ёсны мэргэжлийн МТХ-ийн чадавхыг хөгжүүлж, хадгалсан мэргэжлийн нягтлан бодогчдыг бэлтгэхэд оршино.

Шаардлагууд

МТХ-ийн Дэмжлэг (Лав: А5-р параграф)

10. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн чадавхыг хадгалах болон МТХ-ын ач холбогдлыг сурталчлах, таниулах, дэмжих үүрэгтэй.

МТХ-д Хамрагдах Боломж (Лав: А6-А9-р параграф)

11. ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдыг МТХ-ийн дагуу хүлээсэн хувийн үүргээ биелүүлэх болон мэргэжлийн чадавхаа хадгалахад туслахын тулд МТХ-д хамрагдах боломж, нөөцөөр хангах ёстой.

Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчдод Зайлшгүй Шаардлагатай МТХ (Лав: А10-А13-р параграф)

12. ДНБХ-ны гишүүн байгууллагууд бүх мэргэжлийн нягтлан бодогчдоос өөр өөрсдийн ажил, мэргэжлийн үүрэг хариуцлагад тохирсон мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх болон эзэмшихийн тулд МТХ-д хамрагдахыг шаардах хэрэгтэй.

13. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчдын МТХ-ийн үйл ажиллагааг хэмжихдээ дараах гурван аргаас аль илүүд үзсэн хандлагыг сонгоно. Үүнд: гарцад суурилсан, орцод суурилсан эсвэл нийлмэл хандлага.

Гарцад Суурилсан Хандлага (Лав: А14-А15-р параграф)

14. Гарцад суурилсан хандлагыг хэрэгжүүлж байгаа ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогч бүрийг зохих ёсны мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалсан эсэхийг дараах нотолгоонд үндэслэн тогтсон хугацаанд шаардана:
- (а) Шаардлага хангасан эх үүсвэрээс баталгаажсан байх; ба
 - (б) Чадавхыг үнэлэх оновчтой аргыг ашиглан хэмжсэн байх.

Орцод Суурилсан Хандлага (Лав: А16-А20-р параграф)

15. Орцод суурилсан хандлагыг хэрэгжүүлж буй ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдоос доорх зүйлсийг шаардана:
- (а) 3 жил тутамд дор хаяж 120 цаг (эсвэл түүнтэй дүйцэх сургалтын нэгж) мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд зориулсан сургалтын хөтөлбөрт хамрагдсан байх ба үүнээс 60 цагийг (эсвэл түүнтэй дүйцэх сургалтын нэгж) баталгаажуулсан байх;
 - (б) Жил бүр дор хаяж 20 цаг (түүнтэй тэнцэх норматив цаг) мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан байх;
 - (в) Дээрх шаардлагуудыг хангасан сургалтын үйл ажиллагааг үнэлж, хэмждэг байх.

Нийлмэл Хандлага (Лав: А21-р параграф)

16. Орц ба гарцын нийлмэл хандлагыг хэрэгжүүлж байгаа ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь энэ БОУС-д тодорхойлсон орц, гарцад суурилсан хандлагын тохирох шаардлагуудыг дагаж мөрдөнө.

Мониторинг ба Хэрэгжилт (Лав: А22-31-р параграф)

17. ДНБХ-ны гишүүн байгууллагууд (i) мэргэжлийн нягтлан бодогчид ДНБХ-ны гишүүн байгууллагуудын МТХ-ийн шаардлагад нийцэж байгаа эсхиг хянах; мөн (ii) эдгээр шаардлагуудыг хангаж чадаагүй тохиолдолд мөрдөх зохих шийтгэлийг бий болгох системтэй үйл явцыг боловсруулах ёстой.

Тайлбар Материал

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1-7-р параграф)

- A1. Мэргэжлийн нягтлан бодогчийн хувьд үр дүнтэй ажиллахад шаардагдах мэдлэг үргэлж өссөөр байна. Мэргэжлийн нягтлан бодогчид мэргэжлийн чадавхаа харуулах өсөн нэмэгдэж буй хүлээлттэй нүүр тулдаг. Эдгээр дарамтууд нь бүх салбарын мэргэжлийн нягтлан бодогчдод тулгардаг. Мэргэжлийн нягтлан бодогч нь олон нийтийн хүлээлтэнд хүрч ажиллахад мэргэжлийн чадавхыг үргэлжүүлэн хөгжүүлэх болон хадгалах, мөн насан туршид суралцах үйл явц чухал нөлөөтэй. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил байнгын өөрчлөлттэй орчинд ажилладаг тул ДНБХ-ны гишүүн байгууллагууд МТХ-ийн бодлого болон энэ БОУС-ын хэрэглээг тогтсон хугацаанд хянаж байх хэрэгтэй.
- A2. МТХ-д хамрагдсанаар бүх мэргэжлийн нягтлан бодогчид бүх цаг үед өндөр чанартай мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ гэсэн баталгаа байхгүй. Энэ нь ёс суртахууны зан байдал, мэргэжлийн шийдэл, бодит хандлага болон удирдлагын зохистой түвшнийг шаарддаг. Цаашлаад, МТХ-ийн хөтөлбөрт хамрагдсан мэргэжлийн нягтлан бодогч бүр хөтөлбөрийн үр ашгийг бүрэн олж авдаггүй. Энэ нь мэргэжлийн нягтлан бодогчийн сурах эрмэлзэл боломж болон чадамжаас хамаардаг. Гэсэн хэдий ч, МТХ нь мэргэжлийн нягтлан бодогч нарт өөрсдийн үүрэгтэй холбоотой мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх болон хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд, төрөлхийн хязгаарлалтыг үл хамааран МТХ нь олон нийтийн итгэл, найдварыг хадгалах чухал элементийн нэг юм.
- A3. Хэмжиж, хянаж мөн үнэлсэн (өөрөөр хэлбэл сайтар боловсруулсан) МТХ нь ДНБХ-ны гишүүн байгууллагын чанарын баталгааны үйл явцын нэг хэсгийг бий болгодог. Бусад чанарын баталгааны үйл явц гэдэгт чанарын баталгааны дараах хяналтууд орно: (а) мэргэжлийн нягтлан бодогчдын ажил (мэргэжлийн нягтлан бодогчийн дүүргэсэн МТХ-ийг хянах байж болно), (б) эрэл хайгуул, мөн (в) зөрчил хийх үед хүлээх сахилгын арга хэмжээ авах үйл явц.
- A4. Насан туршид суралцах үйл явц гэдэгт хувийн, иргэний, нийгмийн, болон ажил эрхлэгчийн байр сууринаас хувийн мэдлэг, ур чадвар, үнэ цэнэ, ёс зүй ба хандлагыг сайжруулах зорилгоор хийгдэж буй албан ба албан бус бүх суралцах үйл явцын болон хөгжүүлэлтийн үйл ажиллагаа орно. Насан туршийн сургалтын үйл явц нь нягтлан бодох бүртгэлийн салбар эсвэл бусад салбарт хамрагдсан эсэхээс үл хамааран бүх мэргэжлийн нягтлан бодогчидтой холбоотой байдаг.

МТХ-ийн Дэмжлэг (Лав: 10-р параграф)

- A5. МТХ-д хамрагдах боломж болон мэргэжлийн чадварын хадгалалтыг тодорхойлох үйл ажиллагааны жишээг дурдвал :
- (а) МТХ-ийн үнэ цэнийг мэргэжлийн нягтлан бодогчдод тогтмол мэдээлэх;
 - (б) Мэргэжлийн нягтлан бодогчдод зориулсан МТХ-ийн янз бүрийн боломжуудыг дэмжих;
 - (в) Гүйцэтгэлийн удирдлагын үйл явцын хүрээнд МТХ-ийн чухал ач холбогдлыг онцлохын тулд ажил олгогчтой ажиллах.

МТХ-д Хамрагдах Боломж (Лав: 11-р параграф)

- А6. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчдод хамаарах МТХ-ийг хөтөлбөрийг шууд хангах ёстой ба мөн ажил олгогчид зэрэг бусад газрын санал болгосон хөтөлбөрт хамрагдах боломжоор хангах ёстой.
- А7. МТХ-ийн төлөвлөгөөт хөтөлбөрийн нэг хэсэг болсон үйл ажиллагааны зарим нэгийг дор дурдвал:
- (а) Сургалт, хурал, семинарт оролцох;
 - (б) Өөрийгөө чиглүүлэх сургалт;
 - (в) Ажлын байран дахь сургалт;
 - (г) Техникийн хороодод оролцох, ажиллах;
 - (д) Мэргэжлий үүрэг хариуцлагатай холбоотой МТХ-ийн зөвлөгөөн эсвэл сургалтыг хөгжүүлэх эсвэл сургалт зохион байгуулах;
 - (е) Мэргэжлийн үүрэг хариуцлагатай холбоотой албан ёсны судалгаа;
 - (ё) Хурал, зөвлөгөөн, эсвэл хэлэлцүүлгийн багт илтгэгчээр оролцох;
 - (ж) Техникийн, мэргэжлийн эсвэл эрдмийн ажлын чиглэлээр ном, сурах бичиг, бүтээл бичих;
 - (з) Мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн ном, сэтгүүл унших замаар судалгаа хийх;
 - (и) Мэргэжлийн дахин шалгалт болон албан ёсны шалгалт;
 - (й) Багш, дасгалжуулагч хийх замаар мэргэжлийн хөгжүүлэлтийг дэмжих; ба
 - (к) Багш болон дасгалжуулагчаас мэргэжлийн хөгжлийн тусламж хүлээн авах.

ДНБХ-ны гишүүн байгууллагууд нэг адил боловч олон дахин давтагддаг (жишээ нь: ялгаатай хүмүүст нягтлан бодох бүртгэлийн танилцуулах сургалтыг заах) үйл ажиллагаанаас олж эзэмшсэн МТХ-ийг хэрхэн дүгнэх тал дээр удирдамж боловсруулах хэрэгтэй.

- А8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчдод МТХ-ийг төлөвлөхөд тусалж дараах хэрэгслүүдээр хангах нь зүйтэй:
- (а) Мэргэжлийн тодорхой үүрэг болон салбарт шаардагдах чадавхыг жагсаасан чадавхын зураг; болон
 - (б) Мэргэжлийн нягтлан бодогчдод сурах, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох болон түүнийг хэрхэн эзэмшиж болохыг харуудсан сургалтын төлөвлөгөөний загвар.
- А9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчдыг өөрсдийн МТХ-ийн тухай ажил олгогч, хамт олонтойгоо ярилцахад дэмжлэг үзүүлэх талаар удирдамж боловсруулж болох ба энэ нь ДНБХ-ны гишүүн байгууллагууд шаардлагатай

сургалтын хэрэгцээ болон чадавхыг тодорхойлж, түүнд тохирсон чадавхыг эзэмшүүлэх сургалтын боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчдод Зайлшгүй Шаардлагатай МТХ (Лав: А12-13-р параграф)

А10. МТХ нь эрхэлж буй бизнесийн цар хүрээ ба ажиллаж байгаа салбараас үл хамааран бүх мэргэжлийн нягтлан бодогчдод хамаарна. Учир нь:

- (а) Бүх нягтлан бодогчид өөрсдийн үйлчлүүлэгчид, ажил олгогчид, болон холбогдох оролцогч талуудын өмнө хянамгай байх үүрэг хүлээсэн бөгөөд энэ үүргээ ямар ч нөхцөлд биелүүлнэ гэдгээ харуулах чадвартай байх ёстой;
- (б) Бүх салбарт ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг олон нийтийн итгэл найдварыг хадгалах үүрэгтэй;
- (в) Олон нийт ихэнхдээ мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэжлийн зэрэг буюу нэр хүндэд найдах хандлагатай байдаг. Мэргэжлийн нягтлан бодогчид мэргэжлийн зэрэгтэй болдог. Мэргэжлийн нягтлан бодогчийн ур чадварын дутагдал нь мэргэжлийн нягтлан бодогч, ажил олгогч, ер нь бүхэлдээ мэргэжлийн нэр хүнд болон тогтвортой байдалд хохирол учруулж болзошгүй;
- (г) Орчны хурдацтай өөрчлөлт нь мэргэжлийн нягтлан бодогчдын ур чадварын нийцэлд нөлөөлөх магадлалтай; болон
- (д) Мэргэжлийн нягтлан бодогчийг ажилд авч буй ажил олгогч тодорхой хэмжээнд мэргэжлийн ур чадварын баталгаа болгож мэргэжлийн зэрэгт найддаг.

А11. ДНБХ-ны гишүүн байгууллагууд МТХ-ийн шаардлагыг боловсруулахдаа тухайн нөхцөл байдлаас хамааран тохирох шаардлагыг ямар нөхцөл байдлаар тусгах тухай сайтар тооцох хэрэгтэй, жишээ нь:

- (а) Карьер завсардсан хувь хүмүүс; ба
- (б) Бүтэн цагийн /орон тооны/ ажил эрхэлж байгаад тэтгэвэрт гарсан хувь хүмүүс. Жишээ нь, мэргэжлийн нягтлан бодогчийн зэргээ үргэлжлүүлэн ашиглаж байгаа эсвэл тодорхой хэмжээнд ажил үргэлжлүүлэн эрхэлж байгаа хүмүүс.

А12. ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдын түгээмэл гүйцэтгэх ажил үүрэгт хамаарах МТХ-ийн шаардлага, болон зөвлөмжүүдээс аль зохистойг сонгож болно. Өөрөөр хэлбэл, ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчид өөрт тохирох МТХ-ийн үйл ажиллагаанаас сонгон суралцах шийдвэрт найддаг. Харин ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь тодорхой чиглэлд ажилладаг мэргэжлийн нягтлан бодогчдыг бусад чиглэлийн МТХ-ийн үйл ажиллагаанд хамрагдах уян хатан шаардлага болон зөвлөмжөөс сонгох боломжийг олгодог.

А13. ДНБХ-ны гишүүн байгууллагууд олон нийтийн эрх ашгийг хамгаалахын тулд нарийн мэргэшсэн чиглэлээр, нарийн мэргэшсэн ажил үүрэг гүйцэтгэж байгаа, эсвэл өндөр түвшний эрсдэлтэй орчинд ажилладаг мэргэжлийн нягтлан бодогчдод тусгайлсан эсвэл нэмэлт МТХ хөтөлбөр боловсруулж болох юм.

Гарцад Суурилсан Хандлага (Лав: 14-р параграф)

- A14. Гарцад суурилсан систем дэх баталгаажуулалтын найдвартай байдал чухал байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллагууд өөрийн сонгосон хандлагад дараах үндсэн элементүүдийг тусгахыг дэмждэг:
- (а) Хүрэх үр дүн болон эзэмших чадварыг ойлгомжтой тодорхойлох; мөн
 - (б) Хүрэх үр дүн болон эзэмших чадварыг хөгжүүлж, хадгалсан гэдгийг холбогдох чадавхыг ашиглан харуулах.
- A15. Дараах жагсаалтанд гарцад суурилсан хандлагын үед баталгаажуулалтын зорилгоор ашиглаж болох нотолгоог харуулав:
- (а) Хянан тохиолдуулагчийн бичсэн эсвэл хэвлэн нийтэлсэн материалын үнэлгээ болон дүгнэлт;
 - (б) Сургалтын үр дүнгийн үнэлгээ;
 - (в) Мэргэжлийн нийтлэл эсвэл судалгааны төслийн үр дүнгийн хэвлэл;
 - (г) Ээлжит дахин шалгалт;
 - (д) Нарийн мэргэших эсвэл бусад мэргэжлийн зэрэг авах;
 - (е) Ур чадварын зураглалын дагуу гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл (ажлын бүртгэлүүд);
 - (ё) Чадварын зураглалыг үндэслэн хувь хүний чадавхын түвшнийг харуулахын тулд хийж гүйцэтгэсэн ажлын түүх (ажлын тэмдэглэл);
 - (ж) МТХ-ийг үнэлэх хараат бус туршлагын шалгалт; ба
 - (з) Зохицуулагчийн үнэлгээ болон чадавхын баримт бичгийг боловсронгуй болгох мэргэжилтний харилцаа холбооны үнэлгээ.

Орцод Суурилсан Хандлага (Лав: 15-р параграф)

- A16. Хэмжих ба баталгаажуулахад хялбар байдаг учраас чадавхын хөгжил болон түүнийг хадгалах явцыг хэмжихэд орцод суурилсан хандлагыг ашигласаар ирсэн. Гэхдээ орцод суурилсан хандлагад зарим хязгаарлагдмал байдал ажиглагддаг. Жишээ нь, уг арга хандлагаар суралцах үйл ажиллагааны гарц буюу үр дүн, хөгжүүлсэн ур чадварыг үргэлж хэмждэггүй. Иймд ДНБХ-ны гишүүн байгууллагууд насан туршийн сургалт ба ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх үндсэн зорилгод анхаарах замаар эдгээр хязгаарлалтуудыг багасгаж болно.
- A17. Энэ стандартаар орцод суурилсан МТХ-ийн үйл ажиллагааг цаг эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний нэгжид үндэслэн хэмжинэ. ДНБХ-ны зарим гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдод ойлгомжтой байх өөр хэмжилтийн нэгжийг сонгон ашиглаж болно. Орцод суурилсан МТХ-ийн хэмжилтийн жишээ:
- (а) Сурах үйл ажиллагаанд зарцуулсан цаг;
 - (б) МТХ-ийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын сурах үйл ажиллагаанд хуваарилсан сургалтын нэгж; болон

(в) ДНБХ-ны гишүүн байгууллагын сурах үйл ажиллагаанд зөвлөсөн нэгжүүд.

A18. Энэхүү БОУС нь ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдын сургалтын үйл ажиллагааг харьцааг тооцоолох агуулга дээр үндэслэн баталгаажуулах боломжтой гэсэн ойлголт дээр суурилдаг. Зарим сургалтын үйл ажиллагаанууд хэмжиж болох ч баталгаажуулах боломжгүй байдаг ба үүний жишээ нь, ажлын байран дээрх сургалт юм. Эдгээр үйл ажиллагааг чадавхыг хөгжүүлэх ба хадгалах шаардлагын биелэлтэд оруулж тооцдог боловч гурван жил тутамд баталгаажуулвал зохих МТХ-ийн 60 цагийн нормативд оруулахгүй.

A19. ДНБХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн нягтлан бодогчдод зориулан баталгаажуулах боломжтой бөгөөд нэг жилд зайлшгүй хамрагдах 20 цагийн шаардлагыг ямар харьцаатай байх тухай зөвлөмж гаргаж болно. Эдгээр зөвлөмжийг гаргахдаа ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь орон нутгийн хууль, эрх зүй зохицуулалтын шаардлагууд ба бусад оролцогч талуудын хүлээлтийг авч үздэг.

A20. Дараах жишээнүүд нь орцод суурилсан хандлагын үед баталгаажуулалт хийхэд ашиглаж болох нотолгоог илэрхийлнэ:

- (а) Сургалтын хөтөлбөр болон сургалтын материал;
- (б) Үйлчилгээ үзүүлэгч, удирдагч, ажил олгогч, зөвлөгч болон чиглүүлэгчдийн оролцооны баталгаажуулалт; мөн
- (в) Сургалтын үйл ажиллагаа явагдсаныг нотлох хараат бус дүгнэлт.

Нийлмэл Хандлага (Лав: 16-р параграф)

A21. МТХ-ийн нийлмэл хандлагыг хэрэгжүүлэх хэд хэдэн сонголтот арга бий:

- (а) Орцод суурилсан систем давамгайлсан мэдлэгийн хамрах хүрээнд эзэмшсэн чадавхад орцын нөлөө байгаа гэж үзсэн тохиолдолд орц ба гарцад суурилсан системийн шаардлагыг баримтлах;
- (б) Орцод суурилсан хандлагын шаардлагыг хангаагүй боловч ур чадвараа хөгжүүлж хадгалсан гэдгээ баталсан мэргэжлийн нягтлан бодогчийг хүлээн зөвшөөрөх; эсвэл
- (в) Тухайн чадавхыг эзэмшихийн тулд шаардлагатай хүчин чармайлт гаргасныг илтгэх тодорхой тооны сургалтын цагийг тогтоож, үүнийг сургалтын үйл ажиллагааны үр дүнд эзэмшвэл зохих чадавхыг баталгаажуулах замаар хамт хэрэглэх.

Мониторинг ба Хэрэгжилт (Лав: 17-р параграф)

A22. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалсаныг баримтаар хэрхэн нотлох тухай удирдамжаар хангаж болно. Тус зөвлөмжид мэргэжлийн нягтлан бодогчийн дараах үүрэг хариуцлагыг тусгаж болно:

- (а) МТХ-гэй хамааралтай бүртгэл болон баримтын зохистой хадгалалт; ба

- (б) ДНБХ-ны гишүүн байгууллагын МТХ-ийн шаардлагуудад нийцсэн баталгаажуулах нотолгооны тухай заалт.

Мониторинг хийх аргаа тодорхойлохдоо ДНБХ-ны гишүүн байгууллагууд чухам ямар гишүүд нь олон нийтийн өмнө хамгийн их хариуцлага хүлээж байгаа, эсвэл олон нийтэд хамгийн их эрсдэл учруулж болохыг харгалзан үзэж тэдгээрт тохирсон нарийн мониторинг хийх ёстой.

A23. Мониторинг хийх үйл явцад мэргэжлийн нягтлан бодогчдоос доорх зүйлсийг тогтмол шаарддаг:

- (а) Мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшиж, түүнийг гүйцэтгэх чадамжтай байгаа эсэх талаар мэдэгдэл хүргүүлж байх;
- (б) ДНБХ-ны гишүүн байгууллагын тавьж байгаа МТХ-ийн шаардлагуудыг биелүүлж байгаа эсэх талаар мэдэгдэл хүргүүлж байх; эсвэл
- (в) Өөрийн сонгосон МТХ-ийн хөтөлбөрийн дагуу мэргэжлийн чадавхаа сургалтын үйл ажиллагаагаар хөгжүүлж, түүнийгээ хадгалж байгаа гэдгээ бататгаажуулж нотолгоогоор хангах.

A24. Мониторингийн нэмэлт үйл явцад доорх зүйлс орно:

- (а) МТХ-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд зарим мэргэжлийн нягтлан бодогчдоос түүвэрлэн аудит хийх;
- (б) Чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөө эсвэл МТХ-ийн баримт бичгийг хянах болон үнэлэх; эсвэл
- (в) Олон төрлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ажил олгогчдыг МТХ-ийн хөтөлбөрт хамруулах болон тэдгээрийн чанарын хяналтын хөтөлбөрт үр дүнтэй мониторинг хийх мөн тэдгээрийн цаг бүртгэлийн системд үндэслэн МТХ-ийн үйл ажиллагааг хянах.

A25. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь тодорхой мөчлөгийн хугацаанд мониторингийн үйл явцын цогц ажиллагааг явуулж болно. Тодорхой мөчлөг бүхий мониторингийн үйл явцын үргэлжлэх хугацааг тодорхойлоход, ДНБХ-ны гишүүн байгууллага нь хүрээлэн буй орчинд үндэслэлтэй байгаа зүйлсийг авч үзнэ. Үүнд: (а) олон нийтийн эрх ашиг, (б) оролцогч талууд, эрх бүхий хүмүүс болон нийтийн хүлээлт. Зарим ДНБХ-ны гишүүн байгууллагын туршлагаас үзэхэд таван жилээс илүү мөчлөгийн хугацаа нь дээрх хүлээлттэй нийцдэггүй бол мөн нэг жилээс доош хугацаатай мөчлөг нь ДНБХ-ны гишүүн байгууллага болон мэргэжлийн нягтлан бодогчдод илүү ачаалал, хүндрэл учруулах хандлагатай байдаг.

A26. МТХ-ийн дагуу хүлээсэн үүргийг биелүүлээгүй мэргэжлийн нягтлан бодогчдыг тогтсон хугацаанд МТХ-д хамруулах үед албан ёсны МТХ-ийн систем илүү үр дүнтэй ажиллаж олон нийтийн эрх ашгийг хамгаалдаг. ДНБХ-ны гишүүн байгууллагууд өөрийн улсын хууль эрх зүй болон бусад орчны нөхцөлийг харгалзан үзсэний дараа МТХ-ийг дагаж мөрдөөгүй үед ногдуулах шийтгэлийн төрлүүдийг тодорхойлохыг зөвлөдөг.

- A27. МТХ-ийн шаардлагыг дагаж мөрдөхгүй байгаа үед хийгдэх анхны алхам нь мэргэжлийн нягтлан бодогчийг зохих хугацааны дотор шаардлага биелүүлэхэд нь туслахад чиглэнэ. Ингэхдээ ДНБХ-ны гишүүн байгууллагууд (а) мэргэжлийн нягтлан бодогчийг МТХ-ийн шаардлагыг хойшлуулах буюу түүнээс зайлсхийхэд хүргэсэн нөхцөл байдлыг зөвшөөрөх, эсвэл (б) хэтэрхий чанга шийтгэл оногдуулахын аль алины тэнцвэрийг хангах ёстой.
- A28. ДНБХ-ны зарим байгууллагууд нь МТХ-ийг дагаж мөрдөөгүй мэргэжлийн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх эсвэл тэдний дадлагажих болон ажиллах эрхийг хориглох хууль ёсны эрхтэй байж болдог. Мэргэжлийн нягтлан бодогчдын дадлагажих болон ажиллах эрхийн түдгэлзүүлэлт эсвэл хориг нь ДНБХ-ны асуулгад хариулсан хариултыг харахад тохирохгүй гэдэг нь мэдэгдсэн мөн цаашлаад МТХ-ийн шаардлагыг бараг л биелүүлэх боломжгүй гэдэг нь тодорхой байгаа мэргэжлийн нягтлан бодогчдод хэрэгжинэ. Тавьсан шаардлагыг санаатайгаар биелүүлээгүй мэргэжлийн нягтлан бодогчдын нэрсийг олонд нийтлэх боломжтой. Нэрсийг олон нийтэд нийтлэх нь (а) мэргэжлийн нягтлан бодогчдыг өрөнхийд нь тогтоон барих, болон (б) мэргэжлийн чадавхыг хадгалах эрмэлзлийг олон нийтэд ойлгуулах тодорхой дохио болж болно.
- A29. Сахилгын шийтгэл хүлээлгэх нь ёс төдий арга хэмжээ авна гэсэн үг биш юм. Мэргэжлийн нягтлан бодогч санаатайгаар мэргэжлийн чадавхаа хөгжүүлээгүй бөгөөд түүнийгээ хадгалж чадахгүй байх нь сахилгын шийтгэл хүлээлгэхэд хүргэсэн мэргэжлийн үүрэг хариуцлагын зөрчил төдийгүй энэ нь олон нийтийн эрх ашигт үйлчлэх чадварыг үгүй болгодог.
- A30. Үр дүнтэй мониторинг хийх болон хэрэгжилтийг хангуулах үйл явцад зохих ёсны нөөц бололцоо шаардлагатай. ДНБХ-ны гишүүн байгууллагууд МТХ-ийн шаардлагыг хянах, мониторинг хийх болон хэрэгжилтийг хангуулах үйл явцыг хэрэгжүүлэхийн тулд хороо эсвэл зөвлөл байгуулан ажиллаж болно.
- A31. Олон нийтийн эрх ашгийн хариуцлагын хүрээнд ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь өөрсдийн гишүүдийг энэхүү БОУС-д заасан МТХ-ийн шаардлагад хэр нийцэж байгаа талаар олон нийтэд мэдээлэхийг дэмждэг.

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 8

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХАРИУЦСАН ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕРЫН МЭРГЭЖЛИЙН ЧАДАВХ (2016)

АГУУЛГА

	Параграф
Танилцуулга	
Энэ Стандартын Цар Хүрээ.....	1–5
Хүчинтэй Мөрдөх Хугацаа.....	6
Зорилго	7
Шаардлага	8–9
Тайлбар Материал	
АБОУСЗ-ийн Тунхаглалын Баримт Бичгүүдэд Ашигласан Нэр Томьёоны Лавлагаа.....	A1
Энэ Стандартын Цар Хүрээ.....	A2–A16
Зорилго	A17–A18
Шаардлага	A19–A31

Танилцуулга

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: А2–А16-р параграф)

1. Санхүүгийн тайлангийн аудитад гэрээт ажлын партнерын¹ үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн нягтлан бодогч зайлшгүй хөгжүүлж, хадгалах шаардлагатай мэргэжлийн ур чадварыг энэхүү Боловсролын олон улсын стандарт (БОУС)-д тодорхойлдог.
2. Энэхүү БОУС-ыг ДНБХ-ы гишүүн байгууллагуудад зориулан боловсруулсан болно. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь мэргэжлийн нягтлан бодогчдын мэргэжлийн тасралтгүй хөгжил (МТХ) болон тэдний насан туршдаа суралцах хүсэл зоригийг хөхүүлэн дэмжих үүргийг хүлээдэг. БОУС 7 “*Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил*” (2014)²-ийн дагуу, ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь эрхэлж буй ажил ба мэргэжлийн үүрэг хариуцлагад хамааралтай бөгөөд тохирохуйц мэргэжлийн чадвараа хөгжүүлж, байнга хадгалахыг бүх мэргэжлийн нягтлан бодогчдоос шаардах үүрэгтэй. БОУС 7-д заасан дээрх шаардлагыг гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэх үед БОУС 8, *Санхүүгийн Тайлангийн Аудит Хариуцсан Гэрээт Ажлын Партнерын Мэргэжлийн Чадавх* (2016)-ийн дагуу тавих шаардлага болгон мөрдөх юм. Практик туршлага оролцуулсан МТХ-ийн үйл ажиллагаа явуулах замаар мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх, хадгалах нь гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг юм.
3. Энэхүү БОУС-ыг Гишүүний үүргийн мэдэгдэл (ГҮМ) 1-*Чанарын баталгаажуулалт*, Аудитын олон улсын стандарт (АОУС) 220, *Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт*, Чанарын хяналтын олон улсын стандарт (ЧХОУС) 1, *Санхүүгийн тайлангийн аудит ба нягтлах ажил гүйцэтгэдэг болон бусад баталгаажуулах болон холбогдох үйлчилгээ үзүүлдэг компаниудын чанарын хяналт* зэрэг баримт бичгийн хамт уншвал зохино. орох юм. Эдгээр тунхаглалын баримт бичгүүд хамтдаа ДНБХ-ны гишүүн байгууллагууд, гэрээт ажлын партнер, компаниудын санхүүгийн тайлангийн аудитад хийх чанарын хяналтын системийн нэг хэсэг болж, үүрэг хариуцлага ногдуулах юм. Түүнчлэн, ихэнх эрх зүйн орчны хувьд, чанарын хяналтын ийм системд хөндлөнгөөс хяналт тавих үүргийг зохицуулагч байгууллагууд хүлээдэг. Эдгээр оролцогч талууд тус бүрдээ гэрээт ажлын партнерын мэргэжлийн ур чадварт нөлөөлөх боломж бий.
4. ДНБХ-ны гишүүн байгууллагууд эсвэл бусад оролцогч тал нь энэхүү БОУС-ын шаардлагыг АОУС-д нийцүүлэн бусад түүхэн санхүүгийн мэдээллийн аудит хийх эсвэл баталгаажуулах болон бусад холбогдох үйлчилгээний хувьд гэрээт ажлын партнерүүдтэй ижил төстэй үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн нягтлан бодогчдод тавьж болно.
5. Энэхүү БОУС болон *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Боловсролын Олон Улсын Стандартын Онолын Үзэл Баримтлал ба Мэргэжлийн Нягтлан Бодогч Болохыг Эрмэлзэгч* (2015)-д ашигласан нэр томъёоны тодорхойлолт нь тайлбарын хамт Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-өөс гаргасан *Нэр Томъёоны Тайлбар* (2015)-т багтсан болно. Аудит ба баталгаажуулалтын олон улсын стандартын зөвлөл (АБОУСЗ)-ийн тунхаглалын баримт бичгээс зарим нэр томъёог авч, мөн Тайлбар Материалд оруулсан байгаа.

Хүчинтэй Мөрдөх Хугацаа

¹ Энэхүү БОУС-ын зорилгоор, цаашид “Гэрээт ажлын партнер” гэх нэр томъёог Аудитын олон улсын стандарт (АОУС) 220, *Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт*, 7-р Параграф (а)-д зааснаар ашиглана.

² БОУС 7 “*Мэргэжлийн Тасралтгүй Хөгжил*” (2014), 12-р Параграф

6. Энэхүү БОУС-ыг 2016 оны 07 сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго (Лав: А17–А18-р параграф)

7. Гэрээт ажлын партнерын үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн нягтлан бодогч өөрийн чадавхаа хөгжүүлж, хадгалах шаардлагыг тогтоох нь энэхүү БОУС-ын зорилго юм.

Шаардлага (Лав: А19–А31-р параграф)

8. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь Хүснэгт А-д жагсаасан, гэхдээ түүгээр үл хязгаарлагдах сургалтын үйл ажиллагааны үр дүнгээр илэрхийлэгдэхүйц түвшинд мэргэжлийн чадавхаа хөгжүүлж, хадгалахыг мэргэжлийн нягтлан бодогчдоос шаардах болно.
9. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадавхыг хөгжүүлж, хадгалах боломж олгохуйц МТХ-ийн үйл ажиллагаанд хамрагдахыг гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдоос шаарддаг.

Хүснэгт А: Гэрээт Ажлын Партнерт Мэргэжлийн Чадавх Суулгах Сургалтын Үр Дүн

Ур Чадварын Хамрах Хүрээ	Суралцах Үйл Явцын Үр Дүн
Техникийн Чадавхи	
(а) Аудит	(i) Аудитын ерөнхий стратегийн нэг хэсэг болох. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тогтоон үнэлэх.
	(ii) Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн хариуд авах арга хэмжээг үнэлэх.
	(iii) Аудитыг мөрдвөл зохих аудитын стандарт, холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, баримтжуулсан эсэхийг үнэлэх.
	(iv) Тохирох аудитын дүгнэлт ба түүнд хамаарах аудитын тайлан гаргах, ингэхдээ аудитын гол асуудлыг тохирох хэмжээнд оруулах.
(б) Санхүүгийн нягтлан бодох бүртгэл ба тайлагнал	(i) Аж ахуйн нэгж санхүүгийн тайлангаа бүх материаллаг хүрээнд, мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал ба зохицуулагч байгууллагуудын шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн эсэхийг үнэлэх.
	(ii) Санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээний зөвшөөрөлт, толилуулга ба тодруулгыг мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал ба зохицуулагч байгууллагуудын шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн эсэхийг үнэлэх.
	(iii) Удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн шийдэл ба бодит үнэ цэнийн тооцооллыг үнэлэх.
	(iv) Санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхдээ бизнесийн онцлог, үйл ажиллагааны орчин, үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадвартай нь уялдуулан авч үзэх.
(в) Засаглал ба эрсдэлийн удирдлага	(i) Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд нөлөөлж байгаа байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн үнэлгээний үйл явцыг аудитын төлөвлөлтийн нэг хэсэг болгон

	үнэлэх.
(г) Бизнесийн орчин	(i) Зах зээл , өрсөлдөөн , бүтээгдэхүүний технологи, орчны шаардлага зэрэг аудитын эрсдэлийн үнэлгээг мэдээлэхэд ашигладаг, гэхдээ үүгээр үл хязгаарлагдах хамаарах салбар, зохицуулалт болон бусад гадаад хүчин зүйлсэд шинжилгээ хийх.
(д) Татвар	(i) Татвартай холбоотойгоор санхүүгийн тайланд илэрч болох материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлохын тулд гүйцэтгэсэн горим болон эдгээр горимуудын үр дүн нь аудитын ерөнхий стратегид нөлөөлөх нөлөөллийг үнэлэх.
(е) Мэдээллийн технологи	(i) Аудитын ерөнхий стратегид нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохын тулд санхүүгийн тайланд хамааралтай хяналтыг олж тогтоох мэдээллийн технологийн орчинд үнэлгээ хийх.
(ё) Бизнесийн эрх зүй ба зохицуулалтууд	(i) Аудитын ерөнхий стратеги ба аудитын дүгнэлтэд нөлөөлөх нөлөөллийг тогтоохын тулд илэрсэн эсвэл сэжиг бүхий хууль тогтоомжийн үл нийцлийг үнэлэх.
(ж) Санхүү ба санхүү менежмент	(i) Аудитын ерөнхий стратегид нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохын тулд байгууллагын санхүүжилтийн янз бүрийн эх үүсвэрийн бэлэн байдал ба ашигласан санхүүгийн хэрэглүүрүүдийг үнэлэх.
	(ii) Аудитын ерөнхий стратегид нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохын тулд байгууллагын мөнгөн гүйлгээ, төсөв, таамаглал, шаардлагатай ажлын капиталыг үнэлэх.
Мэргэжлийн Ур Чадварууд	
(з) Оюуны ур чадвар	(i) Ижил төстэй боломжуудыг харгалзан үзэж, тэдгээрийн үр дүнг шинжлэхийн тулд судалгаа/ лавлагаа, хийсвэрлэл, логик сэтгэлгээгээ ашиглан аудитын асуудлуудыг шийдэх.
(и) Хүмүүс хоорондын харилцаа, мэдээлэл солилцоо	(i) Гэрээт ажлын баг, гүйцэтгэх болон засаглах удирдлагын хүмүүстэй зүй зохистой, үр ашигтай мэдээлэл солилцох.
	(ii) Шаардлагатай тохиолдолд, аудитын асуудлыг үр өгөөжтэй хэлэлцэн зөвлөлдөх арга замаар шийдвэрлэх.
(й) Хувь хүний зан төлөв	(i) Насан туршдаа суралцах үйл явцыг дэмжиж, байнга суралцах.
	(ii) Гэрээт ажлын багт үлгэр дуурайлал үзүүлэх.
	(iii) Гэрээт ажлын багт чиглүүлэх буюу зааварлах үүрэг гүйцэтгэх.
(к) Зохион байгуулалт	(i) Аудитын шинжээчдээс бүрдсэн ажлын багнь хамтдаа аудитыг гүйцэтгэх бодит зорилготой бөгөөд чадавхтай эсэхийг үнэлэх.
	(ii) Гэрээт ажлын багийг манлайлал ба төслийн менежментээр ханган аудитын ажлыг удирдах.
(л) Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг	(i) Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахыг гол чиглэл болгож, бүх үйл ажиллагаанд аудитын чанарыг дэмжин ажиллах.
(м) Мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн шүүмжлэл	(i) Аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, мөн аудитын дүгнэлт гаргахдаа мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн шийдлээ ашиглах.
(н) Ёс зүйн зарчим	(i) Үнэнч шударга, бодитой байдал, мэргэжлийн чадавх ба хянамгай байдал, нууц хадгалалт, мэргэжлийн зан

	<p>төлөвт баримтлах ёс зүйн зарчмуудыг аудитын ажилд мөрдөж, ёс зүйн зөрчилтэй үйлдлийг зохих ёсоор шийдвэрлэх.</p>
	<p>(ii) Аудитын явцад бодитой байдал ба хараат бус байдалд тохиолдож болох аюул заналыг үнэлж, хариу арга хэмжээ авах.</p>
	<p>(iii) Ёс зүйн хариуцлага болон холбогдох хууль тогтоомжийн дагуу, байгууллагын мэдээллийн нууцыг чандлан хадгалах.</p>

Тайлбар Материал

АББОУС-ын Баримт Бичгийн Тунхаглалын Хүрэн дэх Тодорхойлолтын Лавлагаа (Лав: 5-р параграф)

А1. БОУС–д АБОУСЗ-ээс тодорхойлсон нэр томьёоноос дараах нэр томьёог ашиглаж байна³.

Хүснэгт Б: БОУС 8-д Ашигласан Тодорхойлолт

Тодорхойлсон Нэр Томьёо	Нэр Томьёоны Эх Сурвалж	Тодорхойлолтын Хэрэглээ
Аудиторын Шинжээч	АОУС 620 <i>Аудиторын шинжээчийн ажлыг ашиглах 6-р Параграф (а)</i>	Нягтлан бодох бүртгэл болон аудитаас бусад салбарт мэргэшсэн хувь хүн, эсвэл байгууллага бөгөөд тэдний тухайн салбарт хийж гүйцэтгэсэн ажил нь аудиторт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авахад нь тус дэм болохыг хэлнэ. Аудиторын шинжээч нь аудиторын дотоод шинжээч (аудиторын харьяалагдах компани эсвэл сүлжээ компанийн партнер, орон тооны ажилтан мөн түр ажилтан), эсвэл аудиторын гаднаас хөлсөлж авсан шинжээч байж болно.
Гэрээт Ажлын Партнер*	АОУС 220 <i>Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт 7-р Параграф (а)</i>	Аудитын ажил ба түүний гүйцэтгэл, мөн компанийн нэрийн өмнөөс гаргасан аудиторын тайланг хариуцдаг, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн, хуулийн эсвэл зохицуулах байгууллагаас зохих эрх мэдэл хүлээн авдаг компанийн партнер эсвэл компани дахь бусад хувь хүнийг хэлнэ.
Гэрээт Ажлын Баг	АОУС 220 <i>Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт 7-р Параграф (г)</i>	Тухайн гэрээт ажлыг гүйцэтгэж буй бүх партнер, ажилтнууд болон гэрээт ажилд аудитын горимуудыг гүйцэтгүүлэхээр уг компани эсвэл сүлжээний компанийн хөлсөлж авсан хувь хүмүүс. Үүнд тухайн компани эсвэл сүлжээ компанийн хөлсөөр ажиллуулж буй аудиторын гадаад шинжээчийг оруулдаггүй. Түүнчлэн, хөндлөнгийн аудитор нь АОУС 610 (2013 онд шинэчлэн найруулсан) ⁴ -ын шаардлагыг мөрддөг бол, үйлчлүүлэгчийн дотоод аудитын функцэд ажилладаг бөгөөд аудитын гэрээт ажилд шууд туслалцаа үзүүлж байгаа хувь хүмүүсийг “гэрээт ажлын баг” гэсэн нэр томьёонд багтаахгүй.

³ Дээр тодруулан авч үзсэн АОУС-ын нэр томьёог АБОУСЗ-ийн *Чанарын Хяналт, Аудит, Нягтлах Ажил, Бусад Баталгаажуулах ба Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Тунхаглалын Баримт Бичиг*- 2016-2017 оны хэвлэл, Боть 1-д тусгасан болно.

⁴ АОУС 610, *Дотоод Аудиторын Ажлыг Ашиглах нь*, (2013 онд шинэчлэн найруулсан).

Тодорхойлсон Нэр Томьёо	Нэр Томьёоны Эх Сурвалж	Тодорхойлолтын Хэрэглээ
Санхүүгийн Тайлан	АОУС 200 <i>Хараат бус аудиторын ерөнхий зорилго ба аудитыг АОУС-ын дагуу гүйцэтгэх нь</i> 13-р Параграф (е)	Санхүүгийн түүхэн мэдээллийн бүтэцчилсэн илэрхийлэл, үүнд холбогдох тодруулга хамаарах бөгөөд байгууллагын эдийн засгийн нөөц буюу үүрэг хариуцлагыг хугацааны тодорхой өдрөөр буюу тэдгээрийн тайлант хугацаан дахь өөрчлөлтийг санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын дагуу илэрхийлж, хэрэглэгчдэд хүргэх зорилготой. “Санхүүгийн тайлан” гэсэн нэр томьёо нь холбогдох санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын дагуу тодорхойлогдсон иж бүрэн санхүүгийн тайланд ихэвчлэн хамаардаг боловч мөн тусдаа санхүүгийн тайланг хамаарч болно. Тодруулгад, холбогдох санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалаар санхүүгийн тайлангийн нүүр ба тэмдэглэлийн хэсэгт эсвэл ишлэл байдлаар хавсаргахыг шаардсан болон зөвшөөрсөн тайлбар юм уу, тодорхойлолт хэлбэртэй мэдээлэл орно.
Компани*	АОУС 220 <i>Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт</i> 13-р Параграф (д)	Хувиараа биеэ даан ажилладаг мэргэжлийн нягтлан бодогч болон тэднээс бүрддэг нөхөрлөл, корпораци эсвэл бусад аж ахуйн нэгж.
Мэргэжлийн шийдэл/ үнэлэмж	АОУС 200 <i>Хараат бус аудиторын ерөнхий зорилго ба аудитыг АОУС-ын дагуу гүйцэтгэх нь</i> 13-р Параграф (м)	Аудитын гэрээт ажлын тухайн нөхцөл байдалд тохиромжтой бөгөөд үйл ажиллагааны талаарх мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргахдаа аудит, нягтлан бодох бүртгэл, ёс зүйн стандартын хүрээнд холбогдох сургалт, мэдлэг, туршлагаа ашиглахыг хэлнэ.
Мэргэжлийн үл итгэх үзэл	АОУС 200 <i>Хараат бус аудиторын ерөнхий зорилго ба аудитыг АОУС-ын дагуу гүйцэтгэх нь</i> 13-р Параграф (н)	Алдаа болон залилангийн улмаас буруу илэрхийлэл үүсэж болзошгүйг илтгэх нөхцөл байдалд сонор сэрэмжтэй хандан, аудитын нотлох баримтыг шүүмжлэлтэй үнэлэх гэх мэт эгзэгтэй үзэл бодлыг агуулсан байр суурь.
* “Партнер” болон “компани”-ийг улсын секторт ажилладаг тэдгээртэй ижил төстэй байгууллагад хамааруулан ойлгож, унших нь нь зүйтэй.		

Энэ Стандартын Цар Хүрээ (Лав: 1–5-р параграф)

- A2. Мэргэжлийн чадавхыг олон арга замаар тодорхойлон ангилж болно. БОУС-ын хүрээнд, мэргэжлийн чадавх гэдэг нь хариуцсан үүргээ тогтоосон стандартын дагуу гүйцэтгэх чадамж юм. Мэргэжлийн чадавх нь зарчим, стандарт, ерөнхий төсөөлөл, бодит байдал

- ба горимуудын талаарх мэдлэгээс давсан ойлголт бөгөөд үүнд: (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүй, хандлагын нэгдмэл байдал ба хэрэглээ багтдаг.
- A3. МТХ бол Мэргэжлийн Анхан Шатны Хөгжүүлэлт (МАШХ)-ийн үргэлжлэл юм. Хувь хүмүүст мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэж чадахуйц хэмжээнд анхны суурь чадавх эзэмшүүлэх замаар сургах болон хөгжүүлэх үйл явцыг МАШХ гэдэг. МТХ нь мэргэжлийн нягтлан бодогчид үүргээ чадвартайгаар биелүүлэхийн тулд мэргэжлийн чадвараа хадгалах, хөгжүүлэх МАШХ-ийн дараах үйл явц юм. Анхан шатны сургалтаас олж авсан (а) техникийн чадавх, (б) мэргэжлийн ур чадвар, (в) мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүй ба хандлагын талаарх мэдлэгийг мэргэжлийн үйл ажиллагаа ба мэргэжлийн нягтлан бодогчийн хариуцлагад зүй зохистой хэрэгжүүлж, сайжруулах боломжийг МТХ-ийн сургалтаар хангадаг.
- A4. БОУС 7–д зааснаар⁵, МТХ-ийн бүрэлдэхүүнд практик туршлага багтдаг. Гэрээт ажлын партнер өөрийн карьераа өсгөхийн хэрээр мэргэжлийн чадавхаа улам гүнзгийрүүлэн өргөжүүлэх замаар практик туршлага хуримтлуулах явдал илүү чухал болдог. Гэрээт ажлын партнер нь бие даан бөглөх жилийн тайлан, төлбөртэй үйлчилгээний цагийн бүртгэл, гүйцэтгэлийн үнэлгээ, гэрээт ажлын чанарын шалгалт, зохицуулагч байгууллагын хяналт зэрэг чанарын хяналт шинжилгээний үйл ажиллагааны үр дүнгээр өөрийн практик туршлагаа нотлох боломжтой.
- A5. Гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэхийн тулд, мэргэжлийн чадавх ба практик туршлагаас гадна, энэ БОУС-ын хамрах хүрэнээс ангид бусад хүчин зүйлсээр, тухайлбал, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн, хуулийн эсвэл зохицуулагч байгууллагаас мэргэжлийн нягтлан бодогч зохих зөвшөөрөл авсан эсэхийг тодорхойлдог.
- A6. Эрх зүйн зарим орчинд, чухам ямар хүн Гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэж болохыг хууль тогтоомжийн хүрээнд, эсвэл зохицуулагч байгууллага нь тогтоох буюу мөрдөн сахиулах (хамтад нь “лиценз олгох дэг журам” гэдэг)-аар заасан байдаг. Лиценз олгох дэг журам нь тавьж байгаа шаардлагын хувьд хоорондоо ялгаатай. Лиценз олгох үйл явц нь тухайн орон дахь ДНБХ-ны гишүүн байгууллагын эрх мэдлээс гадуур байвал, ГҮМ 2- *НБББОУСХ-ноос гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын боловсролын олон улсын стандарт ба бусад тунхаглалын баримт бичиг*⁶ тусгасны дагуу энэхүү БОУС-д заасан мэргэжлийн чадавхын шаардлагыг ДНБХ-ны гишүүн тухайн байгууллага өөрөө хангаж байхуйц хэмжээнд лиценз олгох дэг журамд нөлөөлөх оролдлогыг хамгийн дээд боломжоор хийх ёстой
- A7. Компани гэдэг тодорхойлолтод хувиараа мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийг ч багтаах бөгөөд компани нь хэнээр өөрийн компанийг хууль ёсоор төлөөлүүлэн аудитын дүгнэлт гаргахыг шийддэг. Ихэнх компани нөхөрлөлийн бүтэцтэй бөгөөд нөхөрлөл дэх гишүүд /партнер/ нь нөхөрлөл дотроос хэнээр Гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгүүлэхээ шийддэг.
- A8. Зураг 1-д, Гэрээт ажлын партнерийн мэргэжлийн чадавхад нөлөөлдөг оролцогч талуудыг харуулсан болно. Оролцогч талуудын хоорондын харилцаа нь тухайн хууль эрх зүйн орчин болон АБОУСЗ ба НБББОУСЗ-ийн баримт бичгүүдэд тодорхойлсон

⁵ БОУС 7, *Мэргэжлийн тасралтгүй хөгжил* (2014), 5-р параграфыг харна уу.

⁶ Гишүүний үүргийн мэдэгдэл 2- *НБББОУСХ-оос гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын боловсролын олон улсын стандарт ба бусад тунхаглалын баримт бичиг* НБББОУСХ-ны баталсан олон улсын стандарт ба бусад тунхаглалтай холбогдуулан ДНБХ-ны гишүүн байгууллагуудын биелүүлэх шаардлагыг дурдсан байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын стандарт ба удирдамжийг нэвтрүүлэх болон хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг дангаараа болон бусадтай хамтран хүлээдэггүй тохиолдлыг энэхүү ГҮМ (9-р параграф)-д онцлон авч үзсэн байдаг.

шаардлагууд, мөн ДНБХ-ны тунхаглалд дурдсан үүрэг хариуцлагын үр дагавраас хамааралтай байдаг.

- A9. БОУС 7-ийн⁷ дагуу, НБОУХ-ны гишүүн байгууллагууд мэргэжлийн үүрэг хариуцлага болон өөрийн гүйцэтгэж буй ажлаа зохистой явуулахад шаардлагатай мэргэжлийн чадварын хөгжүүлэлт болон хадгалалтад хувь нэмэр оруулах үүднээс тасралтгүй боловсролын сургалтад бүх мэргэжлийн нягтлан бодогчид хамрахыг шаарддаг.

Зураг 1: Гэрээт Ажлын Партнерийн Мэргэжлийн Чадавхад Нөлөөлдөг Оролцогч Талууд



- A10. БОУС 7-д⁸, МТХ-ийн талаар ДНБХ-ны гишүүн байгууллагын тавьдаг шаардлагыг мэргэжлийн нягтлан бодогчид хангаж байгаа эсэхийг хянах системтэй үйл явцтай байхыг ДНБХ-ны гишүүн байгууллагуудаас шаарддаг.
- A11. Гэрээт ажлын баг болон гэрээт ажлын бүрэлдэхүүнд багтаагүй аль нэг аудиторын экспертүүд нь хамтдаа зохих чадавх ба чадамжтай эсэх талаар гэрээт ажлын партнерын хүлээх хариуцлагыг АОУС 220-д⁹ тодорхойлсон байдаг. Пүүс эсвэл бусад талаас ирүүлсэн мэдээлэлд өөрөөр дурдаагүй бол, гэрээт баг нь пүүсийн ажилд авах болон албан ёсны сургалтаар дамжуулан хувь хүний чадвартай холбоотой пүүсийн чанарын хяналтын системд найдаж болохыг АОУС 220-д¹⁰ заасан байдаг.
- A12. ЧХОУС 1¹¹-д, компаниуд нь (а) мэргэжлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх, (б) тухайн нөхцөл байдалд тохирох аудитын тайлан гаргах боломжийг компани ба гэрээт ажлын партнерт олгохуйц чадавх, чадамжтай бөгөөд ёс зүйн зарчмыг сахин мөрдөх хангалттай тооны ажилтантай гэсэн үндэслэлтэй баталгаагаар хангах бодлого, горимтой байхыг компаниудаас шаарддаг.
- A13. Хууль эрхзүйн дийлэнх орчны хувьд, зохицуулагч байгууллагууд нь ДНБХ-ны гишүүн байгууллага, компани, гэрээт ажлын партнертай холбоотой хөндлөнгийн хяналтын үүрэг гүйцэтгэдэг.

⁷ БОУС 7, Мэргэжлийн тасралтгүй хөгжил (2014), 12-р Параграфыг харна уу.

⁸ БОУС 7, Мэргэжлийн тасралтгүй хөгжил (2014), 17-р Параграфыг харна уу.

⁹ АОУС 220, Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт, 14-р Параграфыг харна уу.

¹⁰ АОУС 220, Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт, А2-р Параграфыг харна уу.

¹¹ ЧУОУС 1 “Санхүүгийн тайлангийн аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний гэрээт ажил гүйцэтгэдэг компаниудын чанарын хяналт”, 29-р параграфыг харна уу.

A14. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь энэхүү БОУС-ын шаардлагад нийцүүлэх, ГҮМ 1¹² ба ГҮМ 2¹³-д заасан үүргээ биелүүлэх замаар ЧХОУС 1-ийн шаардлагыг хангахад нь компаниудад, мөн АОУС 220-ийн шаардлагыг хангахад нь гэрээт ажлын партнерүүдэд тус тус туслалцаа үзүүлдэг. Эдгээр тунхаглал нь нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг гэрээт ажлын партнер ба гэрээт ажлын багт шаардагдах мэргэжлийн чадавхтай холбоотой ил тод байдал ба тууштай байдлыг цогцоор нь сайжруулдаг.

Мэргэжлийн Чадавхыг Илтгэх Сайн Шинж Чанар

A15. Зөвхөн Хүснэгт А-д жагсаасан сургалтын үр дүнд хүрснээр мэргэжлийн чадавхаа хөгжүүлэн, хадгалж буй мэргэжлийн нягтлан бодогчид л гэрээт ажил гүйцэтгэх явцад тулгарч болох төвөгтэй асуудлуудыг амархан шийдвэрлэдэг. Гэрээт партнер болох хүсэлтэй мэргэжлийн нягтлан бодогчид нэлээн хэдэн жил гэрээт ажлын багт ажиллан, туршлага хуримтлуулснаар гэрээт ажлын партнерийн хяналтын дор, хяналт ба удирдлагын үүрэг гүйцэтгэн дэвшиж ажиллах боломжтой. Мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг хариуцлага нэмэгдэхийн хэрээр Гэрээт ажлын партнер болох түүний боломж ихсэж байдаг. Гэрээт ажлын партнераар ажиллаж байгаа хүмүүс аудитын гэрээт ажил удирдах эсвэл гүйцэтгэх явцдаа болон МТХ-ийн сургалтын үйл ажиллагааны дагуу мэргэжлийн чадвараа хөгжүүлж, бас хадгалж байдаг.

Санхүүгийн Тайлангийн Аудит ба Баталгаажуулалтын Бусад Үйл Ажиллагаа

A16. Энэхүү БОУС-ыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан гэрээт ажлын партнер дагаж мөрдөнө. Хүснэгт А-д жагсаасан сургалтын үр дүнгээр илэрхийлэгдэх мэргэжлийн чадавх нь АОУС-уудад нийцүүлэн бусад түүхэн санхүүгийн мэдээллийн аудит эсвэл бусад төрлийн баталгаажуулах ба холбогдох үйлчилгээ үзүүлэхэд мөн тус нэмэртэй байдаг. Үүний нэгэн адил, санхүүгийн тайлангийн аудит хийхэд шаардагдах мэргэжлийн чадавхын ихэнх нь хүрээлэн байгаа орчин эсвэл нийгэмд чиглэсэн арга хэмжээ гэх мэт санхүүгийн бус тайлангийн мэдээлэлтэй холбоотой баталгаажуулах гэрээт ажил хариуцсан партнерүүдэд хамаатай байж болох юм.

Зорилго (Лав: 7-р параграф)

A17. Мэргэжлийн нягтлан бодогч гэрээт ажлын партнерийн үүрэг гүйцэтгэх явцдаа хөгжүүлэн хадгалах мэргэжлийн чадавх бий болгох нь хэд хэдэн зорилготой юм. Эдгээр нь, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах; аудитын чанарыг дээшлүүлэх; Гэрээт ажлын партнерүүдийн ажлын хүрээг өргөжүүлэх; аудитын мэргэжилд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг болно.

A18. Энэхүү БОУС-д гэрээт ажлын партнер нь үүргээ биелүүлэхэд шаардагдах мэргэжлийн чадавхыг аль хэдийн эзэмшсэн байх ёстой гэж шаарддаг хэдий ч тэрээр байнга хувьсан өөрчлөгддөг орчинд ажилладаг хүмүүс юм. Байнга өөрчлөгдөж байх дарамт шахалт дараах олон шалтгаанаас үүдэлтэй боловч үүгээр бас хязгаарлагддаггүй, үүнд (а) зохицуулах байгууллагуудын шаардлага нэмэгдэх, (б) санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын хөгжил, (в) шинэ технологи (г) бизнесийн шинжилгээг ашиглах

¹² Гишүүний үүргийн мэдэгдэл 1- Санхүүгийн тайлангийн аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний гэрээт ажил гүйцэтгэдэг гишүүдийнхээ чанарын баталгаажуулалтыг хянах тогтолцооны хувьд, ДНБХ-оос гишүүн байгууллагуудад тавьдаг шаардлагыг *Чанарын баталгаажуулалтад* тодорхойлсон байна. ДНБХ-ны гишүүн байгууллага нь чанарын баталгаажуулалтыг хянах дүрэм, журам тогтоох, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг дангаараа болон бусадтай хамтран хүлээдэггүй тохиолдлыг энэхүү ГҮМ-д онцгойлон дурдсан байдаг.

¹³ Гишүүний үүргийн мэдэгдэл 2- *НБББОУСЗ-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын боловсролын олон улсын стандарт ба бусад тунхаглалын баримт бичигт* НБББОУСЗ-ийн баталсан олон улсын стандарт ба бусад тунхаглалтай холбогдуулан ДНБХ-ны гишүүн байгууллагуудын биелүүлэх шаардлагыг дурдсан байдаг. ДНБХ-ны гишүүн байгууллага нь мэргэжлийн нягтлан бодох бүртгэлийн боловсролын стандарт ба удирдамжийг нэвтрүүлэх болон хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг дангаараа болон бусадтай хамтран хүлээдэггүй тохиолдлыг энэхүү ГҮМ-д онцгойлон дурдсан байдаг.

шаардлага ихсэх, (д) бизнесийн нарийн төвөгтэй байдал. Өөрчлөлт нь карьерын туршид мэргэжлийн чадавхаа хөгжүүлж байхыг гэрээт ажлын партнераас шаарддаг.

Шаардлага (Лав: 8-9-р параграф)

- A19. Хүснэгт А-д техникийн чадавх, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүй, хандлагатай холбоотой сургалтын үр дүн болон чадвар шаардах асуудлуудыг тодруулсан болно. Чадвар шаардах асуудал гэдэг нь холбогдох сургалтын цогц үр дүнг тодорхойлж болох категори юм.
- A20. Чадавх тус бүрийн хувьд шаардагдах мэдлэг, ойлголт, хэрэглээний агуулга ба далайцыг сургалтын үр дүнгээр бий болгодог. Сургалтын үр дүнгийн ололт амжилт бол МТХ-ийг хэмжих гарцад суурилсан арга юм. МТХ-ийг хэмжихтэй холбоотой удирдамжийг БОУС 7-д дурдсан болно.
- A21. БОУС 2, 3, 4-д¹⁴ заасны дагуу, МАШХ-ийн эцэст мэргэжлийн нягтлан бодогч болохыг эрмэлзэгчээс шаардах мэргэжлийн чадавхыг тодорхойлдог сургалтын үр дүнд тулгуурлан энэхүү БОУС-ыг гаргасан болно.
- A22. Хүснэгт А-д харуулсан сургалтын үр дүнгээс гадна бусад хүчин зүйлс нь төлөвлөсөн МТХ-ийн шинж чанар, хугацаа, далайцад нөлөөлж болно. Эдгээр хүчин зүйлсэд (а) Гэрээт ажлын парьнерын аудитын ажлын багц, (б) аудит болон санхүүгийн тайлангийн стандартуудын өөрчлөлтийн хэр хэмжээ, (в) Хүснэгт А-д тэмдэглэсэн бусад чадавхын агуулгад гардаг өөрчлөлтийг дурдаж болох авч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.
- A23. Аудитын ажлын хэмжээ эсвэл шинж чанар болон аудит хийж байгаа гэрээт ажлын партернын компаниас үл хамааран, гэрээт ажлын партернаар ажиллаж байгаа аудитын ажлын ярвигтай байдалд тохирохуйц МТХ-ийн үйл ажиллагаанд гэрээт ажлын партерн үргэлжлүүлэн сурах шаардлагыг энэхүү БОУС-аар тавьдаг.
- A24. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь энэхүү БОУС-д дурдаагүй нэмэлт мэргэжлийн чадавх шаардах эсвэл гэрээт ажлын партерныг бусад нэмэлт сургалтад хамрагдсан байхыг шаардаж болно. Жишээлбэл, Гэрээт ажлын партерн тусгай зориулалтын салбар буюу ажил гүйлгээнд аудит хийж байх үед ийм тохиолдол гарч болно.

Бие Даан Үйлчилгээ Үзүүлдэг Хувь Хүн болон Жижиг, Дунд Аудитын Компани

- A25. Гэрээт баг эсвэл компанийн бүтцээс өөр онцгой үүрэгт анхаарал хандуулах замаар, энэхүү БОУС-д гэрээт ажлын партерн нь бие даан үйлчилгээ үзүүлдэг хувь хүн эсвэл жижиг, дунд аудитын компанийг оролцуулан үйл ажиллагаа явуулах тохиолдол олон байдгийг хүлээн зөвшөөрсөн байна.¹⁵ Энэ тохиолдолд, гэрээт ажлын партерн нь мэргэжлийн тусгай ур чадвар бүхий ажлын багийн тусламжгүйгээр ажиллаж болно. Үүний үр дүнд, гэрээт ажлын партерн бусад тохиолдолд үүсэхгүй байж болох хэмжээнд, аудитын үйл ажиллагааг дуусгавар болгоход ихээхэн шууд оролцоотой байж болно.

Аудит-Сургалтын Үр Дүн

- A26. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг үнэлэх ба илрүүлэхдээ дараахыг харгалзана:

¹⁴ БОУС 2, *Мэргэжлийн анхан шатны хөгжил- Техникийн чадавх* (2015);
 БОУС 3, *Мэргэжлийн анхан шатны хөгжил- Мэргэжлийн ур чадвар* (2015);
 БОУС 4, *Мэргэжлийн анхан шатны хөгжил- Мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүй, хандлага* (2015).
¹⁵ Дэлхийн нягтлан бодогчдын холбооны Жижиг, дунд аудитын компани хариуцсан хорооны баримт бичигт ЖДАК-ийг дараах байдлаар тодорхойлсон байна: "... компани гэж дараах шинжийг агуулсан аж ахуйн нэгжийг хэлнэ: үйлчлүүлэгчдийн дийлэнх нь жижиг, дунд аж ахуйн нэгж (ЖДААН) байдаг; байгууллагын дотоод дахь техникийн хязгаарлагдмал нөөцийг гадаад эх үүсвэрээс бүрдүүлдэг; цөөн тооны мэргэжлийн албан хаагч ажиллуулдаг."

- Гэрээт ажлыг хүлээн зөвшөөрч, горимуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэх үед олж тогтоосон эрсдэл;
- Аж ахуй нэгжийн тасралтгүй байх зарчим;
- Алдаа ба залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэл.

A27. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд авах хариу арга хэмжээг үнэлэхдээ аудитын ерөнхий стратегийг боловсруулах ба батлах зэрэг үйл явцыг хамардаг.

A28. Аудитыг холбогдох стандарт, хууль журам, зохицуулалтад нийцүүлэн хийж гүйцэтгэсэн эсэхийг үнэлэхдээ:

- Олж авсан аудитын нотолгоо болон бусад холбогдох баримтууд нь зохистой, хангалттай эсэхийг үнэлэх
- Дотоод хяналтад учирч буй томоохон дутагдал болон нэр бүхий албан тушаалтанд хүргэх бусад асуудалд анхаарах
- Удирдлага нь тооцоолол хийх болон бусад шийдэлд өрөөсгөл хандсан эсэхийг олж тогтоох.

Бүтэц Зохион Байгуулалт-Сургалтын Үр Дүн

A29. Аудитад аудиторын шинжээчийг ашиглаж болох талбарын жишээ нь, татварын систем, мэдээлэл технологи, хууль эрхзүй, шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадлан, үнэлгээ, актуарын үйлчилгээ, тэтгэвэр байж болох авч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

Мэргэжлийн Үл Итгэх Үзэл ба Мэргэжлийн Шийдэл-Сургалтын Үр Дүн

A30. Аудитын гол санаа нь аудитор дүгнэлт гаргахдаа уг дүгнэлтийг дэмжих зохистой бөгөөд хангалттай аудитын нотлох баримтууд олж авсан эсэхийг үнэлэх юм. Мэргэжлийн үл итгэх үзэл нь оюун ухаандаа аудитын нотолгоонд шүүмжлэлтэй хандах явдал юм. АОУС –уудад гэрээт ажлын партнер ба тэдний багт санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх болон төлөвлөх явцад мэргэжлийн шийдлээ ашиглахыг шаарддаг. Санхүүгийн тайланд тусгагдсан удирдлагын батламж мэдэгдэл ба төсөөлөлд эргэлзэх, аж ахуй нэгж нягтлан бодох бүртгэлийн стандартыг зохих ёсоор дагаж мөрдсөн эсэх, аудитын ерөнхий стратегийг тодорхойлох зэрэг үед мэргэжлийн шийдэл гүйцэтгэх нь зүйтэй.

A31. Мэргэжлийн үл итгэх үзэл болон мэргэжлийн шийдлийн хүрээнд МТХ-ийг үр ашигтай төлөвлөхийн тулд хянамгай хандах бөгөөд чиглүүлэх буюу зааварлах, хариу үйл ажиллагаа, практик туршлага үүнд гол үүрэг гүйцэтгэсэн байхуйц сургалтын холимог аргыг авч үзнэ.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь Дэлхийн нягтлан бодогчдын холбоо (ДНБХ)-оос 2017 оны 2 дугаар сард англи хэл дээр хэвлэн нийтэлсэн Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Стандартын Зөвлөл (НБББОУСЗ)-ийн “Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага 2017”-г 2019 оны 12 дугаар сард монгол хэл рүү хөрвүүлэн, ДНБХ-ны зөвшөөрлийн дагуу хэвлэж байна. ДНБХ нь *Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага 2017*-г орчуулах ажлын үйл явцыг анхаарч үзсэн бөгөөд энэхүү ажил нь “Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны Бодлогын Мэдэгдэл - Баримт Бичгийн Орчуулгад Мөрдөх Бодлого”-д нийцүүлэн хийгдсэн болно. *Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага 2017*-ийн батлагдсан бүх бичвэр нь ДНБХ-оос англи хэл дээр хэвлэн гаргасан бичвэр мөн болно. Уг орчуулгын үнэн зөв, бүрэн гүйцэт байдал, эсвэл эдгээрээс үүдэн гарч болох аливаа үйлдэлд ДНБХ хариуцлага хүлээхгүй.

Handbook of International Education Pronouncements © 2017 англи хэл дээрх бичвэрийг ДНБХ эзэмшинэ. Бүх эрхийг хуулиар хамгаална.

Нягтлан Бодох Бүртгэлийн Боловсролын Олон Улсын Тунхаглалын Гарын Авлага © 2019 монгол хэл дээрх бичвэрийг ДНБХ эзэмшинэ. Бүх эрхийг хуулиар хамгаална.

Эх бичвэрийн нэр: *Handbook of International Education Pronouncements, 2017 Edition*
ISBN: 978-1-60815-316-9

Энэ баримт бичгийг дахин хэвлэх, хадгалах буюу дамжуулах, эдгээртэй ижил төстэй бусад зорилгоор ашиглах зөвшөөрөл хүсэх бол permissions@ifac.org хаягаар холбогдоно уу.



International
Federation
of Accountants®

529 Fifth Avenue, New York, NY 10017
T +1 (212) 286-9344 F +1 (212) 286-9570
www.ifac.org
ISBN: 978-1-60815-316-9